



"МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН
НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" НҮБ-ЫН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН БИЕТ ОРЧИН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ
БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР



2021 он

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын тэргүүлэх агентлаг юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

НҮБ-ын Хүүхдийн Сан дэлхийн 190 орон тэдгээрийн дотор Монголд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйлсэд тэргүүлэгч дэлхий хэмжээний байгууллага юм.

НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сан

НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сан нь улс орнуудад ТХЗ-д хүрэх ахиц дэвшлийг хурдасгаж, 2030 он хүртэл хэнийг ч орхигдуулахгүй байх амлалтаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, урт хугацааны тогтвортой байдлын шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлэхэд түлхэц болох арга хэрэгслээр НҮБ-ын Суурин зохицуулагчид болон НҮБ-ын багийг хангаж ажилладаг билээ.

Ерөнхий мэдэгдэл:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр эрхлэн хэвлүүлэв.

Энэхүү хэвлэлд дурдсан материал нь НҮБХХ эсхүл Засгийн Газрын байр суурийг илэрхийлээгүй болно. Тус хэвлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчийнх бөгөөд хамтран хэвлүүлсэн байгууллагуудын үзэл баримтлал, бодлогыг төлөөлөхгүй. Судалгаанд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт хамтран хэвлүүлсэн байгууллагууд хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү баримт бичигт дурдсан аливаа бүс нутаг, засаг захиргааны нэгж, "улс орон"-ын талаар хэвлэн нийтэлсэн байгууллагуудын зүгээс ямар нэг байдлаар шүүмж өгөх, тэдгээрийн эрх зүйн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилго агуулаагүй болно.

© 2021 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан.

НҮБХХ-өөс зохих ёсны зөвшөөрөл авсан тохиолдолд тус судалгаа, тайланг хувийн болон арилжааны бус зорилгоор хэвлэх эсвэл хуулбарлахыг зөвшөөрнө. НҮБХХ-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор худалдах, түгээх, дуурайлган хэвлэхийг хориглоно.

Ишлэл хийх санал: А.Заяадэлгэр. (2021). Сургалтын биет орчин, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах зөвлөмж. НҮБХХ. Улаанбаатар, Монгол Улс.

Зөвлөх: А.Заяадэлгэр (БШУ-ны Яаман дээрх зөвлөх)

Чимэглэл зураг: <https://unsplash.com/>, <https://www.istockphoto.com/>

Та дараах хаягаар орж тус тайлантай танилцах боломжтой:
<http://mn.undp.org>

Та бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Гудамж -14

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201

Монгол Улс

Утас: + 976-11-327585



"МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН
НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" НҮБ-ЫН ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН БИЕТ ОРЧИН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ
БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР





АГУУЛГА

ЗУРАГ	iv
ХҮСНЭГТ	v
ЖИШЭЭ	vi
САНАЛ	1
1. БОЛОВСРОЛЫГ ТӨЛӨВЛӨХ	6
1.1 ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ХАНДЛАГА	6
1.2 РЕФОРМ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ	9
1.2.1 Идэвхтэй, хамтран суралцах орчин бүрдүүлэх	10
1.2.2 Хүн-төвт дизайн гаргах	12
1.2.3 Суралцахуйг баяжуулах хэрэгсэл ашиглах боломж бүрдүүлэх	13
1.3 ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ	18
1.3.1 Сургуулийн хэмжээ	20
1.3.2 Хоёр ээлжээр хичээллэх	25
1.3.3 Бүлэг дүүргэлт, багш-суралцагчийн тооны харьцаа	28
1.3.4 Хамран сургах тойрог болон сонголт	32
1.3.5 Суурьшлын ялгаа	33
1.3.6 Ирээдүйн хэрэгцээг таамаглах	38
1.4 ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ-ШИЙДЭЛ	41
1.4.1 Тэнцвэрийг хангах	41
1.4.2 Сургуулийн зураглал хийж дахин зохион байгуулах	42
1.4.3 Ялгаа үүсгэх хүчин зүйл дээр ажиллах	46
1.4.4 Сургуулиудын дунд хамтын ажиллагаа, сүлжээ үүсгэх	49
1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах	54
1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах	54
1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах	54
1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах	54
1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах	54
1.4.6 Хэвтээ, босоо чиглэлийн шилжилтүүд дээр анхаарлаа хандуулах	55
2. Хөрөнгийн санхүүжилт	56
2.1 Санхүүжилтийн хүрээ	61
2.2 Зарим арга хэмжээний санхүүжилт	68
3. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх	73
3.1 Ерөнхий боловсрол	74
3.1.1 Эрэлт, нийлүүлэлтийг таамаглах	75
3.1.2 Сургалтын биет орчны өнөөгийн байдлыг тодорхойлох	84
3.1.3 Жишээ: Дорноговь аймгийн ерөнхий боловсрол	93
3.1.4 Дотуур байрны үйлчилгээ	101
3.2.1 Эрэлт, нийлүүлэлтийг таамаглах	105
3.2.2 Цэцэрлэгийн биет орчны өнөөгийн байдлыг тодорхойлох	115
3.2.3 Жишээ: Дорноговь аймгийн сургуулийн өмнөх боловсрол	119
ХАВСРАЛТ	126
ХАВСРАЛТ 1. Ерөнхий боловсролын сургалтын болон сургуулийн биет орчны шалгуур үзүүлэлт (KPIs)	127
ХАВСРАЛТ 2. Цэцэрлэгийн биет орчны шалгуур үзүүлэлт (KPIs)	217
ХАВСРАЛТ 3. Дотуур байрны орчны шалгуур үзүүлэлт (KPIs)	222
ХАВСРАЛТ 4. Дорноговь аймгийн сургуулийн биет орчны шалгуур үзүүлэлт (KPIs)	223
ХАВСРАЛТ 5. Аймаг, нийслэлийн хүн амын тоо, 2015-2045 он	238
Ашигласан материал	239



ЗУРАГ

Зураг 1.1 Төрийн өмчийн бага, дунд сургуулиудын элсэлтийн тархалт	22
Зураг 1.2 ЕБС-ийн элсэлтийн тархалт	23
Зураг 1.5 Дундаж бүлэг дүүргэлт	29
Зураг 1.6 Бүлэг дүүргэлтийн тархалт	30
Зураг 1.8 Бүлэг дүүргэлт, сурагч-багшийн тооны харьцааны хамаарал (ПИСА 2018)	31
Зураг 1.9 Хувийн сургуулийн байршил	36
Зураг 1.10 Нийслэл дэх сургуулиудын байршил	37
Зураг 2.1 Хөрөнгө оруулалтын төсвийн хэсэг /2019/	63
Зураг 2.2 ЕБ-ын хамран сургалт болон хөрөнгө оруулалт	66
Зураг 2.3 Цэцэрлэгийн хамран сургалт болон хөрөнгө оруулалт	67
Зураг 3.1 Сургуулийн насны тооцсон хүн ам	76
Зураг 3.2 Хүчин чадал ашиглалтын харьцуулалт	80
Зураг 3.3 Төрийн өмчийн нэг сургуульд 2025 онд ногдох сургуулийн насны хүн ам	81
Зураг 3.4 Орчин 1. Сургалтын нэг компьютерыг ашиглаж буй суралцагчдын тоо	89
Зураг 3.5 Орчны шалгуур үзүүлэлт 2 болон 3-ын өнөөгийн байдал /2021/	90
Зураг 3.6 Орчин 4. Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	91
Зураг 3.7 Орчин 5. Хүчин чадал ашиглалт	92
Зураг 3.8 Дундаж бүлэг дүүргэлт	92
Зураг 3.9 Дорноговь аймгийн сургуулийн насны хүн ам болон элсэлтийн таамаглал	96
Зураг 3.10 Математикийн хичээлийн суурь чадвар эзэмшсэн байдлын тархалт /9-р анги/	97
Зураг 3.11 ЕШ-ын хэмжээст онооны дундаж /2019-2020/	98
Зураг 3.12 Хамран сургалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ	106
Зураг 3.13 Цэцэрлэгийн насны тооцсон хүн амын төлөв	107
Зураг 3.15 Хамран сургалт 89.4% байх үеийн хүчин чадал ашиглалт /3-5 нас/	113
Зураг 3.16 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгт нэмэгдэх элсэлт	114
Зураг 3.17 Салбарын хамран сургалт 89.4% байх үеийн хүчин чадал ашиглалт /2-5 нас/ ...	115



ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1 Багшлахуйн загвар, түүнд хэрэгтэй суралцахуйн биет орчин	10
Хүснэгт 1.2 Суралцахуйн орон зайн онцлог	14
Хүснэгт 1.3 Австри улсын сургалтын орчныг шинэчлэх “Үндэсний хөтөлбөрүүд”	16
Хүснэгт 1.4 Дундаж болон хамгийн бага элсэлт	21
Хүснэгт 1.4 ХЧА 1-ээс бага боловч 2 ээлжээр хичээллэж буй сургуулиуд	26
Хүснэгт 1.6 АНУ-ын төрийн өмчийн сургуулиудын хүчин чадлын үзүүлэлт	27
Хүснэгт 1.7 Эстони улсын ахлах сургуулийн хэмжээ болон бүлэг дүүргэлт	28
Хүснэгт 1.9 Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг	38
Хүснэгт 2.1 Цалин хөлснөөс бусад урсгал болон хөрөнгийн зардал	56
Хүснэгт 2.2 Монгол улсын ерөнхий боловсролын зардал	56
Хүснэгт 2.3 Хуваарилалтын механизм	57
Хүснэгт 2.4 Хэмжээг тооцох арга	57
Хүснэгт 2.5 Хөрөнгийн санхүүжилтийн жишээ	58
Хүснэгт 2.6 Монгол улсын практик	59
Хүснэгт 2.7 ЕБ-ын 2016-2019 онуудын хөрөнгө оруулалт /төг/	63
Хүснэгт 2.8 СӨБ-ын 2016-2019 оны хөрөнгө оруулалт /төг/	64
Хүснэгт 2.9 Хөрөнгө оруулалтын нэгтгэл	64
Хүснэгт 2.10 2016-2019 оны хөрөнгө оруулалтын тэгш байдлын үзүүлэлт	67
Хүснэгт 2.11 Лабораторийн хөрөнгө оруулалт	69
Хүснэгт 2.12 Компьютерийн хангамж	72
Хүснэгт 3.1 Хөрөнгө оруулалт төлөвлөх зарим арга хэмжээ	74
Хүснэгт 3.2 “Үндсэн чиглэл”-ийн үр дүнгийн шалгуур	74
Хүснэгт 3.3 Засгийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	75
Хүснэгт 3.4 2021-2022 оны хичээлийн жилийн хүчин чадал	77
Хүснэгт 3.5 2020-2021 оны хичээлийн жилийн үзүүлэлт	78
Хүснэгт 3.6 2024-2025 оны хичээлийн жилийн үзүүлэлтийн төсөөлөл	79
Хүснэгт 3.7 Танхимын багтаамжийг тооцох жишээ	81
Хүснэгт 3.8 Сургалтын танхимаар хүчин чадлыг тооцох жишээ	82
Хүснэгт 3.9 ХЧА-ын үнэлгээний шалгуур	83
Хүснэгт 3.10 Салбарын хүчин чадал /2020-2021/	83
Хүснэгт 3.11 Сургалтын биет орчинг үнэлэх үзүүлэлт	85
Хүснэгт 3.12 ХО-ын төсвийн үр дүнг хэмжих үзүүлэлт	86
Хүснэгт 3.13 Сургуулийн барилгын өнөөгийн байдал	93
Хүснэгт 3.14 Дорноговь аймгийн сургуулийн насны хүн ам болон элсэлтийн таамаглал	93
Хүснэгт 3.15 Ерөнхий боловсролын үзүүлэлт, 2021 оны байдлаар	94
Хүснэгт 3.16 Ялгаатай аргаар тооцсон хүчин чадал ашиглалтын үзүүлэлт	95
Хүснэгт 3.17 ДГ-аймгийн ХО-ын үр дүнг хэмжих үзүүлэлт	98
Хүснэгт 3.19 Өргөтгөх шаардлагатай сургуулийн мэдээлэл	99
Хүснэгт 3.20 Судлах, шийдвэрлэх асуудал	100
Хүснэгт 3.21 Сургуулийн биет орчныг үнэлэх үзүүлэлт	100
Хүснэгт 3.22 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт	101
Хүснэгт 3.23 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт	102
Хүснэгт 3.24 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт /2020-2021/	103
Хүснэгт 3.25 Үндэсний түвшинд хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	105
Хүснэгт 3.26 СӨБ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	107
Хүснэгт 3.27 Цэцэрлэгийн насны тооцоолсон хүн ам	108
Хүснэгт 3.28 Цэцэрлэгийн насны хүн амын таамаглал	108
Хүснэгт 3.29 Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын үзүүлэлт	110
Хүснэгт 3.30 Төрийн өмчийн цэцэрлэгийн хүчин чадал /2021-2022/	111
Хүснэгт 3.31 Төрийн өмчийн цэцэрлэгийн нэмэгдэх элсэлтийн таамаглалын хувилбар	112
Хүснэгт 3.33 Хүчин чадал ашиглалт, хэрэгцээг харуулах үзүүлэлт	116
Хүснэгт 3.34 Викториа мужийн СӨБ-ын хөрөнгийн санхүүжилт	118
Хүснэгт 3.35 Тооцсон хүн ам	120



Хүснэгт 3.36 2020-2021 оны хичээлийн жилийн үзүүлэлт	120
Хүснэгт 3.37 Хүчин чадал ашиглалт	121
Хүснэгт 3.38 Хүчин чадал ашиглалт болон дундаж бүлэг дүүргэлт	122
Хүснэгт 3.39 Дорноговь аймгийн цэцэрлэгийн барилга	122
Хүснэгт 3.41 Дорноговь аймгийн СӨБ-ын шийдэх асуудлын тоо	125

ЖИШЭЭ

Жишээ 1. Орон нутгийн, алслагдсан сургуульд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх Чили улсын туршлага	42
Жишээ 2. Сургуулиудыг дахин зохион байгуулсан солонгос улсын туршлага	43
Жишээ 3. Эстони улсад ахлах сургуулиудыг дахин төвлөрүүлж, нэгтгэсэн тухай	45
Жишээ 4. Мэриландын Монтгломер мужийн тэгш хамруулах бүсчлэл хөтөлбөр	47
Жишээ 5. Лондонгийн сорилт	48
Жишээ 7. Эстони улсын бүсийн зөвлөгөө өгөх төв	52
Жишээ 8. Португал улсад хэрэгжсэн кластерийн төсөл	53
Жишээ 9. Канад улсын Онтарио: холимог сургалт, МХХТ ашиглах стратеги	54
Жишээ 10. Барилгын хэрэглээг үнэлэх Бельги улсын туршлага	60



САНАЛ

АСУУДАЛ 1. Сургалтын дизайнд (Instructional design) сургалтын биет орчныг тохируулах яаралтай хэрэгцээ, шаардлага үүссэн байна.



Шийдлийн санал:

- Өнөөгийн сургууль, цэцэрлэгийн биет орчны зохион байгуулалт (Layout), тоног төхөөрөмжийг багш, суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэхийн тулд шинээр **өрсөлдөөнт грант хэлбэрийн санхүүжилт** ашиглаж болно. Бусад улсын туршлагаас харахад өрсөлдөөнт санхүүжилт нь цэцэрлэг, сургуулийн хамт олон сургалтын дизайны хэрэгцээндээ тохируулан орчноо өөрчлөх, засах, тавилга, тоног төхөөрөмж суурилуулах боломжтой буюу сургууль, цэцэрлэгт боломж олгосон санхүүжилтийн хүсэлтийг хүлээн авах хэлбэртэй байна.
- Шинээр барилга барихдаа уламжлалт анги танхимд хуваах хэлбэрээр биш харин сургалтын орон зай бий болгох хандлагад үндэслэсэн (learning space) архитектур болон сургалтын технологийн нийлмэл дизайн гаргах, зөвлөмж, удирдамж боловсруулах **уралдаан** зарлаж болно. Ингэж шийдлийн хувилбаруудтай болсны үндсэн дээр сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга барьдаг болох хэрэгтэй байна. Сүүлийн үед хангалттай судалгаа байдаг болсон.¹
- Сургалтын орон зайн жишээ:
<https://www.youtube.com/watch?v=GCxvCRysfKM>

АСУУДАЛ 2. Боловсролын үйлчилгээг нийт газар нутгаар харж төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан боловсролын асуудал нь нийгмийн, урт хугацааны үр дагавартай асуудал болж магадгүй байна.



Шийдлийн санал:

- Ихэнх аймаг, дүүрэгт **суурь боловсролын үр дүн** тааруу гарч байна.² Нийслэлийн хувьд Сонгинохайрхан дүүрэгт анхаарал хандуулах шаардлагатай байна. Эхний ээлжид сургалтын үр дүн тааруу байгаа төрийн өмчийн сургуулийг магнет эсвэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөртэй болгох замаар бусад

1 Жишээ нь хэд хэдэн төрлийн тогтмол хэвлэл (*Journal of Learning Spaces*) гардаг болсон.

2 Ерөнхий боловсролын төсвийн зарлагын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтээс харна уу.



сургуулийг чанараар манлайлах эсвэл сурганы онолын үндэслэлтэй удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах (school improvement plan)³ боломжтой.

- “Жижиг сургууль” гэж үзэх доод хязгаарыг тогтоох хэрэгтэй. Тухайн орон нутагт зайлшгүй шаардлагатай сургуульд “жижиг сургуулийн нэмэлт санхүүжилт” олгох боломжтой.
- Цаашид санхүүжилтийг боловсролын түвшнээр салгах хэрэгтэй байж магадгүй. Учир нь түвшин бүрд өөр бодлого хэрэгжүүлж байгаа хэр нь нэг аргаар санхүүжүүлэх үндэслэл байхгүй. Тухайлбал ахлах сургуулийг суралцагчдын сонголтоор санхүүжүүлэх, ахлах сургуульд сургалт явуулах багш заавал магистрын зэрэгтэй байдаг бусад орны туршлагаас суралцах хэрэгтэй.⁴
- Сургалтын орон зайн дизайн гаргахыг хөгжүүлэх ёстой бүтээгдэхүүн гэдэг талаас нь харж инженерчлэх процесс гэж үзэхийг судлаачид зөвлөсөн байна.⁵
- Төрийн өмчийн барилга пассив эвсэл ногоон байх хэрэгтэй болж байна. Ногоон барилгын анхны өртөг өндөр байж болох авч ашиглалтын зардал бага байхаар дизайныг гаргах юм.⁶

АСУУДАЛ 3. Сургалтын биет орчны хөрөнгө оруулалт ил тод биш байгаагаас салбарын хэмжээнд хуримтлагдсан асуудлыг бодитоор шийдэж чадахгүй байсаар ирлээ.



Шийдлийн санал:

- Боловсролын чанарыг боловсрол эзэмших наад захын хэрэгцээт орчныг бүрдүүлсэн эсэхээр буюу орцоор тодорхойлдог. Хүний хэрэгцээнд нийцүүлэхийн тулд шийдэх асуудал одоогийн сургалтын байгууллагын дэд бүтэц болон барилга дээр олон байна. Нэгдсэн байдлаар төлөвлөж асуудлыг шийдэхгүй бол манай улсын өнөөгийн туршлагаас энэ бүх хуримтлагдсан асуудлыг боловсролын хөрөнгө оруулалтад одоо мөрдөж буй “тухайн үед нь хийх санхүүжилт”-ын

³ “Жишээ нь “London challenge”-тай төстэй.

⁴ Финландын сургамжаас дэлхий нийтийн хамгийн түрүүнд суралцаж буй зүйл нь багш нарын бие даасан байдал, нийгмийн статус, мэргэшил юм.

⁵ Process of engineering begins with seeing the learning environment as a "product" to be developed rather than simply as a space to be redesigned. Principles which drive design of the facility layout need to take into the consideration objective of facility layout, factors influencing facility layout and constraints of facility layout. <https://www.managementstudyguide.com/facility-layout.htm>

⁶ Мөн манай улсад сургууль, цэцэрлэгийн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга барих гарын авлага гарсан (Байгаль орчин, аялал жуулчлалын яам).



аргаар (Ad hoc funding⁷) шийдэж чадахгүй нь харагдаж байна. Илүү чиглэсэн, зохион байгуулалттай (targeted and structured funding) механизм хэрэгтэй. Иймд **аймаг, дүүрэг, цэцэрлэг, сургуулийн хүсэлтээр “тухайн үед нь шийдэх” санхүүжилтийг түр түдгэлзүүлэх хэрэгтэй.**

- Цэцэрлэгийн насны хүн ам 2025 он хүртэл тогтонги байх төлөвтэй байгаа тул хүчин чадал нэмэх зорилгоор цэцэрлэгийн барилга нэмж барих төлөвлөлтийг **нэг хэсэг хугацаанд азнах**, эсвэл үндэслэлийг сайн гаргах хэрэгтэй харагдаж байна. Монгол Улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 273 цэцэрлэг барихаар төлөвлөсөн. **Хэрэв сургуулийн өмнөх боловсролд 3-5 настай хүн амыг хамруулбал энэ нь үндэслэл муутай төлөвлөгөө болж харагдаж байна.**
- Сургуулийн дотуур байрны хувьд өнөөгийн төлөвлөлтийн аргаар тооцвол хүчин чадал нэмэх хэрэгцээ одоогийн байдлаар харагдахгүй байна. Харин өрөөний хүртээмжийг нэмэгдүүлэх, тав тухыг хангах хэрэгцээ **их** байна.
- Сургуулийн насны хүн ам тасралтгүй нэмэгдэж, асуудлыг урьдчилж харахгүй бол, мөн анги танхим барих, хүнд жинтэй ширээ бүхий “бүгдэд нэг загвар”⁸ төлөвлөлтөөс өөр арга хэрэглэхгүй бол ачаалал улам нэмэгдэхээр байна. Нөгөө талд хоёр ээлжээр хичээллэх практикийг цаашид удаан үргэлжлүүлэх боломжгүй. Халах хэрэгтэй байна. **Сургуулиудыг нэг ээлжээр ажиллахад түлхэц болохуйц бодлого хэрэгжүүлэхдээ хүүхэд хөгжүүлэх, хоцрогдлыг арилгах, хүүхэдтэйгээ ажиллах, гэрийн даалгавраа сургууль дээрээ хийх (to foster all day school), мөн секц, дугуйлан, ажил мэргэжлийн зөвлөгөө, авьяас хөгжүүлэх арга хэмжээнд төсөв хуваарилдаг болох, багшийн ажлын цаг, үнэлгээнд, мөн сургуулийн ажлын үр дүнгийн үнэлгээнд багтаах.**
- Хамран сургах тойрог дээр уян хатан бодлого хэрэгжүүлэх боломжтой. Жишээ нь заавал газар нутгаар биш Сүхбаатар дүүргийн ачаалалтай сургуулийг өөр ачаалал багатай захын дүүргийн сургуультай кластер болж ажиллах боломж олгох, хувийн сургуулиуд улсын сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах гэх мэт кластерийн олон төрлийн бодлогоос сонгож хэрэглэх

7 Тухайн үед нь шийдэх санхүүжилт (Ad hoc funding) гол төлөв шууд олгох хэлбэртэй (грант) байдаг ч манай улсын энэ механизм олон улсын практикаас өөр байдаг. Засвар хийхэд тухайлбал анхны төлөвлөлтөөс эхлэн гүйцэтгэл хүртэл сургуулийн оролцоо маш бага, багш нарт буюу хэрэглэгчдэд бүр хамааралгүй.

8 One fits for all



боломжтой байна. **Кластерийн бодлогыг санхүүжилтийн урамшуулал дагадаг.**

АСУУДАЛ 4. Суурьшлын ялгаанаас үүсэж буй академик болон нийгмийн ялгаа бодит асуудал мөн эсэхийг тогтоох хэрэгтэй байна.



Шийдлийн санал:

- Суурьшлын ялгаа үүсэж байна гэж ярьдаг боловч үүнийг бодитой хэмжиж байгаагүй. Судлаачдын дунд суурьшлын ялгаанаас боловсролын ялгаа үүсэж байгаа эсэхийг үндэслэлтэй (emphiric evidence) илрүүлэх судалгааны уралдаан зарлаж болно.
- Хувийн сургуулийн байршлаас харахад нийслэлд суурьшлын ялгаанаас үүдсэн боловсролын орцын, процессын ялгаа үүсэж эхэлсэн байх магадлалтай. Харин боловсролоос гарах дунд болон урт хугацааны үр дүнд ялгаа бодитой үүсэж буй эсэх, мөн нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоовол орц болон процесс дээр арга хэмжээ авах замаар ялгааг багасгах бодлогыг томъёолж болно.

АСУУДАЛ 5. Сургалтад хэрэгтэй тоног төхөөрөмжийн (facilities) хөрөнгө оруулалт, сургалтад хэрэглэх бараа, үйлчилгээг санхүүжүүлэх “тогтсон арга” (концепц) хэрэгтэй.



Шийдлийн санал:

- Стандарт тооцоололд суурилсан “бүгдэд нэг загвар” хэлбэрийн нийлүүлэлт хийхээс аль болох татгалзах хэрэгтэй. Боловсрол, Шинжлэх Ухааны Яам - БШУЯ 2020 онд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Хөдөлмөрлөх ур чадварыг дэмжих төслийн хүрээнд шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн (STEM) лабораториуд нийлүүлсэн. Үүнийг сургуулиуд бүрэн хэрэглэж амжаагүй байна. Хэрэв багш нар туршилтын аргад мэргэшээгүй, үүнтэй холбоотой сургалтын дизайн гаргах туршлага муутай бол хэрэглээ бага байдаг тухай судалгааны үр дүнг доор оруулав. Иймд сургуулиуд 2020 онд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг бүрэн хэрэглэж дадах хүртэл тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хүлээх хэрэгтэй гэж зөвлөмөөр байна. Энэ байдалтай холбоотойгоор сургалтад хэрэгтэй бараа, үйлчилгээний зардлыг ч өөрөөр төлөвлөх хэрэгцээ үүснэ.



- Сургалтад юу хэрэгтэйг багш шийднэ. Сургалтын дизайны өөрчлөлттэй холбоотойгоор сургалтад хэрэгтэй бараа, үйлчилгээний зардлыг өмнөх шиг стандарт тооцоолол хийж төвлөрсөн байдлаар тооцох боломжгүй болсон. Багшийн хүсэлтээр эрх олгодог туршлага бусад оронд түгээмэл байв. Үүнийг туршилтын хэлбэрээр хэд хэдэн сургууль дээр бөөн дүн тавьж (lump sum funding) багшийн хүсэлтээр зарцуулах эрх олгож, үр дүнг бүртгэн хичээл нэг бүрээр гаргах арга илүү бодитой байж магадгүй.





1. БОЛОВСРОЛЫГ ТӨЛӨВЛӨХ

Сургуулийн дэд бүтэц, боловсролын үйлчилгээг зохион байгуулахдаа суралцагчдын хэрэгцээнд тохируулан өөрчлөх, нийцүүлэх шаардлага үүсэж, үүнд хүн ам зүйд гарч буй шинэ хандлага, нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, мөн боловсролын зорилго, зорилтын хувьсал нөлөөлж байна.⁹

Хүн бүрд хичээллэх, суралцах, хөгжих хангалттай орон зай бүхий дэд бүтэц бий болгох, орчны хэрэгцээнд нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх нь аливаа боловсролын системийн суурь юм. Үүний тулд нийт газар нутгийг хамарсан цэцэрлэг, сургуулийн систем бий болгодог.

1.1 ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ХАНДЛАГА

Боловсролд гарч буй хандлагыг судалснаар ирээдүйг төлөвлөх боломжтой болно хэмээн таамаглах боломжгүй ч хандлагыг харах нь алдаа гаргахаас сэргийлдэг гэж үзжээ.¹⁰ Боловсролын үйлчилгээ, сургуулийн барилга, тоног төхөөрөмж, анги танхимыг төлөвлөх, санхүүжүүлэхэд харгалзан үзэх шаардлагатай сүүлийн үеийн өөрчлөлт, хандлагыг харья.

Үүнд:

- 1) Сургалтын дизайн, багшлахуйн загвар, суралцахуйн арга хэлбэр улам олон төрөл болж, түүнд шаардлагатай орчин ялгаатай байдаг болов.¹¹
- 2) Тархины үйл ажиллагааны зүй тогтлыг дагаж амьдрал дээр тулгардаг асуудлыг шийдэх суралцахуйд өөр өөр судлагдахууныг хамтад нь хэрэглэж байна.¹² Жишээ нь сургалтын агуулгыг бие даасан олон судлагдахуунд хуваах биш ертөнц дээр болдог үзэгдэл, үйл явдал дээр тулгуурлаж суралцах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үед (phenomenon-based learning) сургалтад хэрэгтэй тоног төхөөрөмж, орон зай, цаг хугацаа зэрэг бүх зүйл уламжлалт анги танхим, сургуулийн орчноос өөр байх хэрэгтэй болж байна.¹³

9 Responsive School Systems, OECD Reviews of School Resources (2018)

10 Stevenson (2010)

11 Prakash Nair, Randall Fielding, and Jeffrey Lackney (2009): Schools identifies 18 different modes of teaching and learning that school facilities must support, such as project-based learning, cooperative learning, peer tutoring, integrated technology that is ubiquitously available when and where needed, team teaching, naturalist learning, and performance-based learning.

12 Жишээ нь both engineering and social sciences (BIM)-interdisciplinary study- <https://www.the-possible.com/future-of-education-digital-campus-learning-teaching/>

13 Mattila and Silander (2015) "How to create the school of the future: revolutionary thinking and design from Finland,"



- 3) Суралцагчдын төрөл, суралцахуйн арга барилыг нь таньж тогтоон, түүнд тохируулах хэрэгтэй боллоо. Нэг бүлэг буюу 30 хүүхэд суралцах стандарт анги танхим гэхээсээ илүү сургалтын орон зай хэрэгтэй байдаг болов.¹⁴ Суралцах хэв маягаар нь суралцагчдыг бүлэглэх судалгаа, туршилт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдлээ.¹⁵ Энэ нь олон талаар сургуулийн дизайнд нөлөөлж байна. Жишээ нь (1) Хичээлийн танхим, хэлбэр, дизайн, тавилгыг өөрчилж байна.¹⁶ (2) Сургуулийн барилгыг бүхэлд нь тусгай онцлог хэрэгцээнд нийцүүлсэн байх хэрэгтэй болж байна. Тухайлбал нүдээрээ харж сурдаг бүлэг хүнд визуал медиа хэрэгсэл бүхий танхим хэрэгтэй бол кинестетик¹⁷ суралцагчдад биеэрээ, гараараа хийх үйл ажиллагааг дэмжсэн загвартай орон зай хэрэгтэй.
- 4) Хуучны тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ энгийн сургуулийн үйл ажиллагааны нэг хэсэг болж байна. Ялгаатай хөгжилтэй суралцагчдыг энгийн сургуульд авах болсон нь сургуулийн дэд бүтэц болон төлөвлөлтөд орц болдог олон төрлийн нөөцөд нөлөөлж байна. Ирэх 30 жилд ялгаатай хөгжилтэй хүн амын тоо өснө гэж тооцохыг судлаачид зөвлөжээ.¹⁸
- 5) Сургууль дээр өнгөрөөх цаг, сургууль гэдэг ойлголт өөрчлөгдөж байна. “Зүрх сэтгэл хаана байна тэр газар сургууль байна. Биетээр оршдоггүй буюу виртуал сургууль бодит болж, тоосго, зуурмагаас бүтдэг барилгыг л зөвхөн сургууль гэж нэрлэх боломжгүй боллоо.”¹⁹ Суралцагчид багшийнхаа явуулсан линкээр байгаа газраасаа нэвтрэх, хэдэн зуун бээрийн цаанаас ч хичээлдээ орж байна. Мөн ихэнх улс жилд 180 орчим өдөр сургууль дээр хичээллэхээр төлөвлөдөг байсан бол ирээдүйд сургууль хэмээн нэрлэгддэг “барилгад” долоо хоногт 3-4 өдөр очдог болж, харин сургалтын бусад үйл ажиллагааг МХХТ-ийн хэрэгслээр явуулахаар төлөвлөж магадгүй. Энэ нь 1) үйл ажиллагааны зардлыг хэмнэх (20 орчим хувь), 2) суралцах цаг багасах биш, ихсэхэд хүргэнэ.²⁰
- 6) Технологи ирээдүй биш өнөөдөр болсон. Эндээс зарим зардал өсч, зарим байнга төлөвлөдөг зардал алга болж магадгүй.²¹ Тухайлбал цаасны хэрэглээ эрс багасаж, онлайн эх сурвалж, программ хангамжид нэвтрэх, бүртгүүлэх зардал төлөвлөх хэрэгтэй болж байна. Онлайн хичээлийн тоо, программ хэрэгслийн тоо болон

14 <http://www.bobpearlman.org/Learning21/new%20learning%20environments.htm>

15 Matthew Cobb (2020) The idea of the brain.

16 Design for Learning forum: School Design and Student Learning in the 21st Century

17 kinesthetic

18 https://www.who.int/disabilities/world_report/2011/report.pdf

<http://uis.unesco.org/sites/default/files/documents/ip49-education-disability-2018-en.pdf>

19 Stevenson (2010): School is where the hearth is.

20 <https://www.edtechdigest.com/2018/10/04/the-future-of-education-trends-we-are-sure-to-witness/>

21 Gomendio, M. (2017), Empowering and Enabling Teachers to Improve Equity and Outcomes for All, International Summit on the Teaching Profession, OECD Publishing, Paris.



хэрэглээ сүүлийн 2 жилд эрс нэмэгдсэн.²² Мөн суралцах боломж хил хязгааргүй болсон. Үүнд: 1) мастер багшийн бэлтгэсэн материал, чанартай хичээлийг бүгдээрээ үзэх, 2) сургалтын материалыг суралцагчийн онцлогт тохируулах боломж нэмэгдэж, 3) хэзээ, хаана, хэрхэн сурах дээр төгсгөлгүй олон сонголт гарч ирэв.²³

- 7) Хэмжээс ашиглан бүх зүйлийг мэдрэмжид ойртуулах арга хурдтай хөгжиж байна. Жишээ нь огментэд (авчрах)²⁴, контакт (хүртэхүй ашиглах)²⁵ болон виртуал бодит байдал (очих)²⁶ бүхий симуляцийн лабораториуд сургалтад ашиглах болов.²⁷
- 8) Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлээс үүсэх ялгааг багасгахад илүү анхаарах болсон.²⁸ Эцэг эх, асран хамгаалагчдын амьдрал ахуй, боловсрол, соёл, хандлага хүүхдийнх нь сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж байгааг харуулж, хэмжих арга ч нарийн болсоор байгаа нь олон улсыг хамарсан ПИСА зэрэг боловсролын үнэлгээний үр дүн юм. Иймд энэ асуудал нийгмийн анхаарлын төвд байх болов.



22 The global education technology market size was valued at USD 76.4 billion in 2019 and is expected to grow at a compound annual growth rate (CAGR) of 18.1% from 2020 to 2027, according to a report from Grand View Research, a market research and consulting company headquartered in San Francisco.

23 Ryan Valconi (2018), Zare (2016) From E-learning to Ubiquitous Learning; Theoretical Principles

24 Augmented Reality (AR) refers to interactions with physical environments that are enhanced with the help of computer-mediated images and sounds.

25 "Haptics" is technology that stimulates the senses.

26 Virtual Reality (VR) consists of interacting with computer-generated simulated environments.

27 <https://www.the-possible.com/future-of-education-digital-campus-learning-teaching/>

28 Broer et.al (2019) Socioeconomic Inequality and Educational Outcomes: An Introduction



1.2 РЕФОРМ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ

Fielding (1999): "No more classrooms! Don't build them."

Боловсролын зорилго, тухайн улсын онцолж буй үр дүн нь түүхийн турш өөрчлөгдсөөр ирсэн хэдий ч үндсэн бүрэлдэхүүн дээр нэмэгдэх хэлбэртэй, бас тухайн цаг үеийн хэрэгцээ, ач холбогдлоороо ялгаатай байдаг.²⁹ Олон судлагдахууны синтез судалгаа болох "Суралцахуй, хөгжлийн шинжлэх ухаан" эрчимтэй хөгжиж, хүүхдийг академик, танин мэдэхүйн, ёс зүйн, биеийн, сэтгэлзүйн, нийгмийн зэрэг бүх талаар нь цогц хөгжүүлэх загвар шинэчлэгдэж, дахин эрчимтэй яригдаж эхлэв.³⁰ Боловсролын зорилгын жишээ: ³¹

Сургалтын хөтөлбөрт заасан академик агуулга (3R, 4K зэрэг + 21-р зууны ур чадвар (4Cs)
+Өөрийгөө таньж мэдэх, удирдах чадвар (бие болоод сэтгэл санааны эрүүл мэнд)
+Нийгмийн ур чадвар + Даван туулах чадвар ³² + - - - ∞

Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд бусад улс сүүлийн 20 жилд педагогийн инновац эрчимтэй хийж,³² сурганд гарсан энэ их өөрчлөлт нь сургалтын биет орчны шинэчлэл рүү хөтөлж байна.³³ Өөрийн орны өнөөгийн байдалтай холбоотойгоор сургалтын биет орчинд явагдаж буй зарим өөрчлөлтийг бага зэрэг дэлгэрүүллээ.

Үүнд:

- Идэвхтэй, хамтран суралцахуйн орчин бүрдүүлэх,
- Хүн-төвт дизайн гаргах³⁴
- Суралцахуйг баяжуулах боломжийг нэмэгдүүлэх.

29 Rothstein, R and Jacobsen, R. (2006). The goals of education, Phi Delta Kappan 88(4):264-272: АНУ-д сүүлийн 250 жилийн турш онцолж байсан боловсролын зорилгод синтез хийж төрийн өмчийн сургуулийн зорилгод өгч буй ач холбогдлын талаар мэргэжлийн хүмүүс болон иргэдийн (насанд хүрсэн иргэн, сургуулийн удирдах ажилтнууд, боловсролын байцаагч, хууль тогтоогчид гэх мэт) саналыг нэгтгэсэн байна. Гол хичээлийн академик чадвар-22%, Тунгаах болон асуудал шийдэх чадвар-18%, Нийгмийн ур чадвар, ажлын этик-12%, Иргэний үүрэг, хариуцлага-11%, Ур чадвар шаардсан ажилд бэлтгэх-10%, Биеийн эрүүл мэнд, Сэтгэл санааны эрүүл мэнд, Урлаг, гоозүйн мэдрэмж 9% байхаар дүн гарчээ.

30 Science of Learning and Development. https://5bde8401-9b54-4c2c-8a0c-whole-child-development-569fc1789664.filesusr.com/ugd/eb0b6a_24f761d8a4ec4d7db13084eb2290c588.pdf

31 Kilbane, C & Milman, N (2014) Teaching Models: Designing Instruction for 21st Century Learners

32 Paul Hamlyn Foundation (2016) Learning Futures: Next Practice in Learning and Teaching.

33 Pearlman (2016): Innovative Pedagogy to Innovative School Facilities

34to move away from teacher-directed whole-group instruction to create learner-centered workplaces for a collaborative culture of students at work (), "telling/lecturing" to the "new" pedagogy of kids teaching themselves with the teacher's guidance" (Prensky, 2008).



1.2.1 Идэвхтэй, хамтран суралцах орчин бүрдүүлэх

Идэвхтэй суралцахуйн орчин³⁵ бүрдүүлэх нь сургалтын үйл ажиллагаанд суралцагчдыг оролцуулахад эергээр нөлөөлж байгааг сүүлийн үеийн судалгаанууд харуулсаар байна.³⁶ Боловсролыг төлөвлөхдөө “сургуулийн барилга, доторх зохион байгуулалт зэрэг биет орчны талаас бодож эхлэхээсээ өмнө суралцагчдад, дараа нь тэдэнд туслахаар ажиллаж буй багш нарт нь юу хэрэгтэй вэ гэдгийг бодох хэрэгтэй бөгөөд тэр үед л өнөөгийн сургалтын орчин үүнийг хийхэд тусалж чадаж байгаа эсэхийг ойлгох болно.”³⁷ Ийм замаар сурганыг сургалтын орчин руу хөрвүүлж харах боломжтой.³⁸ Сурганы хамгийн гол хэсэг болох багшлахуйн зарим гол загварыг, түүнд хэрэгтэй сургалтын биет орчны хамт харууллаа.

Хүснэгт 1.1 Багшлахуйн загвар, түүнд хэрэгтэй суралцахуйн биет орчин

Багшлахуйн загвар	Зориулалт	21-р зууны суралцахуйг дэмжих хэлбэр	Сургалтын орчин
1. Шууд хичээл заах	Багш удирдан сургалт явуулдаг загвар. Энэ загвар нь суралцагчдыг шинээр сурсан зүйлээ бие даан ашиглах чадвартай болгохын тулд процедурыг ойлгодог болоход тусална.	- Логик болон зохион байгуулалттай сэтгэхүйг хөгжүүлэх. - Процедурын (хийх аргын) мэдлэг, чадварыг бие даан эзэмших. - Байгаа мэдлэгийг хэрэглэх дадлага хийх.	Уламжлалт ангид эсвэл лекцийн танхимд хичээллэж болно.
2. Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх	Багш чиглүүлдэг сургалтын загвар. Энэ загвараар суралцахад жишээ татаж, эсвэл жишээгүйгээр дүн шинжилгээ хийх чадвараа ашиглах замаар ухагдахууныг ойлгоно.	- Ялгаж салгах, ерөнхийлөх чадварыг хөгжүүлэх. - Мэдлэг эзэмшихийн төлөө шургуу хөдөлмөрлөх, эрэл хайгуул хийх, шимтэн суралцах дадал суулгах.	Судалгаа хийх, ярилцах орон зай хэрэгтэй.
3. Ухагдахууныг хөгжүүлэх	Суралцагч-төвт загвар. Ухагдахууныг бүлэглэх, ангилах зориулалттай жишээн дээр ажиллаж индуктив учир шалтгааныг олох замаар утгыг нь илүү	- Уян хатан чөлөөтэй бодож сэтгэх, ерөнхий дүгнэлт хийх, ангилж ялгах чадварыг хөгжүүлэх. - Зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэх.	Судалгаа хийх орон зай , орчин хэрэгтэй. Уламжлалт ангид зарим

35 Active learning is generally described as any pedagogical strategy that engages students in the learning process (Prince, 2004).

36 Mary Odum, Karen S Meaney, Duane V Knudson (2021) Active learning classroom design and student engagement: An exploratory study. *Journal of Learning Space*. Vol 10, No 1 (2021) > Odum

37 EDU/EDPC/GNEELE(2017)

38 Fisher (2005)



	сайн ойлгоход энэ загвар тусална.	Ухагдахууныг ойлгох, холбоосыг таньж мэдэхэд туслах.	хичээл орно.
4. Индуктив	Багш чиглүүлдэг сургалтын загвар. Энэ загвараар суралцахад эрэл хайгуул, судалгаа хийх замаар тухайн сэдвийн нарийн агуулгыг таньж мэднэ.	- Судалж буй зүйлийн индуктив учир шалтгааныг олох чадварыг хөгжүүлэх. - Нэг цэг рүү нийлүүлэх, мөн нэг цэгээс салгаж бодох чадвар суулгах дадлага хийх. - Харилцан бие биедээ нөлөөтэйгөөр хамтрах чадварыг хөгжүүлэх, судалж буй агуулгыг утга учиртай болгохын тулд хамтран ажиллаж чаддаг болоход нь туслах. - Судалж буй агуулгыг гүнзгий ойлгох стратеги заах.	Судалгаа хийх орон зай , орчин хэрэгтэй.
5. Үгийн сан хөгжүүлэх	Багш чиглүүлдэг сургалтын загвар. Үгийн утгыг шинжилж, өөрийнхөөрөө ойлгоход энэ загвар тусална.	Аливаа зүйлийн нарийн утгыг таньж мэдэх, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, бүтээлч сэтгэхүйтэй холбох.	Уламжлалт ангид хичээллэнэ.
6. Эрэл хайгуул хийх	Процесст-суурилсан сургалтын загвар. Чухал асуултад хариулахын тулд системтэйгээр бодож сэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшиж, хандлага, дадлыг төлөвшүүлэхэд энэ загвар тусална.	- Асуудал шийдвэрлэх ур чадвар заах. - Мэдлэг эзэмших шинжлэх ухаанч аргуудыг танилцуулах. - Суралцахуйд суралцах хандлага төлөвшүүлж, чадвар суулгах.	Багаар ажиллах, судалгаа хийх боломжтой орон зай , орчин хэрэгтэй.
7. Асуудалд суурилсан суралцахуй	Идэвхтэй суралцах загвар. Энэ загвараар суралцсанаар эзэмшсэн мэдлэгээ асуудал шийдэх ур чадвартай хослуулан академик судлагдахуун дахь чухал асуудлуудыг шийдвэрлэхэд хэрэглэж сурна.	- Бодит амьдрал дээр тулгардаг асуудалд мэдлэгээ ашиглаж сурах. - Асуудлыг шийдэх үр дүнтэй процесст суралцах.	Багаар ажиллах, судалгаа хийх боломжтой орон зай , орчин хэрэгтэй.
8. Хамтран суралцах	Хамтран ажиллангаа суралцах загвар. Судалж буй агуулгыг эзэмшиж, нийгмийн ур чадварыг хөгжүүлэхэд хэрэгтэй хамтран суралцах хандлагыг	- Үр дүнтэй хамтрах, харилцах (сонсох, ээлжлэх) ур чадвар эзэмших. - Хамтран ажиллах, багаар ажиллахын ашиг тусыг ойлгох.	Багаар ажиллах, нийгмийн ур чадвараар дадлага хийх орон



	төлөвшүүлэхэд энэ загвар тусална.		зай хэрэгтэй.
9. Нэгдмэл	Багш чиглүүлдэг сургалтын загвар. Энэ загвараар суралцах нь тунгаах, шүүмжлэлт дүн шинжилгээ хийх замаар бие даан суралцах чадварыг хөгжүүлнэ.	• Судалсан зүйлээ холбон, томъёолох, дүгнэлт хийх, ерөнхийлөх чадварыг хөгжүүлэх. • Их хэмжээний мэдээллийн гол санааг ойлгох, дүн шинжилгээ хийх, судлах чадвар эзэмшүүлэх.	Уламжлалт анги байж болно.
10. Сократын семинар	Багш чиглүүлдэг сургалтын загвар. Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, бодлоготойгоор боловсруулсан, зориудын чиглүүлсэн асуултыг ярилцах, мэтгэлцэх замаар санааг дэлгэрүүлэхэд энэ загвар тусална.	• Харилцах, хамтрах чадварыг хөгжүүлэх (сонсох, асуулт тавих) • Асуулт тавих, нийлүүлж дүгнэх (синтез), дүн шинжилгээ хийх зэргээр сэтгэн болох чадварыг хөгжүүлэх.	Уламжлалт анги байж болно.

Эх сурвалж: Эхний гурван баганыг “Kilbane, C & Milman, N (2014) Teaching Models: Designing Instruction for 21st Century Learners”-ногоос авав.

1.2.2 Хүн-төвт дизайн гаргах

Аливаа зүйлийн дизайныг гаргах цөм нь хүн гэдгийг онцлоход Хэрберт Саймоны дизайн гаргах сэтгэхүйн онол чухал хувь нэмэр оруулсан.³⁹ Хүн төвт дизайнаар хүнийг л онцолж, ямар нэг асуудал тулгарсан үед хүний хийх үйлдэл, хэрэгцээг ойлгох, шийдэл нь хүмүүсийн хэрэгцээнд үнэхээр нийцэх эсэхэд анхаардаг. Үүгээрээ асуудлыг шийдэх бусад аргаас ялгаатай.

Орчин үеийн сурганы цөм (commons) нь мэдээлэл дамжуулах биш суралцахуй юм. Иймд хүн төвт аргаар сургалтын биет орчны дизайн гаргахын тулд

- Суралцахуйн төрөл бүрийн хэв маягийг дэмжих,
- Тэнд суралцах, ажиллах хүмүүсийн эрүүл мэнд, гоо зүйн хэрэгцээ, тав тухыг хангахад анхаарах ёстой.

Орчин нь хүнд өдөөгч болж, мэдрэхүйгээрээ шинэ мэдээллийг хүлээн авдаг учраас суралцахуйн хэв маягт нь (аудитор, визуал, кинестетик, тооцоолох зэрэг) тохирсон буюу бүх төрлийн суралцахуйд бэлэн орчин байх ёстой. Наяр, Филдинг нарын “Сургуулийн дизайны хэл: 21-р зууны сургуулийн дизайны хэв маягийг гаргах нь” ном энэ чиглэлд ихээхэн өөрчлөлт авчирсан бүтээл⁴⁰ юм. Тэд хүний суралцахуйн хэрэгцээг шийдэх зорилготой дизайн гаргахдаа эхлээд хүний тархи хэрхэн

39 Nobel Prize laureate Herbert Simon (1969) The Sciences of the Artificial

40 P. Nair & R. Fielding (2009). The Language of School Design: Design Patterns for 21st Century Schools



ажилладаг, хүний үйлдэл ямар нарийн төвөгтэй байдаг талаас нь харсан байна. Орон зайн, сэтгэл санааны, физиологийн, зан төлөвийн гээд 4 хүрээнд аливааг хүн туулж мэдэрдэг. Эдгээр хүрээний онцлог шинжийг сургуулийн биет орчны дизайн гаргахдаа харгалзах,⁴¹ микро, макро түвшинд эрүүл орон зайн холбоос гаргах тодорхой “хэв” эсвэл зүй тогтол байдаг, тэрхүү “зүй тогтлын хэлийг” дагах хэрэгтэй гэж зөвлөжээ. Энэ нь хүний туулах 4 хүрээний туршлага, мэдрэмжээс аль болох олныг эерэг үр дүнд хүргэхээр холбох арга юм гэж үзсэн.⁴² Филдинг суралцахуй явагдах олон ялгаатай орон зай, үүнд гэртээ байгаа мэт орчин, хамтран ажиллах инкубатор, агуулах, төрөлжсөн лаб, төсөл дээр ажиллах хэсэг, гадаа суралцах орчин, дэлгэцийн хэсэг, амрах хэсэг, ганцаараа байх кабин, багаар ажиллах хэсэг, илтгэл тавих хэсэг, багш нар уулзах хэсэг санал болгожээ.⁴³ Орчин үеийн суралцагчид гэртээ байгаа мэт орчин, суралцах студио, суралцах плазад “ажилладаг” болсон.⁴⁴ Хамгийн инновац бүхий сургалтын орчинд арт, инженерчлэл, медиа, дизайн хийх зэрэг аливааг хийх тусгай төрөлжсөн орон зай нь тус тусдаа байдаг болов.⁴⁵

1.2.3 Суралцахуйг баяжуулах хэрэгсэл ашиглах боломж бүрдүүлэх

Суралцагчид “ажил дээрээ байгаа” мэт суралцахын тулд бүх хүүхэд компьютертой, утасгүй интернэтэд холбогдсон байх нь эхний шаардлага юм.⁴⁶



41 P. Nair & R. Fielding (2009). The Language of School Design: Design Patterns for 21st Century Schools

42 Pattern Language Model

43 Fielding (2005)

44 Fielding (2005)

45 Linda Zane (2015) Pedagogy and Space: Design Inspirations for Early Childhood Classrooms

46 Educational Technology Magazine, Nov 2010: 1:1 Learning initiatives in schools



Хүснэгт 1.2 Суралцахуйн орон зайн онцлог

Үйл ажиллагааны төрөл	Суралцахуйн орон зайн онцлог	Технологи
Академик агуулга эзэмших Судалж буй сэдвийг идэвхтэй судлах орон зай байх, төрөл бүрийн сургалтын дизайн, багшлахуйн загвар ашиглах боломжтой байх.	<u>Уян хатан, чөлөөт орон зай:</u> Өргөн уудам ажлын орон зай; Байгалийн болон сайжруулсан шууд бус гэрэлтүүлэгтэй байх <u>Идэвхтэй суралцах орон зай:</u> Өргөн тавцангууд, тухтай тавилга, олон төрлийн технологи ашиглах боломжтой, мөн дуу, гэрлийн тохиромжтой зохицуулалттай байх.	- Суралцагч бүрд хүрэлцэх компьютер, цэнэглэх боломжтой шугам, судалсан, хийсэн зүйлээ хэвлэх боломжтой дэд бүтэц байх. - Олон төрлийн мэдээллийн эх сурвалж руу холбогдох (Суралцахуйн удирдлагын систем, виртуал лаб, тусгай зориулалттай программ хангамж).
Үе тэнгийнхэнтэйгээ суралцах Суралцахуйн орон зай нь суралцагчид нэг нэгэндээ туслах, бие биедээ заах, биеэсээ суралцах, мөн бие даан ажиллах боломжтой байх.	<u>Уян хатан, чөлөөт орон зай:</u> Хүнд, үргэлжилсэн загвартай ширээ, сандлыг хөнгөн, хөдөлгөж болох дугуйтай тавилгаар сольж, багаар ажиллах боломж бүрдүүлэх. <u>Идэвхтэй суралцах орон зай:</u> Хамтран ажиллахад дугуй ширээ, дижитал болон биет ажлын орон зай байгуулах.	- Хамтран ажиллах ажлын талбар (бичиж болох хана, дижитал самбар, проектор гэх мэт). - Хичээлийн удирдлагын систем дээр баг үүсгэх, нэг файл дээр зэрэг ажиллах боломжтой байх. - Хамтдаа унших,⁴⁷ хамтдаа бичих,⁴⁸ хамтдаа төсөл дээр ажиллах (шинжлэх ухааны лаб, симуляцийн өрөө, виртуал лаб, тусгай зориулалттай программ хангамж, хөгжмийн зэмсэг) боломжтой байх.
Хамтран ажиллах Суралцахуйн орон зай нь суралцагчдын хооронд, багш нарын хооронд, багш суралцагчийн хооронд,	<u>Уян хатан, чөлөөт орон зай:</u> Чөлөөтэй хөдлөх боломжтой биет орон зай нь багш-суралцагчийн хоорондын зайг	Багш болон суралцагчид видео загварчлал боловсруулах ашиглах боломжтой байх.⁴⁹

47 Kindle, Nook, and iPad, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл зэрэг

48 Google Docs, Wiki

49 Алслагдмал газар байгаа, эсвэл онлайнаар хичээллэж байгаа, хөгжлийн ялгаатай өөр өөр хэрэгцээтэй суралцагчдад видео загварчлал (video modeling) ихээхэн ашиг тустай.



улмаар сургууль дотор, сургууль хооронд харилцаа, хамтын ажиллагаа явуулахад амар хялбар байх, ямар нэг хязгаарлалт, бэрхшээл учруулдаггүй байх.	ойртуулдаг. Уламжлалт урдаас харах хэлбэртэй шатлалыг багасгана. Ялгаатай хөгжилтэй суралцагчдад хэрэгтэй үед нь тусламж үзүүлэх, багаар ажиллаж буй үед асуулт гарвал багш шууд очих боломжтой. <u>Идэвхтэй суралцах орон зай:</u> Суралцагчидтайгаа ганцаарчилж ажиллах, бүлгээр ажиллах орон зай, мөн ангиудыг нийлүүлж лекц унших, арга хэмжээний заал; нэгдсэн тусламж үзүүлэх, суралцагч, багш нарын асуудлыг шийдэх “хүлээн авах төв цэг эсвэл индэр” хэрэгтэй.	• Технологийн хэрэгслүүд ашиглах эрх, дэд бүтцийн орчин бүрдсэн байх.⁵⁰ • Аудио хэрэгсэл, хөгжим, дэлгэц, цагаан самбар зэрэг онлайн хамтран ажиллах орчин бүрдсэн байх
---	--	---

Эх сурвалж: Finkelstein et. al. (2016). Research-informed princiles for redesigning teaching and learning,

Улс орнууд суралцахуйн энэ хэрэгцээнд нийцүүлэхийн тулд сургалтын орчны шинэчлэл хийх “том дүнтэй хөтөлбөр” хэрэгжүүлж үр дүнг нь тайлагнаж байна. Тухайлбал Англи улс дунд сургууль бүрийг шинэчлэх эсвэл солих зорилгоор “Ирээдүйн сургуулийг барих нь” (55 тэрбум фунт стерлинг) хөтөлбөрийг⁵¹ 2003 оноос хэрэгжүүлж байна. Сингапур улсын хувийн сургуулиудын бүтээсэн сургалтын уян хатан орчин судлаачдын анхаарлыг татах болсон.⁵² Австрали улс 2008 оноос “Боловсролын шинэчлэлийн бүтээн байгуулалт хөтөлбөр” хэрэгжүүлсэн.⁵³ Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон гол үндэслэл нь үүсч буй боловсролын хэрэгцээг хангахаас гадна, барилгын дийлэнх материалыг дотооддоо үйлдвэрлэдэг учраас эдийн засгийг сэргээх хөрөнгө оруулалт болно гэж үзсэн юм байна.

50 WebQuests, Blackboard Engage, or wikis, Google Bookmarks and Diigo

51 Building Schools of the Future (BSF)-

https://www.designingbuildings.co.uk/wiki/Building_Schools_for_the_Future_BSF

52 Өмнөх тайланд Финлянд, Дани улсын жишээг харуулсан.

53 Building the Education Revolution (BER) program: Primary Schools for the 21st Century (P21), which initially provided \$12.4 billion for Australian primary schools to build iconic new facilities, such as libraries and multipurpose halls, or to upgrade existing facilities, by 31 March 2011; National School Pride, which provided \$1.3 billion for minor capital works and refurbishment projects in all eligible Australian schools, to be completed by February 2010; and Science and Language Centres, which initially provided \$1 billion for construction of new, or refurbishment of existing, science laboratories or language learning centres in secondary schools by 30 June 2010.

<https://www.anao.gov.au/work/performance-audit/building-education-revolution-primary-schools-21st-century>



Хүснэгт 1.3 Австрали улсын сургалтын орчныг шинэчлэх “Үндэсний хөтөлбөрүүд”

Хөтөлбөр	Тодорхойлолт /Австрали доллар/
<u>Боловсролд хувьсал, өөрчлөлт хийх хөтөлбөр</u>	
Гүйцэтгэл: 17.2 тэрбум доллар. Үүнд дараах төслүүд багтана.	
1) 21-р зууны бага сургууль (14.1 тэрбум)	Нийт 24,000 төсөлд хөрөнгө оруулалт хийж, сургуулийн дэд бүтцийг орчин үеийн болгох зориулалттай.
2) 21-р зууны дунд сургуульд зориулсан шинжлэх ухааны болон хэлний төв (1.8 тэрбум)	7,920 сургууль дээр хэрэгжих 10,475 төслийг санхүүжүүлэх эрх үүссэн. Номын сан, олон төрлийн зориулалт бүхий заал, мөн анги танхим байгуулах, байгаа тоног төхөөрөмжийг солих ажил хийгдэнэ.
3) Үндэсний шилдэг сургууль (1.3 тэрбум)	537 сургуульд шинжлэх ухааны лаб болон хэлний төв байгуулах санхүүжилт зөвшөөрөгдсөн. 9,462 сургуулийн 12,639 төслийг санхүүжүүлэх эрх үүссэн. Үүнд сургуулийн барилгыг сэргээх, тогтсон хэв маягтай барилгын загварыг өөрчлөх, гадаа талбайд суралцах орон зай барих, спортын талбай, тоног төхөөрөмж, ногоон байгууламж хийх төслүүд багтсан.
<u>Мэргэжлийн сургалтын төв байгуулах хөтөлбөр</u>	
Анхны төлөвлөсөн өртөг: 2.5 тэрбум доллар: Сургууль дээр мэргэжлийн сургалтын шинэ төвүүд байгуулах, одоо байгааг нь шинэчлэх.	
<u>Дижитал боловсролын хувьсалд түслэх хөтөлбөр</u>⁵⁴	
Гүйцэтгэл: 2.4 тэрбум доллар. Үүнд дараах төслүүд багтана.	
9-12 дугаар ангийн бүх суралцагчдад мэдээлэл, харилцаа холбооны технологийн тоног төхөөрөмж бэлтгэх (2.2 тэрбум) - Бүх сургуульд өндөр хурдны интернэт холболт хийх (100 сая) - Бүх багш болон сургуулийн удирдлагыг МХХТ-ын боловсрол эзэмших мэргэжлийг хөгжлийг дэмжих (40 сая)	

21-р зууны суралцахуйн орчныг бүрдүүлэх АНУ болон Их Британы хөтөлбөрүүд дээр ажилласан зөвлөх Пирлмэний (Bob Pearlman) нэгтгэсэн сургалтын орчноо улс орнууд хэрхэн шинэчилж буйг харуулсан видео материал болон чухал хэвлэлийг хөл тэмдэглэгээнээс харна уу.⁵⁵ Тэр мөн АНУ болон Их Британи улсад хэрэгжсэн сургуулийн 5 төслийг сургалтын шинэ орчныг харуулах шилдэг, бас өөр өөрийн онцлогтой жишээ гэж үзэн, судлахыг санал болгожээ.⁵⁶

⁵⁴ <https://docs.education.gov.au/category/deewr-program-group/digital-education-revolution>

⁵⁵ <http://www.bobpearlman.org/Learning21/new%20learning%20environments.htm>

⁵⁶ Bob Pearlman (2016) Ch 6. Designing new learning environments to support 21st Century Skills:

- Columbus Signature Academy, Columbus, Indiana



-
- New Tech High @ Coppell, Coppell, Texas
 - The Metropolitan Regional Career and Technical Center, Providence, Rhode Island
 - High Tech High, San Diego, California
 - New Line Learning Academy, South Maidstone Federation, Maidstone, Kent, England



1.3 ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ

Боловсрол судлалд төлөвлөлт гэдэг нь бодлого боловсруулж, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ирээдүйд юу хэрэгтэй болохыг урьдчилан харах чадвар юм.⁵⁷ Харин уламжлалт тодорхойлолтоор газар, тоног төхөөрөмж, ажилтан зэрэг нөөцийг боловсролын тодорхой хэрэгцээнд зориулан системтэйгээр хуваарилах үйл явц юм гэж үздэг байв.⁵⁸ Төлөвлөлтийн уламжлалт онол, практикаар⁵⁹ боловсролын төлөвлөлт урт хугацаанд дэд бүтцийг төлөвлөх, хамран сургалтыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулдаг. Харин орчин цагт илүү стратегийн шинжтэй болж, “өсөлт, өөрчлөлтийг удирдах” тухай асуудал байх болов.⁶⁰ Сүүлийн үед боловсролын төлөвлөлтөд тулгарч буй асуудлууд нь нийт газар нутгийг хамарсан боловсролын системийн талаарх ойлголтыг өөрчилж байна.⁶¹ Тухайлбал:

- Сургалтын үйл ажиллагааг орон зай болон засаг захиргааны нэгжээр тусгаарлах боломж багасч байна.⁶² Та “энэ гудамжинд амьдардаг л бол энэ сургуульд явах ёстой” гэж тулгах боломжгүй болсоор байна.⁶³
- Нэгэнт бүтээсэн систем болон өдөр тутмын тогтсон практикт найдах боломжгүй болж байна.⁶⁴
- МХХТ-ийн хөгжлийн ачаар суралцах орон зай, цаг хугацааны талаарх ойлголт эрс өөрчлөгдөв.
- Орчны хурдтай хувьслагаас шалтгаалж ирээдүйн үйл ажиллагааг баримжаатай таамагласан төлөвлөгөө гаргахад хүндрэлтэй боллоо.⁶⁵
- 21-р зуунд аливаа асуудалд орон нутгийн оролцоо аль ч улсад их болж, олон оролцогч асуудлыг улам хүндрүүлэх болов.⁶⁶

57 Foresight in formulating and implementing programs and policies.

58 Хэрэгцээг гаргаж ирэх, Байгаа нөөц, нөхцөл байдлыг үнэлэх, Зорилго, зорилт, хүрэх үр дүнг томъёолох, Хувилбаруудыг гаргаж ирэх, Ажил хэрэг болгох хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах, Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх, Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлэх

59 Lewin (2013) Four decades of education planning: Retrospect and prospect: Centralized educational planning has also played an important role among developing nations, as from the 1960s.

60 Husar, M., et.al (2017)

61 World Multidisciplinary Earth Sciences Symposium (2017)

62 administrative spaces and functional spaces overlap

63 Stevenson (2007)

64 business as usual is no longer an option in education planning


65 to predict the future and prepare rigid plans

66 Husar et.al (2017)



- Тулгамдаж буй асуудлыг нэг талаас нь харж төлөвлөх боломжгүй болж байна.⁶⁷

Харин манай улсад боловсролыг төлөвлөх нь өнөөдрийн бэлэн нөөц дээр ирээдүйн хэрэгцээг хангах үйл хэрэг хэвээр байна. Олон төрлийн нөөц боловсролыг төлөвлөхөд орц болох бөгөөд бидэнд тулгарч буй өнөөгийн асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулж магадгүй гэж үзсэн зарим нэгийг нь энд авч үзье. Ингэхдээ боловсролыг төлөвлөх, сургалтын биет орчны дизайн гаргах, сургууль, цэцэрлэг барих, санхүүжүүлэх, үйл ажиллагаа явуулахад гарч буй орчин үеийн хандлага, бидэнд тулгарч буй зарим асуудлыг шийдсэн бусад орны туршлагыг судалж, дараа нь хөрөнгийн төсвийн зарим арга хэмжээний санхүүжилтийг сайжруулах санал боловсруулаа.



Эх сурвалж: Санааг PISA (2018) тайлангаас авав.



1.3.1 Сургуулийн хэмжээ

Сургуулийн хэмжээ олон талаар сургалтын үр дүнд нөлөөлж болно. Сургуулийн хэмжээ ямар байвал оптимал байхыг нэгдсэн байдлаар тогтоох боломжгүй. Суралцагчийн тоо нэмэгдээд байх тусам тодорхой эдийн засгийн цар хүрээ хүртэл зардал буурч, сургуулийн хэмжээ хэт томроход захиргааны бүтэц төвөгтэй болж үр ашиг буурдаг гэж үздэг.⁶⁸ Иймд бага сургуулийг 300-500 суралцагчтай, бусад түвшинд, ялангуяа ахлах сургуулийг 600-900 суралцагчтай байх нь тохиромжтой хэмээн үзсэн байв.⁶⁹

Сургуулийн оптимал хэмжээ, бүлэг дүүргэлтийн дундаж шаардлагыг заахгүй байх нь төвлөрлийг сааруулах бодлогын үед тодорхой бус байдал үүсгэж, хариуцлагыг сулруулж, үр ашгийг бууруулдаг гэж зарим орны практикт хийсэн тойм судалгаанаас дүгнэж болохоор байна.⁷⁰

ЭЗХАХБ-ын орнуудад 300 болон түүнээс цөөн суралцагчтай бол “жижиг сургууль” гэж үздэг юм байна. Харин дунд сургууль 660 орчим, ахлах сургууль 920 орчим суралцагчтай бол “дундаж хэмжээтэй” сургууль гэж үзжээ.⁷¹

Монгол Улсын сургуулийн **дундаж хэмжээг** 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтээр тооцвол:

- Багийн баг сургуульд 33, сумын бага сургуульд 60,
- Сумын дунд сургуульд 254, сумын ерөнхий боловсролын сургуульд 671,
- Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуульд 1359,
- Нийслэлийн ерөнхий боловсролын сургуульд 2291⁷² суралцагч элссэн байна.

68 Economies of scale

69 Andrew et.al (2002)

70 OECD (2018)

71 PISA (2018)

72 Онцгой утгыг (outlier 6109) оруулж тооцов.



Хүснэгт 1.4 Дундаж болон хамгийн бага элсэлт

Avg. Нийт Суралцагч

33 2,291

Сургуулийн Ангилал	Байршил I				
	Аймгийн төв	Баг	БШУЯ	Сумын төв	Хороо
Бага сургууль /1-5 дугаар анги/		33		60	447
Дунд сургууль /1-9 дүгээр анги/		119		254	267
Дунд-ахлах сургууль /6-12 дугаар анги/	201		344	81	58
Ахлах сургууль /10-12 дугаар анги/					290
Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар анги/	1,359	445		671	2,291

Min. Нийт Суралцагч

7 295

Хамгийн бага элсэлт

Сургуулийн Ангилал	Байршил I				
	Аймгийн төв	Баг	БШУЯ	Сумын төв	Хороо
Бага сургууль /1-5 дугаар анги/		7		29	224
Дунд сургууль /1-9 дүгээр анги/		63		83	210
Дунд-ахлах сургууль /6-12 дугаар анги/	174		295	81	20
Ахлах сургууль /10-12 дугаар анги/					70
Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар анги/	213	192		113	130


Багийн бага сургуулийн дундаж элсэлт 33 суралцагч, хамгийн бага элсэлт 7 суралцагч байна. Боксплотын утгын хязгаар 7-75, медиан хэмжээ их доогуур байгаа учраас хамгийн бага хэмжээнээс I квартилийн хооронд байгаа сургуулиуд дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй.⁷³

Сумын төвийн дунд сургуулийн элсэлтийн боксплотын хязгаар өргөн, тархалт хэд хэдэн “бүлэг” хэлбэртэй, медиан хэмжээнээс хамгийн их утга хүртэлх тархалт их байна.

73 Нийслэлийн Хан-уул дүүргийн зуун гучдугаар сургууль 930 суралцагчтай (outlier) бөгөөд бага сургуулийн боксплотыг илүү тод харуулахын тулд тархалтын зургаас хасав.




Зураг 1.1 Төрийн өмчийн бага, дунд сургуулиудын элсэлтийн тархалт



Харин 1-12 ангитай ерөнхий боловсролын сургуулийн хувьд бүх байршилд боксплотын хязгаар өргөн, сарнилт ихтэй харагдаж байна. Жишээ нь сумын төвийн ерөнхий боловсролын сургуулийн хамгийн бага элсэлт 113 байхад их элсэлт 2912 байв.



Зураг 1.2 ЕБС-ийн элсэлтийн тархалт




Жижиг сургуульд сургуулийн барилга, талбайн ашиглалт тааруу, нэг ажилтны үйлчлэх хүний тоо цөөн тул төсвийн хөрөнгийн үр ашиг доогуур байдаг гэж тооцдог. Жижиг сургуульд үнэн хэрэгтээ бүх төрлийн нөөц хязгаарлагдмал. Ерөнхий боловсролын нэг суралцагчид ногдож буй зардлын ялгааг жишээгээр харуулав. Сургуулиуд нь ерөнхийдөө “жижиг” ангилалд багтахар бол нэг суралцагчид ногдох байр ашиглалт, захиргаа аж ахуйн зардал зэрэг үйл ажиллагааны тодорхой цар хүрээнд тогтмол шинжтэй зардал өндөр гарна.

Тухайлбал 2019-2020 оны хичээлийн жилд Дорнод аймгийн нэг сургуулийн дундаж элсэлт 738 бол, Дундговь аймагт 445 байв. Энэ нь нэг хүүхдэд ногдох байр ашиглалтын зардал ялгаатай байхад хүргэж байна. Нэг сургуульд ногдох зардлаар харвал Булган, Дундговь аймгууд жагсаалтын дунд байгаа хэдий ч нийт сургуулийн элсэлт доогуур учраас тогтмол шинжтэй байр ашиглалтын болон үйл ажиллагааны зардал өндөр гарч “үр ашиг муутай ажиллаж байгаа” гэж харагддаг.



Зураг 1.3 Байр ашиглалтын дундаж зардал



Сургууль том байх тусмаа нөөц, сонголт, боломж нэмэгдэж, боловсролын үр дүн сайн байх хандлагатай байна гэж дүгнэсэн судалгаа олон бий.⁷⁴ Гэхдээ 1200-аас дээш хүүхэдтэй том сургуульд ч асуудал үүсдэг байж магадгүй.⁷⁵ Тухайлбал суралцагч, багшийн аль алиных нь зан төлөв, хандлага хэт том сургуульд сулардаг бол жижиг сургуульд уур амьсгал илүү эерэг байжээ.⁷⁶ Мөн боловсролын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаанд сургуулийн хэмжээ сургалтын үр дүнд эергээр нөлөөлөх оптимал хэмжээг 680-960 гэж тогтоосон судалгаа бий.⁷⁷

74 Тухайлбал PISA (2015): Across OECD countries, students in larger schools score higher in science and are more likely to expect to work in a science-related career than students in smaller schools.

75 Тухайлбал: Ares Abalde (2014) School size policies

76 OECD (2016)

77 Hattie & Clarke (2018)



1.3.2 Хоёр ээлжээр хичээллэх

Сургуулийн барилгын ашиглалтыг нэмэгдүүлэх өөр нэг арга нь ээлжээр хичээллэх юм. Хөгжилтэй орнуудад хоёр ээлжээр хичээллэх аргыг бараг хэрэглэдэггүй.⁷⁸ Ээлж нь шинээр барилга барих боломжгүй үед авах арга хэмжээ бөгөөд боловсролын төлөвлөлт оновчтой бол ийм байдалд орох нь тун ховор гэжээ.⁷⁹ Ээлжээр хичээллэхийг газар, барилга, тоног төхөөрөмж гээд бүх төрлийн нөөцийн ашиглалтыг сайжруулах, бүлэг дүүргэлтийг бууруулах арга болгон бид ашигладаг. Чили улс 1996 онд хоёр ээлжээсээ “бүтэн өдрийн сургууль”-руу шилжиж, сургалтын цаг, хичээлийн гадуурх үйл ажиллагааг нэмэгдүүлж чадсан аж.⁸⁰ Энэ шинэчлэлд ихээхэн хөрөнгө оруулалт шаарджээ. Үүний үр дүнд математик болон хэлний хичээл дээр сурлагын амжилт ахисан нь судалгаагаар нотлогдсон байна.⁸¹ Казахстан улс төвлөрсөн газруудад сургуулийн ээлжийг багасгах хөрөнгө оруулалт хийж, нийт 106 сургууль барьснаар 2007-2011 онд 3 ээлжээр хичээллэж байсан сургуулийн тоог эрс бууруулсан байна.⁸²

Олон ээлжээр хичээллэх нь сургуулийн барилга, тоног төхөөрөмжийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлдэг ч, багшийн хичээл заах цаг, суралцагчидтайгаа ажиллах цаг багасдаг. Мөн хичээл хоорондын завсарлага багасах, тусламж хэрэгтэй суралцагчдад зарцуулах цаг, анхаарал буурснаар стресс ихтэй суралцах орчин болж хувирна. Зүүн Европын орнуудад хийсэн судалгаагаар үдээс хойших ээлжид хичээллэдэг суралцагчдын үнэлгээ бага зэрэг доогуур байсан бөгөөд энэ нь багш, суралцагчийн аль аль нь ядарсан эсвэл хичээлийн дараа давтах, зөвлөгөө авах, өгөх цаг бага байсантай холбоотой байж магадгүй гэж дүгнэжээ.⁸³ Иймд зарим сургууль ээлжийг сольж хичээллүүлэх болсон байна. Хамгийн гол асуудал нь ээлжээр хичээллэх үед гэрийн даалгавар их байхаас өөр аргагүй болдог.⁸⁴ Ихэнх улс хоёр ээлжээр хичээллэхийг түр зуурын арга хэмжээ гэж үзсэн байв.⁸⁵ Ээлжээр хичээллэх нь эцэг эхийн сэтгэлд нийцэхгүй үйлчилгээ юм.⁸⁶

Гэтэл манай тохиолдолд зарим сургууль хүчин чадал ашиглалтын коэффициент нь 1-ээс бага байхад ч хоёр ээлжээр хичээллэдэг. Үүнд багшийн хүрэлцээ, хичээлийн хуваарь хийх арга нөлөөлдөг байж магадгүй. Дараах хүснэгтэд 2020-2021 оны хичээлийн жилийн мэдээгээр хүчин чадал ашиглалт нь доогуур байгаа хэр нь 2 ээлжээр хичээллэж эхэлсэн сургуулиудыг харуулав.

78 Bray, M (2008)

79 Bray, M (2008)

80 Santiago et.al (2017): All day school

81 Bellei (2009) in OECD (2018)

82 World Bank (2015)

83 Lusher & Yassenov (2016)

84 Bray, M (2008)

85 Sagyndykova, G (2013)

86 Linden, T (2001) & Sagyndykova, G (2013)



Хүснэгт 1.4 ХЧА 1-ээс бага боловч 2 ээлжээр хичээллэж буй сургуулиуд

Байрлал	Нэр	Хүчин чадал ашиглалт /барилгын хүчин чадлаар/	Хүчин чадал ашиглалт /хичээл хийх ангиар/	Хүчин чадал ашиглалт /сургалтын танхимаар/	II ээлжинд хичээллэж буй бүлгийн жин
Архангай аймаг	Ар. Батцэнгэл сумын ерөнхий боловсролын сургууль	0.7	0.91	0.74	0.24
Архангай аймаг	Ар. Хашаат сумын ерөнхий боловсролын сургууль	0.81	0.91	0.75	0.20
Архангай аймаг	Ар. Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургууль	0.6	0.31	0.27	0.19
Баян-Өлгий аймаг	Бө.Ногооннуур сумын ерөнхий боловсролын хоёр дугаар сургууль	0.34	0.56	0.27	0.60
Баян-Өлгий аймаг	Бө.Цагааннуур тосгоны ерөнхий боловсролын сургууль	0.53	0.77	0.51	0.60
Баян-Өлгий аймаг	Бө.Ногооннуур сумын ерөнхий боловсролын гурав дугаар сургууль	0.75	0.83	0.31	0.40
Баянхонгор аймаг	Бх.Бууцагаан сумын Баян бүрд багийн ерөнхий боловсролын сургууль	0.68	0.20	0.03	0.25
Булган аймаг	Бү.Сэлэнгэ сумын Ерөнхий боловсролын сургууль	0.75	0.61	0.38	0.17
Говь-Алтай аймаг	Гв.Гуулин багийн ерөнхий боловсролын сургууль	0.43	0.80	0.30	0.25
Говь-Алтай аймаг	Гв.Бугат сумын ерөнхий боловсролын сургууль	0.49	0.94	0.53	0.47
Дундговь аймаг	Ду.Далгархангай сумын ерөнхий боловсролын сургууль	0.78	0.96	0.55	0.09
Завхан аймаг	Зв.Цагаанхайрхан сумын ерөнхий боловсролын сургууль	0.32	0.90	0.29	0.44
Завхан аймаг	Зв.Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургууль	0.85	0.63	0.38	0.47
Өвөрхангай аймаг	Өв.Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургууль	0.4	0.54	0.29	0.15
Өвөрхангай аймаг	Өв.Эүүнбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургууль	0.87	0.80	0.58	0.31
Сүхбаатар аймаг	Сү.Наран сумын ерөнхий боловсролын сургууль	0.81	0.91	0.72	0.10
Сэлэнгэ аймаг	Сэ.Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль	0.75	0.93	0.60	0.08
Төв аймаг	Тө.Цэцл сумын ерөнхий боловсролын сургууль	0.72	0.74	0.60	0.25
Ховд аймаг	Хо.Дөргөн сумын ерөнхий боловсролын сургууль	0.83	0.83	0.64	0.17
Ховд аймаг	Хо.Мөст сумын ерөнхий боловсролын сургууль	0.78	0.93	0.68	0.16
Хөвсгөл аймаг	Хө.Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургууль	0.63	0.77	0.56	0.09
Хөвсгөл аймаг	Хө.Мөрөн сумын ерөнхий боловсролын Ирээдүй хорин нэгдүгээр зуун сургууль	0.84	0.79	0.60	0.03
Хөвсгөл аймаг	Хө.Ханх сумын ерөнхий боловсролын сургууль	0.76	0.22	0.18	0.29
Хэнтий аймаг	Хэ.Биндэр сумын ерөнхий боловсролын сургууль	0.56	0.70	0.59	0.42
Хэнтий аймаг	Хэ.Батноров сумын Бэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль	0.4	0.42	0.31	0.45
Хэнтий аймаг	Хэ.Галшар сумын ерөнхий боловсролын сургууль	0.58	0.82	0.49	0.38
Дархан-Уул аймаг	Да.Хонгор сумын Ерөнхий боловсролын арван нэгдүгээр сургууль	0.52	0.59	0.42	0.31
Сүхбаатар дүүрэг	СБД-ийн Монгол Улсын Консерватори	0.52	0.20	0.18	0.45
Сүхбаатар дүүрэг	СБД-ийн ерөнхий боловсролын лаборатори өсвөрийн зохион бүтээгчдийн ахлах сургууль	0.71	0.64	0.57	0.38
Багахангай дүүрэг	БХД-ийн ерөнхий боловсролын хангай цогцолбор сургууль	0.83	0.97	0.71	0.47
Орхон аймаг	Ор.Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль	0.84	0.90	0.78	0.16
Орхон аймаг	Ор.Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	0.87	0.92	0.84	0.49

Улс орнууд хүчин чадал ашиглалтын хязгаар тогтоож сургалтын орчныг төлөвлөдөг. Жишээ нь АНУ-д төрийн өмчийн сургуульд хүчин чадал ашиглалтын коэффициент нь 80-94% байвал хангалттай гэж үзжээ⁸⁷

87 <https://edscape.dc.gov>. Зарим улс 95%-д хүргэнэ гэсэн зорилт тавьсныг хэт өндөр байна хэмээн ихээхэн шүүмжилсэн байв.




Хүснэгт 1.6 АНУ-ын төрийн өмчийн сургуулиудын хүчин чадлын үзүүлэлт

Нийт хүчин чадал ашиглалт (хча)	Үнэлгээ	Танхимаар тооцсон хүчин чадал ашиглалт (үйл ажиллагааны хүчин чадал)
>95	Хүрэлцээгүй	>110
90-94	Хүрэлцээ муудаж байгаа	100-109.9
70-89	Хэвийн	85-99.9
60-69	Үр ашиг тааруу	70-84.99
<60	Үр ашиг муутай	<70

Эх сурвалж: Laurie Lewis, Kyle Snow, Elizabeth Farris, Becky Smerdon, Stephanie Cronen, Jessica Kaplan, [Condition of America's Public School Facilities: 1999](#) (NCES 2000-032) (Washington, DC: U.S. Department of Education, 2000).

Манай улсын төрийн өмчийн сургуулийн 55 хувьд нь ашиглалтын коэффициент 1.1-ээс дээш байна. Хүчин чадал ашиглалтын коэффициент 1.1-ээс дээш бол нэг ээлжээр хичээллэх боломжгүй.⁸⁸ Мөн II ээлжинд нийт суралцагчдын 50-иас дээш хувь нь хичээллэж байгаа төрийн өмчийн сургууль 16 байна.

Зураг 1.4 Ашиглалтын коэффициент өндөр байгаа сургуулийн байршил



88 Биеийн тамирын заал, урлагийн заалыг ашиглах боломжтой тул хичээл хуваарь хийж үзэхэд онолын хүчин чадлаар болон 30 хүүхэд нэг ангид хичээллэх боломжтой танхимыг тооцож гаргасан хүчин чадал ашиглалтын коэффициент 1.1 байхад 1 ээлжээр хичээллэх боломжтой байдаг. Гэхдээ цаашид ХЧА-ын коэффициент 1 бол нэг ээлжээр хичээллэж боломжтой гэж үзье.



1.3.3 Бүлэг дүүргэлт, багш-суралцагчийн тооны харьцаа

Бүлэг дүүргэлтийг сургуулийн зохион байгуулалт, төлөвлөлтийн шийдвэрт дараах зорилгоор хэрэглэдэг. Тухайлбал:

- Боловсролын нийлүүлэлтийг төлөвлөхөд хэрэглэдэг (Бүлэг дүүргэлтийн доод хэмжээг заах).
- Бүлэг дүүргэлтийг зарим улс онолын хувьд шаардлагатай багшийг тооцоход хэрэглэдэг⁸⁹ (Бүлэг дүүргэлтийн дундаж хэмжээг заах).
- Санхүүжилтийг тооцоход хэрэглэдэг (Бүлэг дүүргэлтийн дээд, доод хэмжээг заах).

Зарим улс бүлэг дүүргэлтийн шаардлагыг сургуулийн хэмжээтэй уялдуулсан байна. Тухайлбал Эстони улс ахлах сургуулийн бүлэг дүүргэлтийг дараах байдлаар тогтоожээ.

Хүснэгт 1.7 Эстони улсын ахлах сургуулийн хэмжээ болон бүлэг дүүргэлт

Хэмжээний ангилал	Суралцагчийн тоо	Бүлэг дүүргэлтийн дээд хэмжээ
Жижиг сургууль	252 болон түүнээс цөөн суралцагчтай	28
Дунд хэмжээний сургууль	360 орчим суралцагчтай	30
Том хэмжээний сургууль	540-760 орчим суралцагчтай	36


Эх сурвалж: Santiago et al. (2016)

Бүлэг дүүргэлтийн дээд хэмжээг заадаг практикаас гадна хамгийн бага хэмжээг заадаг улс орон байна. Үүнийг жижиг анги үүсгэхээс, сургалтын чанар тааруу байгаагаас шалтгаалан суралцагчид өөр сургууль руу шилжин суралцсаар байхад ч сургууль үр ашиггүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байхаас сэргийлэх зорилгоор хэрэглэдэг. Хүн ам сийрэг суурьшсан оронд үүнийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэдгийг манай улсын туршлага харуулна. Жишээ нь 2020-2021 оны элсэлтээр төрийн өмчийн сургуулиудын дундаж бүлэг дүүргэлт 7-36 байна.

89 Nusche et. al (2016)



Зураг 1.5 Дундаж бүлэг дүүргэлт




Бага сургуулийн хувьд бүлэг дүүргэлтийн тархалтын I-III кватиль хоорондын зай хол, боксплотын хязгаар өргөн байна. Харин дунд сургуулийн хувьд нийт боксплотын хязгаар харьцангуй бага, медиан дээрх тархалт өндөр байна. 1-12 ангитай ерөнхий боловсролын сургууль дээр боксплотын хязгаар хэт өргөн, бүх кватильд тархалт өндөр, медианаас хамгийн их хэмжээ хүртэл тасралгүй үргэлжилсэн, бас тархалт шигүү байна.







Зураг 1.6 Бүлэг дүүргэлтийн тархалт




Бага ангийн бүлэг дүүргэлтийн тархалт



Ахлах ангийн бүлэгт дүүргэлтийн тархалт



Дунд ангийн бүлэг дүүргэлтийн тархалт




Байршил I
 ■ Аймгийн төв
 ■ Баг
 ■ Сумын төв
 ■ Хоргоо




Багш суралцагчийн тооны харьцаа, бүлэг дүүргэлтийг харьцуулах нь сургуулиудад байгаа багшийн нөөцийг, мөн ашиглах боломжтой хүчин чадлыг харуулдаг.⁹⁰ Бүлэг дүүргэлт болон нэг багшид ногдох суралцагчийн тооны хамаарал хүн ам багатай улс орнуудад сул байдаг.⁹¹ Манай улсын төрийн өмчийн сургуулиудад энэ хамаарал хүчтэй (Cor [1] 0.9055622) байна.

Зураг 1.7 Сурагч-багшийн тооны харьцаа болон бүлэг дүүргэлтийн хамаарал



Зураг 1.8 Бүлэг дүүргэлт, сурагч-багшийн тооны харьцааны хамаарал (ПИСА 2018)



Эх сурвалж: OECD, PISA (2015) Database, Table II.6.26

90 The comparison of student-teacher ratios and class size can provide a measure of the spare teacher resource capacity within schools.

91 OECD (2017) Education at a Glance



ЭЗХАХБ-ын орнуудын дунджаас харахад, бүлэг дүүргэлт болон нэг багшид ногдох суралцагчийн тоо нь нийгэм-эдийн засгийн хувьд давуу талтай сургуулиуд, мөн төвлөрсөн газрын сургуулиуд, төрийн өмчийн сургуулиудад өндөр байжээ.⁹²

Сүүлийн үед бүлэг дүүргэлтийг боловсролын үр дүнд нөлөөлөх орцын хүчин зүйл болгон үзэх нь эрс багассан. Бүлэг дүүргэлтийг орц болгон үзэж хөрөнгө оруулалтыг төлөвлөх нь “хүүхэд цөөтэй ангид хүүхэд бүрд ногдох багшийн цаг их, анхаарал сайн байна, үүнээс улбаалан үр дүн сайн байна” хэмээх таамаглалд үндэслэдэг.⁹³ Нөгөө талаар бүлэг дүүргэлтийг багасгах хөрөнгө оруулалт хийснээс өөр төрлийн буюу багшийн цалин урамшуулал, багшийн хөгжил, мэргэшил, багшлахуйн чадвар, туслах багш хөлслөх зэрэг бусад хүчин зүйлд анхаарах нь илүү үр дүнтэй гэж дүгнэсэн судалгаа олон бий.⁹⁴ Анги ахих бүрд бүлэг дүүргэлтийн нөлөө бага байна гэсэн дүгнэлт ч гарч байна.⁹⁵ Хамгийн сүүлийн ТАЛИС (TALIS) багш нарыг ажилдаа сэтгэл дундуур байхад хүргэдэг гол хүчин зүйл бол анги хэдэн хүүхэдтэй байх нь биш харин анги доторх уур амьсгал, хүмүүжилгүй буюу зан төлөвийн асуудалтай хүүхдүүд юм гэж хариулжээ. Иймд багш нарыг “хүнд сорилттой нөхцөлд ажиллах” чадамжтай болгон бэлтгэх зөвлөмж өгч байна.⁹⁶ Калифорнийн бүлэг дүүргэлтийг багасгах хөтөлбөрөөс боловсролын салбар ихээхэн сургамж авсан.

1.3.4 Хамран сургах тойрог болон сонголт

Сургуулийн сонголтыг дэмжих үндэслэл нь зах зээлийн зарчимд найдах явдал юм. Сонголтыг ваучерын механизм, татварын хөнгөлөлтөөр дэмждэг.⁹⁷ Гэхдээ энэ нь гол төлөв хувийн сургуулийн өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн бодлого байдаг. Уг нь сонголтыг нэмэгдүүлэх нь хувийн хэвшлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх тухай асуудал биш юм. Төрийн өмчийн боловсролын системд хэрэглэгчийн шаардлагад нийцсэн олон төрөл хэлбэрээр сургуулийг зохион байгуулж суралцагч, эцэг эхэд сонголт хийх боломж бүрдүүлэх ёстой. Төрийн өмчийн сургууль энгийн, магнет, лицей, авьяастны,⁹⁸ тусгай, гүнзгийрсэн, төрөлжсөн, зарим улсад боардинг,⁹⁹ чартер сургууль,¹⁰⁰ мэргэжлийн сургалттай гэх мэт олон төрлөөр сургалт санал болгож, аль болох олон суралцагч татахыг хичээдэг.

Сургууль сонголтын талаарх арга хэмжээг сайтар судалж төлөвлөхгүй бол нийгэмд ялгаа үүсгэдэг гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрсөн байна.¹⁰¹ Мөн сургуулиуд шалгалт авах хэлбэрээр элсүүлэх эрх чөлөөтэй байвал “сайныг нь түүх” (cream skimming), хүүхдэд багаас нь ялгаварлал мэдрүүлэх зэрэг сөрөг хандлагад

92 OECD, PISA (2015)

93 Dynarski, J et.al (2013)

94 Жишээ нь Hattie (2009, 2018)

95 Wobsmann & West (2006), Howley and Howley (2004): In general, secondary school students tend to benefit more from larger schools than primary school pupils, and low-income and minority students appear to perform better in smaller schools.

96 TALIS (2018)

97 Musset, P (2012)

98 Жишээ нь SAMPAD

99 Boarding schools are relatively more prevalent in the United Kingdom (UK), India, China, and parts of Africa.

100 менежментийн гэрээгээр төрийн өмчийн сургуулийг ажиллуулах

101 <https://www.cato.org/commentary/segregation-school-choice-movement>



хүргэдэг.¹⁰² Сургуулийн сонголтыг үр дүнтэй болгохын тулд төрийн зүгээс нийгэм эдийн засгийн хувьд сул байдалд байгаа хэсгээ илүү дэмжих чиглэл баримтлах хэрэгтэй гэжээ.¹⁰³ Гэхдээ нийгэм эдийн засгийн хувьд сул нөхцөлд байгаа гэр бүлд сонголт хийх эрх чөлөө байсан ч сонголтод нөлөөлөх хүчин зүйлийн талаар зөв дүгнэлт хийж чаддаггүй гэсэн судалгааны дүгнэлт ч байна.¹⁰⁴

Иймд суурьшилд-суурилсан төлөвлөлтийн хэлбэрийг боловсролд өргөн хэрэглэдэг. Тухайлбал ЭЗХАХБ-ын орнуудад хийсэн судалгаанд хамрагдсан 33 орны 27 нь энэ аргаар төлөвлөж байна.¹⁰⁵ Суурьшилд суурилах нь суралцагчид амьдардаг газартайгаа ойрхон байгаа сургуулийг сонгох үйлдэлд хөтөлнө. Хамран сургах тойрог зааснаар хүний эрхийг зөрчиж, төрийн бодлогоор үр дүн муутай сургууль оршин тогтносоор байхыг урамшуулдаг хэмээн шүүмжилдэг ч газарзүйн байршлаар хамран сургах тойрог тогтоосноор ялангуяа бага насны хүүхдүүдийн хувьд чухал гэж үздэг. Гэхдээ хамран сургах тойрогт нь хэд хэдэн сургууль байх бөгөөд тэр дундаас сонгох эрхтэй байдаг туршлага элбэг байв.¹⁰⁶ Харин академик шинжтэй ахлах сургуулийн хувьд нутаг дэвсгэр хамааралгүй сонголт хийх эрх өгдөг байна. Суурьшилд суурилсан ийм систем оршин суугчдын дунд нийгмийн ялгаварлал үүсгэх үү гэдэг асуулт мөн л гардаг.

Ийм хэлбэрийн төлөвлөлтөд хамран сургах тойрог тогтоох асуудал хамгийн чухал бодлого болж хувирах бөгөөд ихэнхдээ газар нутгийн хил хязгаарыг дагадаг. Гэхдээ сүүлийн үед энэ зарчмыг эвдэх хандлагатай байна. Хамран сургах тойрог хэт ачаалалтай бол хөршийн нутаг дээрх сургууль хамран сургах тойрогт багтах нь бий. Жишээ нь Австрийн Вен хотын хамран сургах тойрогт хөрш хоёр дүүргийн сургуулийг ч багтаадаг ажээ.¹⁰⁷ Мөн улс орнууд хамран сургах тойргийг ойр ойрхон шинэчилдэг байна.

1.3.5 Суурьшлын ялгаа

Суурьшлын ялгаа нь боловсролын үр дүнд нөлөөлөхгүй байвал боловсролын системийг үр дүнтэй ажиллаж байна гэж дүгнэдэг болжээ.¹⁰⁸

Орон нутгийн сургуулиуд хүчин чадлын илүүдэлтэй байхад хот суурин газар хүчин чадал хүрэлцэхгүй байх бэрхшээл манай улсад ч гардаг. Орон нутгийн сургуулиудын бүтэц, суралцагчдын аж байдал, нийгэм эдийн засгийн орчин нь ихээхэн ялгаатай, бэрхшээл ихтэй.¹⁰⁹ Ийм ялгаатай байдал нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, хаана амьдарч байгаагаас үл хамааран чанартай боловсрол

102 Шалгалт авч элсүүлэхийг улс орнууд хориглодог байна. Үүний оронд эхлээд бүртгүүлснийг авах, тойргийн хүүхдээ авах, ах эгч нь сурч байсныг авах, квот тогтоох гэх мэт өөр арга хэрэглэхийг санал болгожээ. Жишээ нь Бельги улсын сургуулийн сонголтын талаар хийсэн сүүлийн 2 удаагийн шинэчлэл нь ийм зорилготой юм байна.

103 Nusche et.al (2009)

104 Schneider, P. et.al (2000)

105 OECD (2011)

106 Жишээ нь Австри, Дани

107 Nusche et.al (2016)

108 OECD 2016)

109 OECD (2018)



эзэмших боломжийг бүх суралцагчдад олгох зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Дэлхийн аль ч улсад хотжилт явагдаж 2019 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 66 орчим хувь нь хотод амьдардаг болсон байна.¹¹⁰ Хотжих үзэгдэл зарим оронд сүүлийн 10 жилд эрчимтэй явагдсан аж. Тухайлбал Япон, Турк, Польш, Унгар улс.¹¹¹

Суурьшлыг сийрэг, хүн ам цөөтэй гэж ангилах нь улс орон бүрийн хувьд ялгаатай. ПИСА олон улсын шалгалтад 3000-аас доош хүн амтай тосгон, 3000-15000 хүнтэй суурьшлын төвийг “жижиг” гэж үзжээ. Гэтэл манай улсын сумдын дундаж хүн ам 2600 орчим байна.¹¹²

Суурьшлын ялгаа боловсролын үр дүнд нөлөөлж байна. Тухайлбал:

- ПИСА 2015: Шинжлэх ухааны хичээл дээр ерөнхийдөө хөдөөгийн сургуулийн хүүхдүүд хотын үе тэнгийнхнээсээ 31 функтээр доогуур үнэлэгдсэн. Энэ ялгаа нь 1 жилээр хоцорч байгаатай дүйцэхээр юм.¹¹³ Зарим оронд 50 функтээр (Чили, Чех, Унгар, Итали, Турк, Словак гэх мэт) ялгаатай байсан бол зарим улсад бараг ялгаагүй (Финлянд, Герман, Израйл), мөн орон нутгийн хүүхдүүд нь илүү (Их Британи, АНУ) байх цөөн тохиолдол байв.
- Орон нутгийн сургуулийн төгсөгчид шинжлэх ухааны мэргэжил сонгох нь бага байна.¹¹⁴
- Орон нутгийн сургуулийн хамран сургалт, төгсөлтийн жин хотын үе тэнгийнхнээс тааруу байна гэж гарсан судалгаа элбэг байна.¹¹⁵
- Орон нутгийн жижиг сургуульд авьяаслаг хүүхдүүд хохирдог.¹¹⁶

Боловсролын үр дүнд гарч буй ялгааг тайлбарлах гол хүчин зүйл нь судлаачдын ажигласнаар

- Томоохон хэсгийг эцэг эхийн эдийн засаг, нийгэм, соёлын статусаар¹¹⁷ тайлбарладаг.

110 <https://data.worldbank.org/indicator/SP.RUR.TOTL.ZS>

111 World Bank: data.worldbank.org

112 2020 оны хүн амын мэдээгээр: Аймгийн төвүүдийг оруулахгүй тооцвол

113 OECD (2018), PISA (2015) Database

114 PISA (2015)-аас шинжлэх ухааны мэргэжлийн жагсаалтыг харна уу.

115 Жишээ нь: USA Department of Agriculture (2017)

116 Puryear & Kettler (2017)

117 Economic, social and cultural status (ESCS)- Жишээ нь Эцэг эхийн боловсрол тааруу байдаг нь нөлөөлдөг (Bertolini et.al, 2008):



- Боловсролын үр дүнд хамт олны нөлөө (peer effect) өндөр гардаг болсон. Хүүхдүүд хамтдаа сурч, хөгждөг болсон энэ цаг үед найз нарынх нь хүсэл тэмүүлэл, хандлага, чадвар ихээхэн нөлөөтэй.¹¹⁸
- Орон нутагт мэргэжлийн багшийн хангамж асуудалтай байдгаас ялгаа үүсч байна.¹¹⁹ Мөн мэргэжлийн багш нар нэг нэгнээсээ суралцах, хамтдаа хөгжиж, хамтдаа ажиллах боломж бага.¹²⁰
- Хотын сургуульд зааж буй хичээлийн төрөл олон, ялангуяа төрөлжсөн болон хувийн сургуулиуд сургалтын хөтөлбөрөөр суралцагчдыг татдаг. Мөн сургуулиас өөр хэлбэрээр төрөл бүрийн сургалтад хамрагдах боломжтой. Нэмэлт хичээлд суух нь сурлагын амжилт, дараагийн шатны боловсролд нөлөөлдөг чухал хүчин зүйл болох нь судалгаагаар тогтоогдсон.¹²¹
- Хичээлийн дараах үйл ажиллагаа, хүүхдийг хөгжүүлэх арга хэмжээ явуулах нөөц бололцоо, орон нутагт бага байна. Тухайлбал шинжлэх ухааны дугуйлан, спортын клуб, секц, нийгэмших үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн дадлага хийх боломж (дэд бүтцийн болон санхүүгийн) бага байна.¹²² Хэт дүүрснээс шалтгаалан том сургуульд ч тэгш боломж багасдаг.¹²³

Манай улсад суурьшлын ялгаа боловсролын үр дүнд нөлөөлж байгааг тогтоосон судалгаа одоогоор байхгүй. Хүн амын боловсролын түвшин хот, хөдөөд ялгаатай байгааг ажиллах хүчний судалгаанаас харж болдог. Гэхдээ тэр нь амьдрах хэв маягийн ялгаа юм.

Сонголт, өрсөлдөөнийг дэмжих, төрөөс хувийн сургуульд санхүүжилт олгох бодлогын гол зорилго бол суралцагчдад тэгш боломж олгох юм. Энэ зорилго хэрхэн биелж байгааг хувийн сургуулийн байршлаас баримжаалж болох талтай. Өөрөөр хэлбэл хувийн сургуулийн байршил нь тэгш боломж биш харин ч эсрэгээрээ суурьшлаас шалтгаалсан боловсролын ялгаанд хувь нэмэр оруулж байгаа байж магадгүй.

118 OECD (2019)

119 Bertolini et.al (2008), Pisano., et.al (2008)

120 Ares Abalde (2014)


121 Irvin et.al (2017)

122 Тухайлбал, ЭЗХН-ийн орнуудад 15 настай суралцагчдын 29 хувь нь шинжлэх ухааны дугуйланд явсан бол төвлөрсөн газрын суралцагчдын 40 хувь нь хамрагдсан байв (OECD, 2016).

123 Leithwood & Jantzi (2009)




Зураг 1.9 Хувийн сургуулийн байршил





Зураг 1.10 Нийслэл дэх сургуулиудын байршил



2019-2020 оны элсэлтийн мэдээнээс харахад Сонгинохайрхан дүүрэгт хувийн сургууль цөөн байна. Нийслэлд 2020-2021 оны хичээлийн жилийн мэдээгээр 136 хувийн сургууль үйл ажиллагаа явуулж байснаас тус дүүрэгт 8 байна.



Хүснэгт 1.9 Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг

Дүүрэг	Төрийн бус өмчийн сургууль	Төрийн бус өмчийн цэцэрлэг	2020-2021 оны хичээлийн жилд хувийн сургуульд элссэн	2020-2021 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн цэцэрлэгийн элсэлт
Чингэлтэй	10	18	1239	1262
Баянзүрх	30	145	13385	10990
Хан-уул	27	98	9583	7131
Багануур	1		179	
Сүхбаатар	26	32	9290	1805
Налайх	3	5	210	280
Баянгол	29	64	5059	3764
Багахангай	0			
Сонгинохайрхан	8	61	1271	4497
Нийт	134	423	40,216	29,729

1.3.6 Ирээдүйн хэрэгцээг таамаглах

Ирээдүйн хэрэгцээг таамаглах, төлөвлөхөд дараах аргыг бид дангаар нь эсвэл холимог байдлаар ашигладаг.¹²⁴ Үүнд:

- Хүн ам зүйг дагасан загвар (Demographic Model)
- Санхүүгийн буюу төсвийн загвар

Боловсролыг төлөвлөхдөө хүн амзүйн хөгжил, өөрчлөлтийг дагасан хэлбэрээр, төсвийг санхүүгийн загвараар боловсруулдаг нь эдгээрийг уялдуулахад төвөгтэй байсаар ирсэн шалтгаан юм.

Хүн амзүйг дагасан загвар нь боловсролын бодлогын талаарх шийдвэрийг тоон утгатай болгох зорилготой, мөн 3 үндсэн үе шаттай. Үүнд:

1) Эрэлт, хэрэгцээ – 2) Нийлүүлэлт = 3) Шаардлагатай хөрөнгө оруулалт

Харин төсвийн загвар нь 1) төсвийн хязгаар тогтоох (улсын төсвийн тодорхой хувийг зарцуулах), 2) энэ хязгаарт тохируулан боловсролын үзүүлэлтүүдийг төлөвлөх, 3) тухайн төсвөөр хийж чадах ажлын хэмжээг гаргах алхамтай.

Боловсролын орчин тогтмол өөрчлөгдөж байгаа үед төлөвлөлтийг уламжлалт аргаар үргэлжлүүлэн хийх боломжгүй гэж үзэх болсон.¹²⁵ Ялгаатай нөхцөл байдал, ялгаатай асуудалд өөр өөр арга хэрэглэхийг зөвлөж байна. Жишээ нь:

¹²⁴ Төлөвлөлтийн олон арга байдгаас сүүлийн үед энэ хоёр аргыг төсвийн үйл ажиллагаанд хэрэглэж байна.

¹²⁵ Foresight Toolkit U.K. and The AC/UNU Millennium Project: business as usual is no longer an option in education planning



- Дэлпи (The Delphi)- Экспертийн дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргах
- Стратегийн үүднээс урьдчилан харах (Strategic foresight) –Хэтийн төлөвийг шинжих (Horizon scanning)
- Хандлагын үр нөлөө (Trend impact)- Түүхэн мэдээллийг ашиглан ирээдүйг таамаглах

Хэтийн төлөвийг шинжих (Horizon scanning) аргыг дээд боловсролын бодлого боловсруулахад түлхүү, Дэлпи аргыг бүсийн хөгжлийн бодлого, хүн амд суурилсан төлөвлөлт хийх, эсвэл томоохон хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд, харин хандлагын үр нөлөөг тооцох аргыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхөд хэрэглэдэг.

Стратегийн үүднээс урьдчилан харах

Хэтийн төлөвийг шинжих арга нь “Өөрчлөлтийн онол”-д суурилсан учраас юу тогтмол үлдэх, юу өөрчлөгдөх, юу тасралтгүй өөрчлөгдсөөр байхыг тодорхойлох боломж олгодог. Болзошгүй өөрчлөлтийг 360 градусын радарт тавьж харснаар боловсролыг төлөвлөж буй мэргэжилтэнд өөрчлөлтийн талаарх төсөөллийг тал бүрээс нь шинжих боломж олгодог аж.¹²⁶ Үүнийг ашиглан шинэ, хүлээж байгаагүй асуудлыг, эсвэл шийдэгдэхгүй үлдээд байгаа асуудлыг, мөн тэдгээрийн ирээдүйн хандлагыг гаргаж ирнэ. Тухайлбал:

- Онлайн сургалт, виртуал сургууль нь өнөөгийн сургалтын орчин, арга, хэрэгслийг хэрхэн өөрчлөх вэ?
- Сүүлийн үеийн шинэ арга хэрэгслийн тусламжтайгаар суралцахуйд ямар ахиц гарч болох вэ? (Жишээ нь тархины биологийг ойлгож, түүний дагуу тусламж үзүүлэх арга)¹²⁷
- Суралцагчийн ялгааг харгалзан үзэж сургалтын хөтөлбөр болон даалгаврыг ялгаатай хийх, хэрэгжүүлэх боломжтой юу?¹²⁸

Хандлагын үр нөлөө

Боловсролын салбар нь мэдээллийн системээр дамжуулан өгөгдлийг нэгжээс шууд цуглуулдаг. Цаг хугацааны өгөгдөлтэй болсон учраас цаашид модель ашиглах, машин сургаж ирээдүйг таамаглах боломж бүрдэж байна. Жишээ нь 2015-2016 оны хичээлийн жилээс хойших хугацааны ерөнхий боловсролын зарим үзүүлэлтийн хамаарлыг харж урьдчилсан таамаглалын загварт ашиглаж болно.

126 Key Success Factor of A Foresight Program eBook


127 Neuro-enhancers

128 Differentiated instruction



Зураг 1.11 Хамаарал харах

2019 оны гүйцэтгэл болон багш-суралцагчийн тооны харьцаа



Эдгээр аргыг бүрэн утгаар нь бид энд хэрэглэж амжихгүй ч боловсролыг төлөвлөх, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах санал боловсруулахдаа харгалзан үзнэ.





1.4 ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ-ШИЙДЭЛ

Сүүлийн жилүүдэд сургуулийн бие даасан байдал, төвлөрлийг сааруулахад ихээхэн анхаарч байна.¹²⁹ Төвлөрлийг сааруулах хөдөлгөөн өрнөж байгаагийн зэрэгцээ, ихэнх улсад гол шийдвэрийг төвлөрсөн байдлаар гаргах нь чухал гэж үзсэн хэвээр байна. Тухайлбал ЭЗХАХБ-ын нэгэн судалгаанд хамрагдсан 18 орны 14 улсад нь төрийн өмчийн суурь боловсролын сургууль нээх, хаах шийдвэрийг дээд түвшинд (Яамны болон бүсийн түвшинд) гаргадаг байв.¹³⁰

Макро түвшинд боловсролын төлөвлөлт хийхдээ дараах бодлогыг зарим улс хэрэгжүүлжээ. Үүнд:

- 1) Тэнцвэрийг хангах,
- 2) Сургуулийн зураглал хийж, дахин зохион байгуулах,
- 3) Ялгаа үүсгэж буй хүчин зүйлс дээр ажиллах,
- 4) Сургуулиудыг сүлжээ үүсгэн хамтран ажиллахыг урамшуулах,
- 5) Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах,
- 6) Хэвтээ, босоо чиглэлийн шилжилтүүд дээр анхаарлаа хандуулах багтана.

1.4.1 Тэнцвэрийг хангах

Нэг хүүхдэд ногдох тогтмол шинжтэй зардал өндөр гарах учраас сургаж буй хүний тоогоор санхүүжүүлэх нь жижиг сургуулиудын оршин тогтнох нөхцөлийг угаасаа хүндрүүлдэг. Нөгөө талаас гэрээсээ хол явж сурах нь хүүхдийн сэтгэл санаанд муугаар нөлөөлдөг гэж судалгаагаар харагдах хандлагатай байна.¹³¹ Иймд энэ хоёрын тэнцлийг олох нь чухал бодлого юм.

Жижиг суурин, тосгонд холимог бүлгээр хичээллэх зөвлөмж өгдөг байсан. Холимог бүлгээр хичээллэхэд сургалтын үр дүн тааруу гарч байгаа, мөн хүүхдийн сурах эрхийг хөндсөн асуудал гэж үздэг тул ийм сургалт зөв шийдэл болж чадахгүй байна.

Тухайн сургууль оршин байх нь маш чухал гэж үзвэл “хамгаалах санхүүжилт” хийх арга ашигладаг. Гэхдээ энэхүү хамгаалалтын санхүүжилт нь санхүүжилтийн үндсэн хэсгээс ялгахуйц ангид, олон нийтэд ил тод байсан үед л ач холбогдлыг нь мэдэрч хариуцлага яригдах хэмжээнд байдаг юм байна.¹³²

129 OECD (2018)

130 OECD (2018)

131 Ares Abalde (2014)

132 <https://assets.publishing.service.gov.uk/government/>



ЖИШЭЭ 1. ОРОН НУТГИЙН, АЛСЛАГДСАН СУРГУУЛЬД ТЕХНИКИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИЛИ УЛСЫН ТУРШЛАГА

Чили улсын санхүүжилтийн системд алслагдсан, орон нутгийн сургуулийн хэрэгцээг хангахад чиглэсэн хэсэг байдаг. Тухайлбал хамран сургалт, элсэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшихэд нь зориулж тэтгэлэг өгдөг. Тэгснээр дотуур байр, тээврийн асуудлаа шийдэж ахлах сургуульд үргэлжлүүлэн сурах боломжтой болно. Мөн алслагдсан сургуулийн багш нарын ажлын нөхцөлийг сайжруулах, хамтдаа суралцах боломж олгох замаар боловсролын чанарыг сайжруулах алхам хийжээ. Алслагдсан нутагт ажиллаж буй багш, удирдлагад “Хүнд нөхцөлд ажилласны нөхөн төлбөр” гэдэг нэртэй мөнгөн урамшуулал өгдөг болсон. Алслагдсан сургуульд ажиллаж буй багш удирдлага болвол тусгай урамшуулал олгодог. “Хөдөөг холбох нь” нэртэй хөтөлбөр 2000 оноос хөдөөгийн сургуулиудад хэрэгжүүлж технологийн дэд бүтэц байгуулж, интернэт болон сургалтын материалаар хангасан байна.

Эх сурвалж: Santaigo et.al (2017) in OECD (2018)

1.4.2 Сургуулийн зураглал хийж дахин зохион байгуулах

Сургууль хэт цөөн хүүхэдтэй байх нь сургуулийн барилга, тоног төхөөрөмжийн илүүдэл үүсгэж төсвийг үр дүн муутай зарцуулж буй хэрэг болно. Иймд “жижиг сургууль” гэж үзэх хязгаар, хамгийн бага бүлэг дүүргэлтийн хэмжээг тогтоох аргыг боловсролын төлөвлөлтөд хэрэглэж байна.

Хүн амын тоо цаашид тогтонги байх хандлагатай үед сургуулиудын байршил, хэрэгцээ, хамран сургалтын ахиц, үйлчилгээний чанарыг судалсны үндсэн дээр сургуулиудыг дахин зохион байгуулах арга хэмжээ зарим улс авчээ. Дахин зохион байгуулалтын бодлого хэрэгжүүлэхдээ зөвхөн урт хугацааны үр ашиг, тогтвортой хөгжлийг онцолно.¹³³ Хамгийн гол зарчим нь суралцагчдын сайн сайхан байдлын төлөө байх, энэ бүхэн эцэстээ суралцагчдад л хамгийн их ашигтай байх ёстой. Багш



нарын хамтын ажиллагаа, мэргэжлийн хөгжил хангагдах нь ч эцсийн дүнд хүүхдийн төлөө байх ёстой.

Сургуулиудыг дахин зохион байгуулснаар 1) төсвийн хөрөнгийн үр ашгийг хангах, 2) нэгэнт тогтсон, үр дүн муутай бүтцийг задлах замаар боловсролын чанарыг сайжруулах боломжтой.

Суралцагчийн тоо буурах, төсвийн хомсдол үүссэнээс шалтгаалан сургуулийг хаах, нэгтгэх

Сургуулийг нэгтгэх гэдэг нь зарим сургуулийг хааж, суралцагчдыг ойролцоо өөр сургуульд шилжүүлэх үйл явц юм. Санхүүгийн хямралын үед энэ аргыг хэрэглэдэг байв. Гэхдээ ийм зохицуулалт хийсэн бусад орны туршлагаас харахад хүн амзүйн хөгжил, өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээнд нийцүүлэхийн тулд дэд бүтцийн зохицуулалт хийх зорилготой байжээ.¹³⁴ Иймд зөвхөн элсэлт буурч буй орон нутагт биш, хоёр ээлж болж тэгш байдал алдагдсан хотын том дүүргүүдэд ч дахин зохион байгуулалт хийх хэрэгцээ үүсдэг.¹³⁵ Сургуулийг нэгтгэх нь эдийн засаг, нийгэм, соёлын, боловсролын чанарын, сэтгэлзүйн, амьдралын хэв маягийн гээд олон асуудлыг хөнддөг. Боловсролын үзүүлэлт тааруу сургуулиас сургалт сайтай, нөөц боломж ихтэй сургууль руу шилжсэнээр хүүхдүүдэд ашигтай гэж гардаг ч шинэ газар дасан зохицоход нь анхаарал халамж тавихгүй бол завсардалт үүсдэг гэжээ.¹³⁶



ЖИШЭЭ 2. СУРГУУЛИУДЫГ ДАХИН ЗОХИОН БАЙГУУЛСАН СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА

Өмнөд Солонгос улс 1982 оноос эхлэн боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах бодлого хэрэгжүүлж, үүний үр дүнд орон нутгийн сургуулиуд нэгдэж нийлэх эсвэл хаагдахад хүрсэн. 180-аас цөөн суралцагчтай бол тухайн сургуулийг хаах зөвлөмж гаргав. Гэвч сургуулиуд кластер үүсгэх хэлбэрийг түлхүү сонгож, 2-4 сургууль нийлж “бүл” (hub) болж ажиллаж эхэлсэн. Бүлд нэг сургууль нь сургалтын үйл ажиллагаа, орчны асуудал дээр чиглүүлэх, манлайлах үүрэгтэй байдаг.

2004 оноос хойш салбарын стратеги өөрчлөгдөж, үр ашгийг хамгийн их байлгах зорилгоосоо орон нутагт боловсролын чанарыг сайжруулах чиглэл рүү шилжив. Орон нутагт сайн ахлах сургууль бий болгох урамшууллын хөтөлбөрийг засгийн газраас хэрэгжүүлж, хөдөөгийн сургуулиудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төрийн өмчийн сургуулиудыг тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авав.

134 European Commission, EACEA & Eurydice (2013)

135 Lee & Lubienski (2016)

136 Brummet (2014)



Мөн сургууль хоорондын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, орон нутагт сургуулийн өмнөх боловсролыг сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх болов. Орон нутгийн сургуулиудын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийв. Гэхдээ гол хөрөнгө оруулалт нь нэгдэж нийлсэн сургууль, тодорхой сонгосон бүс нутагт хийгдэж, бүсээр ялгаатай дэмжлэг үзүүлснээс шалтгаалан орон нутгийн суралцагчид тодорхой сургуулиуд руу шилжих болсон гэдэг шүүмжлэл гарсан байна.

Эх сурвалж: OECD/Korea Development Institute (2017), Improving Regulatory Governance: Trends, Practices and the Way Forward, OECD Publishing, Paris.

Эх сурвалж: Santaigo et.al (2017) in OECD (2018)

Сургалтын үр дүнг сайжруулах зорилгоор сургуулиудыг дахин зохион байгуулах

Сургуулиудыг дахин зохион байгуулах нь дан ганц төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийн төлөө биш юм. Тухайлбал Литва улс сургуулийг дахин зохион байгуулснаар сургууль завсардлыг бууруулж чадсан байна.¹³⁷ Чех улсад бага сургууль, дунд сургуулийг нийлүүлэн “суурь боловсрол” гэж нэрлэж, нэгэн бүхэл, салшгүй систем хэлбэрээр ажилладаг байв. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт нь удааширснаас эрэлт буурах хандлагатай болжээ. Олон улсын шинжээчдийн баг ажиллаж боловсролын түвшнээр салгах санал гаргасан байна. Хэрэв бага сургуулиасаа дунд сургуулиа салгавал бүх жижиг тосгонд нөөц багатай “жижиг сургууль” байх шаардлагагүй болж, нөгөө талаар бага сургуулиа өргөтгөх боломжтой болох юм.¹³⁸ Төстэй асуудал үүсч үүнийгээ хэрхэн шийдсэн тухай Эстони улсын жишээг энд оруулъя.

137 Shewbridge, C. et.al (2016)

138 Shewbridge, C. et.al (2016))



ЖИШЭЭ 3. ЭСТОНИ УЛСАД АХЛАХ СУРГУУЛИУДЫГ ДАХИН ТӨВЛӨРҮҮЛЖ, НЭГТГЭСЭН ТУХАЙ

Хүн амын өсөлт саарч, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнээс сурагчдын тоо буурсан ч ахлах сургуулиуд орон нутагт үйл ажиллагаа явуулсаар байв. Энэ байдал нь Эстони улсын боловсролын систем, ялангуяа хөдөө орон нутагт үр ашиггүй ажиллаж байна гэж дүгнэхэд хүргэжээ. Боловсролын системээ оновчтой болгохын тулд Эстони улсын Засгийн газар дахин төвлөрүүлэх шууд бус стратеги хэрэгжүүлэв.

Арга хэмжээ хоёр хэсэгтэй. Нэгдүгээрт, суурь боловсролыг ахлах сургуулиас салгасан байна. Ингэснээр бусад түвшнийг ахлах сургуультай нэгтгэсэн эсвэл 1-12 дугаар ангитай ерөнхий боловсролын сургууль шинээр нээхийг нь хязгаарлав. Хоёрдугаарт, муж болгонд улсаас шинээр гимнази байгуулах замаар ахлах сургуулиудыг төвлөрүүлэхийг зорьсон байна.

Энэ арга хэмжээний үр дүнд орон нутгийн засаг захиргааны жижиг нэгжүүд энэ түвшний боловсролын үйлчилгээ үзүүлэхээ зогсоож суралцагчдыг шинээр байгуулсан улсын сургууль руу явуулах болно гэж найдаж байжээ. Ахлах сургуулиудыг хаах эрх мэдэл улсад байхгүй. Шинээр байгуулагдах гимназийг улсаас бүрэн санхүүжүүлдэг учраас энэхүү шинэчлэл нь ахлах болон суурь боловсролын сургуулийг оновчтой болгоход санхүүгийн хөшүүрэг болсон юм. Түүнээс гадна суурь боловсролыг сайжруулахын тулд ахлах сургуулиудаа хаах эсвэл нэгтгэх арга хэмжээ авсан нөхцөлд орон нутгийн захиргаа нь улсаас хөрөнгө оруулалт авах хүсэлт гаргаж болно.

Энд хэд хэдэн анхаарах зүйл байгааг ЭЗХАХБ-ын 2016 оны тойм тайланд дурдсан байна. Ахлах сургуулийн үйл ажиллагааг үр ашигтай үргэлжлүүлж чадаж байгаа орон нутаг шинээр байгуулагдсан гимназид суралцагчдаа алдах эрсдэл тулгарч болно. Энэ нь сургуулиудын хуваагдал, ялгааг улам нэмэгдүүлэхэд хүргэх магадлалтай. Хоёрдох асуудал нь ахлах сургуулиудыг төвлөрүүлж нэгтгэснээр ахлах сургуулиар эзэмших боловсролыг тухайн бүс нутгийн хөгжлийн стратегитай уялдуулахад хүндрэлтэй болж магадгүй.

Эх сурвалж: Santaigo et.al (2016) & OECD (2018)



1.4.3 Ялгаа үүсгэх хүчин зүйл дээр ажиллах

Нийгэмд боловсролын ялгаа үүсгэдэг хүчин зүйлийн жагсаалтад 1) оршин суух хэв маяг¹³⁹, 2) эцэг эхийн сонголт, 3) сургуулиудын элсэлтийн бодлого дээгүүр эрэмбэлэгддэг. Суурьшлын болон эцэг эхийн сонголтын үр дүнд бий болдог боловсролын ялгааг багасгахын тулд 1) “суралцагчдыг байрлуулах” шууд арга хэмжээ авах, 2) сонголтыг хянах, 3) сургуулийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлдэг.

140

Суралцагчдыг “байрлуулах” шууд арга хэмжээ авах

Суралцагчдыг хаана элсэхийг нь албадах боломжгүй. Харин хаана элсэхийг санал болгох эсвэл хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх бодлого хэрэгжүүлэх боломжтой. Хамран сургах тойргийг тогтоохдоо нэг тойрогт аль болох амьжиргааны түвшнээр нь холих арга хэрэглэх, шинээр барих сургуулийн байршлыг шийдэхдээ үүнийг харгалзах, мөн төрөлжсөн (magnet) сургууль байгуулж элсэлтийг нь чөлөөтэй байхаар зохион байгуулах арга хэрэглэж байна.¹⁴¹ Дани улсын нийслэл Копенхаген хот суурьшлаас үүссэн боловсролын ялгааг багасгах хөтөлбөр хэрэгжүүлжээ. Үүнийг “Интеграци хийх Копенхаген загвар” гэж нэрлэдэг. Энэ үйл ажиллагааны хүрээнд үндэсний цөөнх болон цагаач гэр бүлийн хүүхдүүдийн унаа тээвэр, шилжилт хөдөлгөөнийг нь зохицуулах замаар амьдардаг дүүргээс нь өөр дүүргийн сайн сургуулиудад сургасан байна.¹⁴²

Магнет буюу математик, шинжлэх ухаан, урлагийн төрөлжсөн, гүнзгийрсэн сургалттай сургуулийг нийгэм-эдийн засгийн байдал, сонголтоос үүсэх тэгш бус байдал, ялгаатай тэмцэх хэрэгсэл болгон 1970-аад оноос АНУ өргөн хэрэглэх болов. Ингэхдээ төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургуулийг амьжиргааны түвшин доогуур дүүрэгт байгуулж элсэлтийг нь чөлөөтэй байлгадаг. Хамран сургах тойргийн гаднаас ирж буй хүүхдүүдэд үнэгүй тээврээр үйлчилдэг.¹⁴³ Магнет сургуульд элсэх хүсэлт хэт олон бол сугалаагаар шийддэг байна.

Сонголтыг хянах, зохицуулах

Сургууль сонгох бодлогыг ойр ойрхон хянаж, хуулийн зохицуулалт хийдэг. Ингэхдээ нэгэнт үүссэн боловсролын тогтолцоо нь зарим хэсэгт системтэйгээр давуу тал үүсгэж, харин зарим хэсэгт сул байдал бий болгож байгаа эсэхийг үнэлнэ. Тухайлбал унаа, хоол зэрэг өрхийн зардлыг зохицуулна. Мөн сонголт хийх эрх нээлттэй байх үед эцэг эх, асран хамгаалагчид ямар хүчин зүйлийг харгалзаж, ямар үйлдэл хийж байгааг нь тогтоож, үүнд үндэслэн тэгш боломжийг ашиглахад саад болж байгаа хүчин зүйлс дээр ажилладаг.

139 Residential patterns

140 Gong, Y & Leng, C (2020). When education policy and housing policy interact: Can they correct for the externalities?, Journal of Housing economics.

141 Karsten (2010)

142 Nusche (2009)

143 <https://educationpost.org/are-magnet-schools>.



Судлаачид суурьшлын бодлого бол боловсролын бодлого байх ёстой гэж үзэж байна.¹⁴⁴ Ричард Ротштэйн¹⁴⁵ 2017 онд “Хуулийн өнгө” номдоо өнөөгийн суурьшлын ялгаа нь хувь хүмүүсийн сонголт, үйлдлийн үр дүн¹⁴⁶ гэж тайлбарладаг байсан. Үнэн хэрэгтээ энэ нь төрийн тодорхой бодлогогүй байсан алдаанаас үүссэн¹⁴⁷ ялгаа юм. Гэхдээ бас тоолгүй орхисон асуудал ч биш юм байна. Бараг л ийм үйл явцыг бид хөхүүлэн дэмжсэн, “зарим хэсгийнхээ хүссэн газраа амьдрах, өсөх, суралцах эрхийг нь үгүйсгэсэн” хэмээн олон жилийн судалгаанд үндэслэн дүгнэжээ.¹⁴⁸

Суурьшил, орон сууцны i) тэгш хамруулах бүсчлэл байгуулах, ii) орлогоос хамаарах орон сууцны хөнгөлөлт олгох, iii) төрийн түрээсийн сууц хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн 3 төрлийн бодлого түгээмэл байна.



ЖИШЭЭ 4. МЭРИЛАНДЫН МОНТГЛОМЕР МУЖИЙН ТЭГШ ХАМРУУЛАХ БҮСЧЛЭЛ ХӨТӨЛБӨР

Тэгш хамруулах бүсчлэл (Inclusionary zoning) гэдэг нь орлого багатай гэр бүлийг амьжиргааны түвшин сайтай гэр бүлтэй нэг хороололд амьдруулах зорилготой газрын хэрэглээний бодлого юм. Монтгломер муж 1974 оноос хойш тэгш хамруулах бүсчлэлийн хөтөлбөр хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн байна. Тус мужийн нэг гэр бүлийн дундаж орлого 93,373 ам.доллар байдаг нь АНУ-ын дундаж орлого 51,914 ам.доллараас бараг л 2 дахин их юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд 1970 оноос хойш 13,000 боломжийн (хямд) үнэтэй орон сууц баригдаж, шинээр барилга баригдах бүрд хөтөлбөрийн сууц нэмэгддэг. Мөн тус мужийн төрийн орон сууцны агентлаг нь баригдсан тэгш хамруулах бүсчлэлийн орон сууцны тодорхой хувийг (гуравны нэг хүртэл) худалдан авах эрхтэй байдгаараа онцгой юм.

Эх сурвалж: Heather Schwartz (2013) Can housing policy be good education policy?

Тэгш хамруулах бүсчлэлийн бодлого нь зөвхөн өндөр үнэтэй суурьшлын бүсэд хамааралтай бөгөөд сууцыг зах зээлийн үнээс доогуур үнээр өгснөөс үүсэх зөрүүг улсаас зохицуулдаг. Үүнийг үл хөдлөх хөрөнгийн компанид дараагийн суурьшилд нэмэлт газар өгөх эсвэл нөхөн төлөх замаар шийддэг. Эрэлт ихтэй сайн сургуульд

144 Heather Schwartz (2013) Can housing policy be good education policy?

145 A former columnist for the *New York Times* and a research associate at the Economic Policy Institute, as well as a Fellow at the Thurgood Marshall Institute of the NAACP Legal Defense Fund

146 *de facto* segregation

147 *de jure* segregation

148 Richard Rothstein (published by Liveright in May 2017). *The Color of Law*



нийгэм-эдийн засгийн хувьд сул байгаа гэр бүлийн хүүхдүүдийг хамруулах олон аргын нэг нь энэ байж болно.¹⁴⁹

Сургуулийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх

Сургуулийг сайжруулах эсвэл сургууль хөгжүүлэх¹⁵⁰ төлөвлөгөө гэдэг нь сургуулийн үйл ажиллагаа, практик, сургалтын үр дүнг сайжруулахын төлөө удирдлага, багш зэрэг сургуулийн үйл ажиллагааны оролцогчид хамтдаа өөрчлөлт хийх тухай юм. Сургуулийг сайжруулах арга хэмжээний эцсийн зорилго нь суралцахуйг сайжруулах бөгөөд үүнд суралцагчийн сайн сайхан байдал¹⁵¹ болон сурлагын амжилт багтана.



ЖИШЭЭ 5. ЛОНДОНГИЙН СОРИЛТ

Их Британи улсын Боловсрол болон ур чадварын яам нь нийслэлд боловсролын үр дүнг сайжруулах Лондонгийн Сорилт (London Challenge) хэмээх хөтөлбөр зарлаж, 2003-2008 онуудад хэрэгжиж эхэндээ дунд сургуулийг дэмжих зорилготой байсан бол 2008-2011 онд Манчестер, Блакт орших бага сургуулиудыг хамруулан “Хотуудын сорилт” болгон өргөжүүлэв.

Өмнөх туршлагадаа үндэслэн хэрэгжүүлсэн “Хотуудын туршилт” хөтөлбөр нь амжилт муутай байгаа сургуулийн тоог бууруулах, шилдэг сургуулийн тоог нэмэгдүүлэх, нөхцөл боломж тааруу байгаа гэр бүлийн хүүхдүүдийн боловсролын үр дүнг сайжруулах гэсэн гурван зорилготой.

Хөтөлбөрт i) амжилт муутай, дэмжлэг хэрэгтэй байгаа сургуулийг олж тогтоох; ii) зорилтот арга хэмжээ авах замаар дунд зэрэг гэж үнэлэгдэхээр байгаа сургуулиудыг сайн сургууль болгох; iii) сургууль дундын ялгааг арилгахад дэмжлэг үзүүлэх, iv) “сургуулийн бүл” хэмээн нэрлэдэг холбоонд сургуулиудыг элсүүлэх, v) орон нутгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, vi) удирдлага- манлайллын сургалтад хамруулах арга хэмжээ багтана. Сургуулийг сайжруулахад юу хэрэгтэй вэ гэдэг дээр олон талын оролцоог (сургуулийн удирдлага, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд) хангасан шийдвэр гаргах арга хэрэглэв.

149 Heather Schwartz (2013) Can housing policy be good education policy?

150 School improvement plan (SIP)-Боловсрол судлалын сургуулиуд тусдаа судлагдахуун болгон гүнзгий судалдаг.

151 Well-being



Сургуулийн амжилт, бас нөхцөл байдлаас шалтгаалж олон төрлийн дэмжлэг авах боломж санал болгож буй энэ стратеги нь сургууль бүрд ялгаатай тусламж үзүүлэх арга хэмжээ болж чадсан юм. Амжилт муутай байгаа сургуулиуд экспертийн тусламж авч, дунд зэрэг байгаа сургуулиуд бусад ижил төрлийн сургуулиудтай хамтран ажиллах болов. Мөн сургуулийн удирдлага цаашид өөрөө сургуулиа сайжруулаад явах боломжтой болжээ. Сайн сургуулиуд ч бусадтай туршлагаа хуваалцах, бусад амжилттай сургуулиасаа суралцах, амжилт муутай сургуульд тусламж дэмжлэг үзүүлж байна.

Эх сурвалж: Baars et.al (2014) Lessons from London schools:
Investigating the success

1.4.4 Сургуулиудын дунд хамтын ажиллагаа, сүлжээ үүсгэх

Сургуулиудын дундах албан болон албан бус харилцааг “сургуулийн сүлжээ” (school network), хамтын ажиллагаа гэж ойлгоно. Жижиг сургуулиудыг олон хүүхэдтэй том сургуультай эсвэл ойр хавийн сургуультай удирдлага нэгтэй болгож, цахимаар хичээллэх, бие биедээ тусламж үзүүлэх зэргээр хамтран ажиллах кластер үүсгэвэл үйл ажиллагааны зардал хэмнэхийн зэрэгцээ, хамтын ажиллагааны үр дүнд сургалт сайжирна гэж үздэг. Үүнийг хэвтээ чиглэлийн хамтын ажиллагаа (horizontal co-operation) гэж нэрлэнэ. Гэхдээ гол санхүүжилтийн хэсгээс хамтын ажиллагааг өдөөж буй санхүүгийн урамшуулал мэдрэгдэхүйц тусдаа байх хэрэгтэй.¹⁵² Тухайлбал Эстони улсын санхүүжилтийн томьёо нь дунд сургуулийг аль болох томруулах (7-9-р анги), нэгтгэх хандлагатай хэсгийг агуулсан байдаг. Мөн гэрээсээ хол амьдрахтай холбоотой бүх зардлыг төрөөс хариуцдаг байна. Жишээ нь бүлэг дүүргэлтийн хамгийн бага хэмжээнээс илүү байх тохиолдолд орон нутгийн сургуулийн багшид нэмэлт хөлс төлдөг байна.¹⁵³

Албан ёсны эсвэл сайн дурын эсэх, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ, бодлогын ялгаанаас хамааран хамтын ажиллагааны олон төрөл байна. Тухайлбал:

- Нөөцөө хувааж ашиглах, хамтран сургалт явуулах, худалдан авах зүйлсийн үнийг хувааж төлөх,
- Албан болон албан бус хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл байгуулах,
- Тусгай үйлчилгээ үзүүлэх дундын төв байгуулах,
- Нэгдсэн удирдлагын дор кластер хэлбэрээр ажиллах.

152 Nusche et.al (2015)

153 Santiago, P. et.al (2016)



Нөөцийг хувааж ашиглах

Мэргэшсэн багш, өндөр үнэтэй тоног төхөөрөмж эсвэл суралцагчид дундаа ашиглах боломжтой тоног төхөөрөмж зэрэг нөөцийг хувааж ашиглах боломж жижиг сургуулийн хувьд их чухал. Франц улс энэ аргыг 1970-аад оноос хэрэглэж, элсэлтээс шалтгаалан үйл ажиллагаа нь хүндрэлтэй байх магадлалтай байсан сургуулиудын нөхцөл байдал сайжирсан байна. 1998 оноос хойш эдгээр сургуулийн хооронд зорчих тээвэр болон интернэтийг нь шийдсэнээр хичээлийн дараах үйл ажиллагааг хүртэл хамтдаа хийдэг болжээ.¹⁵⁴

Испани улсад 1980-аад оноос хойш орон нутгийн сургуулиуд нэгдэн “Хөдөөгийн сургуулиудын бүлэг”¹⁵⁵ нэртэй нөхөрлөл байгуулж ажилласан байна. Сургуулиуд өөр өөр мужаас хамтарч, мэргэжлийн багш, сургалтын материалаа хуваалцаж, сургалтын хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагааг хамтран явуулж, багш нарын мэргэжлийн ганцаардлыг шийдэх боломжтой болжээ. Ийм туршлага түгээмэл байв.

Хамтын худалдан авалт хийх нь нөөцөө хувааж ашиглах өөр нэг арга юм. Маш сайн ярилцаж шийдсэний үндсэн дээр хөрөнгө оруулалтын санал илгээх, авсан хөрөнгийг хэрхэн хувааж хэрэглэх талаар урьдчилж тохирох, эсвэл авсны дараа жижиг сургуульд тоног төхөөрөмжөө ашиглуулах хэлбэр байж болно. Тухайлбал жижиг сургуульд усан бассейн байхгүй бол том сургуулийн усан бассейн дээр хичээллэх арга байж болдог.

Албан болон албан бус хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл байгуулах

Багш нар өөр сургуулийн суралцагчдад ангид болон онлайнаар сургалт явуулах, нэг сургуульд байгаа байгалийн ухааны лабораторид өөр сургуулиуд ирж хичээллэх, нийт 9-р ангийн физикийн хичээлийг хамтарч буй сургуулийн суралцагчдад нэг дор заах зэргээр сургуулиуд хамтран ажиллахад хамгийн түрүүнд эрхзүйн асуудал тулгардаг юм байна.

154 OECD (2018)

155 “Grouped Rural Schools”



ЖИШЭЭ 6. БЕЛЬГИ УЛСАД ХЭРЭГЖСЭН СУРГУУЛИУДЫН ХООРОНДОХ САЙН ДУРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бельги улсын Флэмиш муж нь 1999 оноос сургуулиудын дунд “сургуулийн холбоо” байгуулж хамтын ажиллагааны эхлэлийг тавьжээ. 2003 оноос ийм холбоонд бага сургуулиудыг хамруулсан байна. Нэг холбоонд газар нутгийн хувьд ойролцоо орших 6-12 сургууль багтаж байв. 2010 гэхэд ихэнх сургууль (96.7%) холбоонд элсэж, үлдсэн цөөн хэд нь тусгай хэрэгцээт сургуулиуд байжээ. Ялангуяа дунд сургуулийн хувьд хамтын ажиллагааны гол зорилго нь үр ашгаа дээшлүүлэх, хамтын ажиллагаагаар дамжуулан сургалтын хөтөлбөрийн үр дүнг сайжруулах явдал байв. 2010 онд хийсэн Аудитын Шүүхийн Үнэлгээний дүгнэлтэд “нэг 155 OECD (2018) 156 “Grouped Rural Schools” 35 холбоонд хамрагдаж буй сургуулиудын хөтөлбөр давтагдахааргүй, сургууль бүр нэг төрлийн хичээл санал болгох нь эрс цөөрсөн байна” гэжээ. Холбооны гишүүнчлэл сайн дурын хэлбэртэй. Бодит байдал дээр өрсөлдөж байх ёстой сургуулиуд холбоонд элсэж байгаа нь санхүүгийн урамшуулалтай холбоотой.

Холбоонд байгаа сургуулиуд хамтаараа шийдвэр гаргасан тохиолдолд Боловсрол, Сургалт хариуцсан яамнаас нэмэлт орон тоо болон шаардлагатай нэмэлт зардлыг санхүүжүүлдэг. Сургуулийн холбоод захиргааны болон туслах ажилтны орон тоо нэмэх боломжтой. Дунд сургуулийн хувьд холбоо дотроо тохиролцож багшийн цагийг дахин хуваарилж болно.¹⁵⁷ Бага сургуулиуд дундын захирал томилох, мөн нийт төсвийн 10 орчим хувийг авч үлдэж өөрийн үйл ажиллагаанд зарцуулах эрхтэй. Хамгийн амжилттай холбоод нь хүн ажилд авах, үнэлэх, захирлын ажлыг хөнгөвчлөх, захиргааны ачааллыг бууруулахуйц менежментийн цогц систем хөгжүүлж, педагогийн манлайллыг хэрэгжүүлсэн гэж үзэж болохоор байдаг. Дунд сургуулийн холбоодын ажлыг үнэлэхэд ихэнх нь хүний нөөцөө хувааж ашиглах, сургалтын хөтөлбөрийн зарим хэсгийг хамтдаа хэрэгжүүлэх боловсон хүчний нэгдмэл бодлоготой болсон байжээ.

Эх сурвалж: Nusche, et.al (2015) OECD Reviews of School Resources.



ЖИШЭЭ 7. ЭСТОНИ УЛСЫН БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВ

Эстони улсад 26 наснаас доош насны залуучууд, хүүхдүүдэд үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх “Бүсийн зөвлөгөө өгөх төв” 2014 оны 9 сарын 1-нээс орон нутагт ажиллаж эхэлжээ. Эдгээр төвд ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх, тусгай хэрэгцээт сургалт явуулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хэл ярианы асуудлыг эмчлэх, нийгмийн сурган хүмүүжүүлэх зүйн үйл ажиллагаа явуулдаг. Орон нутгийн засаг захиргаа (ялангуяа жижиг газрууд) болон сургуулиуд энэ төвөөр дамжуулан тусгай дэмжлэг, үйлчилгээ (ялгаатай хөгжилтэй суралцагчтай ажиллах боловсролын мэргэжилтэн эсвэл боловсролын сэтгэл судлаач гэх мэт) хүсэх эрхтэй. Эдгээр төвүүд нь “Насан туршийн зөвлөгөө өгөх агентлаг”-ын удирдлагад ажилладаг бөгөөд энэ агентлаг нь ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, мэргэжилтнүүдийг бэлтгэх, мөн насан туршийн боловсролын сургалт, зөвлөмжид чанарын баталгаажуулалт хийх үүрэгтэй.

Төв бүр ялгаатай хөгжилтэй, суралцах бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах “Мэргэжлийн зөвлөл”-ийн үүрэг хүлээдэг. Тэд сургуулиудад ялгаатай хөгжилтэй суралцагчдыг хэрхэн элсүүлэх, сургалтыг нь хойшлуулах асуудал гарвал хэрхэн шийдвэрлэх, ялгаатай хөгжилтэй суралцагчдад сургалт хэрхэн үр дүнтэй явуулах талаар зөвлөмж өгдөг. Ялгаатай хөгжилтэй суралцагчдад үзүүлэх үйлчилгээнд хэл ярианы согог эмчлэх, тусгай сургалтын багш, сурганы мэргэжилтэн, сэтгэл судлалын мэргэжилтний үйлчилгээ багтана. Ирээдүйд энэ төв оношлох үүрэг хүлээж магадгүй байна.

Бүсийн зөвлөгөө өгөх төвүүд сургуулиудын өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулахад ихээхэн тус хүргэхээр юм. Орон нутгийн засаг захиргаа болон сургуулиудад хэрэгтэй үйлчилгээг нь үзүүлдэг төв байхын төлөө мэргэжилтнүүдээ сайтар сургах, дүрэм, журам, практикаа хөгжүүлэх хэрэгтэй. Бодлого боловсруулагчдын хувьд эдгээр төвүүд боловсролын үр дүнг сайжруулах, тэгш боломжийг бүрдүүлэхийн тулд зохицуулалт хаана хийх хэрэгтэй байгааг мэдэх чухал мэдээллийн эх сурвалж болж байна. Эдгээр төвийг Европын Нийгмийн Сангаас санхүүжүүлж байгаа хэдий ч, алсдаа сургуулиуд, эцэг эхчүүд, багш нар тэдний үйлчилгээнд мөнгө төлдөг болж магадгүй.

Эх сурвалж: Santaigo et.al (2016) & OECD (2018)



Нэгдсэн удирдлагын дор кластер хэлбэрээр ажиллах

Англи улсын Вилтшэйр мужид хоёр бага сургууль нийлээд 64 суралцагчтай байжээ. Тэд нэгдэж хоёр байртай нэг сургууль болсон байна. Гэтэл элсэлт 99 болж нэмэгдэн мэргэжлийн багш ажиллуулах боломжтой болов.¹⁵⁶

Кластер хэлбэрээр ажиллахад хэд хэдэн анхаарах асуудал гардаг. Нэг кластерт байгаа сургуулиуд ойрхон оршдог байх хэрэгтэй. Ингэснээр багш нар сургуулиудын хооронд явахаас бэрхшээхгүй болно. Тэдэнд унааны хөнгөлөлт олгодог байх хэрэгтэй. Мөн хэн шийдвэр гаргах вэ гэдэг асуудал гардаг. Кластерт байгаа нөөц ихтэй том сургууль нь илүү дуу хоолойтой оролцдог ч, нэгдсэн ойлголтод хүрэх амаргүй. Иймд Дани улсад кластерт байгаа сургуулийн захирлууд кластерийг ээлжлэн удирдахаар зохион байгуулсан нь оновчтой зохицуулалт болсон байна.¹⁵⁷ Дараагийн асуудал нь компьютерын лаб, номын сан зэргийг бүх сургуулийн багш, суралцагчид хэрэглэнэ гэдгийг сайтар зохицуулсан дүрэм журам хэрэгтэй байдаг. Сургуулийн автобус, багш нарын ажлын хуваарь, суралцагчид сургууль хооронд зорчиж хичээлдээ оролцохыг зохицуулах нь нарийн ажил бөгөөд үүнийг гол төлөв нэгдсэн баг хийдэг.



ЖИШЭЭ 8. ПОРТУГАЛ УЛСАД ХЭРЭГЖСЭН КЛАСТЕРИЙН ТӨСӨЛ

Португал улс нь 2005 онд сургуулийн тэгш бус байдлыг эрс бууруулах, үр ашгийг сайжруулах шинэчлэл эхлүүлжээ. 10 жилийн дотор төрийн өмчийн сургуулийн 47%-ийг хаасан бөгөөд ихэнх нь орон нутгийн жижиг бага сургууль байв. Шинэчлэл хийхээс өмнө хөдөөгийн сургуулийн ихэнх нь тохижилт муутай, боловсролын үр дүнгийн үзүүлэлт нь доогуур байсан бол төвлөрсөн суурингийн сургуулиуд хоёр ээлжээр хичээллэдэг, хэт дүүрсэн байв. Энэ асуудлыг шийдэхийн тулд Боловсролын яам орон нутгийн засаг захиргаатай хамтран, 20-оос цөөн суралцагчтай, 2005-2006 оны хичээлийн жилд анги улиралт нь улсын дунджаас өндөр байгаа сургуулиудыг хааж эхэлсэн. Хэдийгээр сургуулийг нэгтгэх, хаах асуудал нь хуулийн дагуу байсан боловч, эцэг эх, орон нутаг, иргэдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч, ийм өөрчлөлт хийснээр суралцагчдад хэрэгтэй гэдгийг ойлгуулах шаардлагатай болов. Үүний зэрэгцээ яамны зүгээс орон нутагт төсвийн дэмжлэг үзүүлж, гэрээсээ хол явах болсон хүүхдүүдийн тээврийн зардал, амьдрах зардал, кластер сургуулийн тохижилтод хөрөнгө оруулалт хийв.¹ Олон жижиг сургуулийг дахин тоноглож, хамгийн багадаа 150 суралцагч хүлээн авах хүчин чадалтай болгож, өдөржин сургууль дээр хичээллэх, нэмэлт давтлага авах, сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх арга хэмжээ авчээ алслагдсан сургуулийн багш нарт хөгжих боломж, нэмэлт хэрэгцээтэй суралцагчдад тусламж авах боломж нэмэгдэж, Боловсролын яам болон сургууль, орон нутгийн хамтын ажиллагаа сайжирсан байна.

156 Rule (2005)

157 Rule (2005)



Энэ төсөл амжилттай болоход хэд хэдэн хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд i) хэтийн зорилго тодорхой байх, ямар тохиолдолд сургууль хаагдах, түүнийг юугаар солих нь тодорхой байх ёстой, ii) энэ арга хэмжээг авснаар эцсийн дүнд суралцагчдад ямар ашигтай байхыг эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарлах, улмаар өрхөд санхүүгийн нэмэлт дарамт уяруулахааргүй буюу сургууль-гэрийн хооронд үнэ төлбөргүй зорчих зэрэг асуудлыг шийдсэн байх ёстой, iii) орон нутаг нь кластерийн удирдлагыг өөрсдийнхөө үүрэг хариуцлага гэж хүлээн авч дэмжих хэрэгтэй.

Эх сурвалж: Liebowitz, D et al. (2018), OECD Reviews of School Resources: Portugal 2018, OECD Publishing, Paris in OECD (2018).

1.4.5 Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах

Орчин үеийн нэгэн чухал үйлчилгээ нь виртуал сургалт юм. Суралцагчид илүү уян хатан байдлаар, гэртээ эсвэл ангидаа ТВ-ээр эсвэл интернэтээр мэргэшсэн багшийн чанартай хичээл үзэх боломжтой. Тухайлбал Ричард Робинсон “4 багш тус тусдаа 4-р ангид хичээл заадаг бөгөөд нийт 100 суралцагчтай. Гэтэл дундаа нэг мастер багштай, 3 туслах багштай бол цалин өндөр байдаг улсад хүний нөөцийн зардал хэмнэх боломжтой талаар 20 жил ярьж байна” гэжээ.¹



ЖИШЭЭ 9. КАНАД УЛСЫН ОНТАРИО: ХОЛИМОГ СУРГАЛТ, МХХТ АШИГЛАХ СТРАТЕГИ

Цахим сургалтын нөөцөд Онтариогийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой виртуал сургалтын орчин, сургалтын материалын дижитал номын сан багтана. Үүнийг суралцагчид бие даасан онлайн хичээл болгон судлах, эсвэл ангидаа болон хичээлээс бусад цагаар нэмэлт болгон судлах боломжтой. Нэвтрэх эрхийн хамгаалалт бүхий сургалтын виртуал орчин нь суралцагчдыг багш нар болон ангийнхантай нь холбох хэрэгсэл болж чаддаг. Хөдөөгийн, алслагдсан нутагт цахим сургалтыг бодитой болгоход өндөр хурдны Интернэт (бродбанд) гол хүчин зүйл нь юм. Онтариогийн 2016 оны төсөвт цахим сургалтыг дэмжихийн тулд боломжийн үнэ өртөгтэй, бүгдэд хүртээмжтэй өндөр хурдны интернэтийн үйлчилгээг санхүүжүүлэх хэсэг багтсан. Мөн энэ төсөвт суралцагчдын сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд анхаарал тавих санхүүжилт багтаажээ. Тухайлбал Онтариогийн теле-эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төв хөдөөгийн, алслагдсан нутгийн хүүхэд, залуучуудад видео хэлэлцүүлгээр эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг болов.

Эх сурвалж: Ontario Ministry of Education (2017)



1.4.6 Хэвтээ, босоо чиглэлийн шилжилтүүд дээр анхаарлаа хандуулах

Боловсрол эзэмших нь олон жил шаарддаг нөр их хөдөлмөр тул замд нь олон саад бэрхшээл тохиолддог. Иймд он жилүүдийн турш буюу боловсролын нэг шатаас нөгөө рүү шилжин ороход тусламж, дэмжлэг үзүүлэхийг босоо чиглэлийн зохицуулалт, харин сонголт, программ, хөтөлбөрийн хооронд шилжихэд тусламж, дэмжлэг үзүүлэхийг хэвтээ зохицуулалт гэж нэрлэнэ.

Босоо чиглэлийн зохицуулалт хийснээр суралцах явцад тохиолдох төрөл бүрийн эрсдэлийг суралцагчид ганцаараа үүрэхгүй байх, улмаар эрт сургуулиас гарах, сургууль дээрээ тулгарч буй бэрхшээлийг хамтдаа даван туулах, өнөөгийн боловсролын хамгийн гол үр дүн болох тууштай, даван туулах чадвартай (resilient) хүн болоход нь тусалдаг. Ийм зохицуулалтыг хангалтгүй хийвэл үр дагавар нь хувь хүнд ч төдийгүй, нийгэмд ч өндөр өртөгтэй тусдаг.¹⁵⁸

Боловсролын өөр өөр замууд санал болгосноор хүсэл сонирхлоо дагах, өнөөгийн нөхцөл байдалдаа тохируулах, ямар нэг завсардалт үүсгэхгүй ('seamless pathways') зохицуулах боломж суралцагчдад олгодог. Хүн хүсэл сонирхлоо дагах аас бус, тухайн үеийн амьдралын нөхцөл байдлаас болж сонголт хийхэд хүргэхгүй байх нь төрийн үүрэг юм. Нийгэмд тэрхүү сонголтоос шалтгаалж ялгаа үүсдэггүй байхыг төр баталгаажуулах ёстой. Жишээ нь Австрали улсын Боловсрол, хөдөлмөрийн яам дараах арга хэмжээнд анхаарлаа хандуулдаг байна.¹⁵⁹ Үүнд:

- Сургуульд сурах нь дараагийн боловсрол хийгээд амьдралын турш амжилттай байх бэлтгэл болох,
- Сургуулиар дамжуулан мэргэжлийн боловсрол олгох,
- Суралцагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх,
- Сургуулиас ажил амьдралд шилжихэд нь туслах,
- Ажлын байранд мэргэжил эзэмших хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Мэргэжлийн боловсролоос дээд боловсрол руу шилжихэд туслах,
- Ажиллаж буй хүмүүсийг дахин сургах, дахин мэргэшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

158 OECD (2018)

159 Parliament of Australia. Chapter 5 - Education and training pathways



2. Хөрөнгийн санхүүжилт

Капиталын буюу хөрөнгийн зарлага гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд хэрэглэх, хөрөнгө болж үлдэх зүйл худалдан авах гэсэн утгатай. Үүнд зураг төсөл гаргахаас эхлэн барилга барих хүртэлх өргөн хүрээний хөрөнгийн гүйлгээ багтана.

ЭЗХАХБ-ын орнуудын цалин хөлснөөс бусад урсгал болон хөрөнгийн зардлын дундаж нь 2011-2014 онд 28% байжээ.

Хүснэгт 2.1 Цалин хөлснөөс бусад урсгал болон хөрөнгийн зардал

Жишээ	Дундаж хэмжээ /2011-2014/
Бельги, Литва, Ирланд, Португал, Мексик	20%-иас бага
Чех, Эстони, Финлянд, Өмнөд Солонгос	35%-иас их
ЭЗХАХБ-ын орнуудын дундаж	27%

Эх сурвалж: OECD (2017)

Харин манай улсад нийт зарлагад эзлэх цалин хөлс, урамшууллаас бусад зарлага нь 2019 оны гүйцэтгэлээр 48.6% байна.

Хүснэгт 2.2 Монгол улсын ерөнхий боловсролын зардал

Төрөл	2019 оны гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/ ¹⁶⁰	Хувь
Цалин хөлс, урамшуулал	506.6	51.4%
Бусад урсгал зардал	231.3	23.5%
Капиталын зардал	247.5	25.1%
Нийт зарцуулалт	985.5	100%

Эх сурвалж: СЯ

Сургалтын биет орчин бүрдүүлэх, хөгжүүлэхэд зориулж буй хөрөнгө, нөөцийг хуваарилах ялгаатай механизм байдаг. Хуваарилалтын механизм гэдэг нь санхүүжилтийг орон нутаг руу, хүлээн авагч сургууль, цэцэрлэг рүү шилжүүлэх ялгаатай арга зам юм.



Хүснэгт 2.3 Хуваарилалтын механизм

Хуваарилалтын арга	Тодорхойлолт
Тухайн цаг үед нь шийдвэрлэх (Ad hoc grant)	Санхүүжүүлэгч болон хүлээн авагч байгууллага тухайн цаг үед нь шийддэг хэлцэл.
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (Infrastructure investment programme)	Дунд хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн салбарын хэмжээнд хийхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын зорилтот хөтөлбөр.
Өрсөлдөөнт санхүүжилт (Competition grant)	Хөрөнгө оруулалтын өргөдөл хүлээн авах үйл явц. Хүсэлтийг холбогдох шалгуурын дагуу үнэлж, хийх зүйлийг ач холбогдлоор нь эрэмбэлж шийдвэр гаргана.

Эх сурвалж: OECD (2018)

Орон нутаг эсвэл боловсролын байгууллагын хүлээн авах дүнг тооцох аргыг санхүүжилтийг хуваарилах суурь гэнэ. Хөрөнгийн санхүүжилтийг тооцдог түгээмэл аргыг дараах хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 2.4 Хэмжээг тооцох арга

Хуваарилалтын суурь	Тодорхойлолт
Захиргааны үнэлэмж, шийдвэрээр (Administrative Discretion)	Төсвийн хуваарилалтыг мэргэжлийн үнэлэмжээр шийдэх арга. Сургууль бүрд хэрэгтэй төсвийг орон нутаг эсвэл яамны түвшинд тооцохдоо магадгүй зарим нэг шалгуур үзүүлэлт ашиглаж болно.
Хэлэлцээр хийх замаар (Negotiated Process)	Санхүүжилтийн хэмжээн дээр шийдвэр гаргагчид болон санхүүжилт хүсч буй байгууллага хоёрын дунд хэлэлцээр явагдах арга. Тухайлбал богино хугацааны хэрэгцээнээс үүссэн асуудлыг шийдэх хүсэлтийг орон нутгийн засаг захиргаа гаргах, тогтмол авдаг санхүүжилт дээр хэлэлцээр хийх гэх мэт.
Хэрэгцээг үнэлэх (Assessment of needs)	Доор тайлбарлав.
Өрсөлдөөнт зарчмаар (Competitive basis)	Сургууль эсвэл орон нутгийн засаг захиргаа хөрөнгө оруулалтын санхүүжилт авахаар өргөдөл илгээх үйл явц.

Эх сурвалж: OECD (2018)

“Хөрөнгө оруулалтын хөтөлбөр” хэрэгжүүлж, “хэрэгцээг үнэлэх” аргаар хөрөнгө оруулалтын хэмжээг тооцох нь олон улсын сайн туршлага байх хандлагатай юм байна. Судалгаанууд Австри, Эстони улсын практикийг нэлээд иш татсан байв.¹⁶¹



Хүснэгт 2.5 Хөрөнгийн санхүүжилтийн жишээ

Улс	Боловсролын түвшин	Шийдвэр гаргах түвшин	Хүлээн авагч	Хуваарилах арга	Хуваарилалтын суурь
Дани	СӨБ, Бага, Дунд	Орон нутаг	Сургууль	Тухайн үед нь	Захиргааны шийдвэр
Эстони	СӨБ	Хот/дүүрэг	Тусгай агентлаг ¹⁶²	ХО-ын хөтөлбөр	Хэрэгцээг үнэлж
	Бусад	Орон нутаг	Сургууль	Тухайн үед нь	Хэрэгцээг үнэлж
		Төвлөрсөн	Хот/дүүрэг	ХО-ын хөтөлбөр	Өрсөлдөөнт
Португал	СӨБ болон бага	Орон нутаг	Хот/дүүрэг	ХО-ын хөтөлбөр	Хэрэгцээг үнэлж
	Бага, дунд	Төвлөрсөн	Хот/дүүрэг	Тухайн үед нь	Хэрэгцээг үнэлж
	Ахлах сургууль	Хот/дүүрэг	Сонгогдсон агентлаг	ХО-ын хөтөлбөр	Хэрэгцээг үнэлж
	Ахлах сургууль	Хот/дүүрэг	Сонгогдсон агентлаг	Тухайн үед нь	Хэрэгцээг үнэлж
	СӨБ-өөс бусад	Төвлөрсөн	Хот/дүүрэг	Тухайн үед нь	Хэрэгцээг үнэлж
Австри	Бусад	Орон нутаг	Сургууль	ХО-ын хөтөлбөр	Хэрэгцээг үнэлж
		Төвлөрсөн	Орон нутаг	Тусгай санхүүжилт	Хэлэлцээ хийх
	Дунд сургууль	Төвлөрсөн	Сургууль	ХО-ын хөтөлбөр	Хэрэгцээг үнэлж
	Бусад	Төвлөрсөн	Сургууль	ХО-ын хөтөлбөр	Өрсөлдөөнт
Бельги	Бүх түвшинд	Төвлөрсөн	Сургууль	Тухайн үед нь	Захиргааны шийдвэр

Эх сурвалж: OECD (2018)

Дээрх хүснэгтээс харахад, эдгээр орнууд хөрөнгө оруулалтын хэмжээг тооцохдоо “Өрсөлдөөнт зарчмаар” болон “Хэрэгцээг үнэлэх” суурь ашиглаж, хөрөнгө оруулалт хийх эсэхээ шийдэх, зарцуулах эрх олгохдоо ихэнх тохиолдолд “хөрөнгө оруулалтын хөтөлбөр” хэрэгжүүлсэн байна. Үүнийг хөгжлийн хандлага гэж үзвэл манай улсын практик нэлээд хоцрогдсон тооцогдохоор юм. Боловсролын хөрөнгө оруулалтын шийдвэрийг “тухай үед нь шийдэх” аргаар гаргаж, хуваарилахдаа “захиргааны үнэлэмжээр шийддэг” гэж үзэж болно.

162 Улс орнуудад өөр өөр нэртэй, үүрэгтэй агентлаг, хүрээлэн, төв байдаг юм байна. Тухайлбал Өмчийн харилцааны газар, Боловсролын төлөвлөлтийн агентлаг гэх мэт



Хүснэгт 2.6 Монгол улсын практик

Улс	Боловсролын түвшин	Шийдвэр гаргах түвшин	Хүлээн авагч	Хуваарилах арга	Хуваарилалтын суурь
Монгол	СӨБ, ЕБ, НТБ	Орон нутаг	Орон нутаг	Тухайн үед нь шийддэг	Захиргааны шийдвэр
		Төвлөрсөн	Орон нутаг	Тухайн үед нь шийддэг	
			Орон нутаг	Хэлэлцээр хийх тохиолдол байдаг	

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хэрэгцээг үнэлэх

Хэрэглэгчийн оролцоогүйгээр сургалтын орчин, дэд бүтэц чанартай, хангалттай гэдгийг тодорхойлох боломжгүй. Гэхдээ зарим нэг нөхцөл биелсэн байх ёстой гэдэг талаас нь харсан хөндлөнгийн шинжилгээ хийж, 1) багш, суралцагчдад суралцахуйн үйл ажиллагаагаа явуулах хангалттай орон зай байх, 2) танхимын температур хүнд таатай байх, 3) эрүүл, аюулгүй орчны шаардлага хангасан байх, 4) ариун цэврийн шаардлагад нийцсэн байх, 5) ялгаатай хөгжилтэй суралцагчдын хэрэгцээг хангадаг байх зэрэг шалгуур тавьдаг. Тухайлбал Австрали улсын төрийн бус өмчийн сургуулийн сургалтын орчинд хийсэн нэгэн судалгаанд биет орчныг дэд бүтцийн тохиромжтой, хүрэлцээтэй байдал болон чанарын нөхцөл гэсэн шалгуураар үнэлнэ гэжээ.¹⁶³ Үүнд:

- Тохиромжтой гэдгийг барилгын насжилт, зайлшгүй хэрэгтэй тоног төхөөрөмж байгаа эсэхээр,
- Хүрэлцээтэй гэдгийг нэг суралцагчид ногдох орон зайгаар,
- Чанарын нөхцөл гэдгийг барилгад засвар хийх хэрэгцээ нь үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд саад болох хэмжээний яаралтай эсэхээр шийднэ.

Урт хугацаанд баримтлах стратеги, дэд бүтцийн хэрэгцээг тал бүрээс нь харсан цогц үнэлгээнээс биш харин санхүүгийн өнөөгийн нөөц боломжоос хөрөнгө оруулалт хамаарах нь элбэг. Бүх шатанд хуваарилалт, төлөвлөлт хийвэл хөрөнгийн санхүүжилтийг төвөгтэй болгодог байна. Тухайлбал Австрали улс 2011 онд хөрөнгийн санхүүжилтийн механизмд тойм судалгаа хийж “сургуулийн дэд бүтэц, хөрөнгийн санхүүжилтийг үр дүн муутай зохицуулж иржээ. Үүнд шат бүрд төлөвлөлт хийх, зарцуулах эрх олгосон нь нөлөөлсөн” гэж дүгнэж, хөрөнгийн санхүүжилтийг хоёр хэсэгт буюу шинэ барилгын болон байгаа барилгад хөрөнгө оруулалт хийх гэж ангилан ил тод, ойлгоход амар болгохыг зөвлөсөн байна.¹⁶⁴ Мөн энэ судалгаагаар “Сургууль төлөвлөлтийн агентлаг”-ийг муж улс бүрд байгуулахыг санал болгожээ.

¹⁶³ Survey of non-government school infrastructure in Australia, 2001

¹⁶⁴ Gonski, D. et al. (2011)



Хөрөнгийн санхүүжилтийг урсгал зардал шиг санхүүжилтийн томъёогоор хуваарилах нь ховор.¹⁶⁵ Нийлүүлэлтэд-суурилсан механизм хэрэглэж байгаагаас шалтгаалж төлөвлөлт ихэнхдээ боломжит нөөцөөс хамаарч, хөрөнгө оруулалт урт хугацааны бодлоготой уялдахгүй байх асуудал үүсч байна.¹⁶⁶ Улмаар энэ нь буруу хуваарилалт хийх эрсдэл болдог. Үүнийг шийдэхийн тулд Эстони улсын хэрэгжүүлсэн арга хэмжээг Жишээ 3-т харууллаа. Мөн Литва улс Европын Холбооны санхүүжилтээр стратегийн зорилтыг сургуулийн үйл ажиллагаатай холбох олон үүрэг бүхий төвүүд байгуулах хөрөнгө оруулалт хийжээ. Ийм маягаар эрэлт, хэрэгцээнд-суурилсан хуваарилалт руу шилжих арга замыг бусад орон ч мөн эрэлхийлж байна.



ЖИШЭЭ 10. БАРИЛГЫН ХЭРЭГЛЭЭГ ҮНЭЛЭХ БЕЛЬГИ УЛСЫН ТУРШЛАГА

Сургуулийн барилгын ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд Бельги улсын Фрэнч мужид 4 үе шаттай үнэлгээ хийдэг. Үүнд 1) шалны гадаргуу болон суралцагчдын тооноос хамааруулан хүчин чадлыг дутуу, эсвэл илүү ашиглаж байгаа эсэхийг гаргана; 2) нийт шалны гадаргуу, биеийн тамир зэрэг бусад хөгжүүлэх төрлийн хичээлийн орон зайг үндэсний нормтой харьцуулна; 3) хэрэв их хэмжээгээр дутуу эсвэл илүү ашиглаж байгаа бол газар дээр нь үнэлгээ хийх баг ажиллана; 4) анхны үнэлгээ баталгаажвал Боловсролын яам, Дэд бүтцийн яам нь ажлын хэсэг байгуулж орон зайг илүү үр ашигтай ашиглахад чиглэсэн санал боловсруулна.

Эх сурвалж: Smoos, M. (2017)



165 OECD (2017)

166 OECD (2017, хуудас 92)



2.1 Санхүүжилтийн хүрээ

Хөрөнгө оруулалт ч мөн урсгал зарлагын нэгэн адил боловсролын санхүүжилтийн үндсэн зарчмуудын дагуу хийгдэх ёстой гэж үзжээ.¹⁶⁷ Үүнд:

- Хангалттай боловсрол олж авах нөхцөл бүрдүүлж чадаж байгаа эсэх,
- Хэвтээ, босоо чиглэлээр тэгш, шударга хуваарилалт хийж чадаж байгаа эсэх,
- Үр дүнтэй байж чадаж байгаа эсэх,
- Тэнцвэрийг хангах зарчим хангагдаж, тухайн орон нутгийн хөгжлийн ялгаанаас хамаардаггүй байж чадаж байгаа эсэх,
- Санхүүжилтийн дүрэм, журам нь ил тод, ойлгомжтой байж чадаж байгаа эсэх.

Эдгээр нь тухайн үйл ажиллагааг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шалтгааныг тайлбарлах үндэслэл болдог. Яагаад төсвийн хөрөнгийг энэ удаад тухайн сум, хороо, тухайн сургууль, цэцэрлэгт зарцуулж байгааг Засгийн газар эдгээр зарчмыг ашиглан иргэд, татвар төлөгчдөд тайлбарладаг юм.

Хангалттай байдлын зарчим

Хангалттай байдлын зарчмаар суралцагчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх орчин бүрдсэн байхыг баталгаажуулна. Гэтэл бид сургалтын биет орчин нь тэнд суралцаж, ажиллаж буй хүмүүсийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийдэггүй. Ямар тохиолдолд хангалттай гэж үзэх талаар бидэнд концепц одоогоор байхгүй.

Тэнцвэрийг хангах зарчим

Сургалтын биет орчинд зарцуулж буй хөрөнгө тухайн аймаг, дүүргийн эдийн засгийн боломжоос хамаардаггүй байх зарчмыг төсвийн тэнцвэрийг хангах гэж нэрлэдэг. Орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн санхүүжилтээр хийж буй хөрөнгө оруулалтын мэдээлэл боловсролын салбарын мэдээллийн системд байхгүй учраас үнэлэх боломж хязгаарлагдмал байна.

Тэгш байдлын зарчим

Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын санхүүжилт дээр 2019 оны байдлаар тэгш байдлын зарчим хэрхэн хэрэгжиж байгааг Вариацийн коэффициент, Маклун индекс ашиглан шинжилсэн.¹⁶⁸ Харин хөрөнгө оруулалтын хувьд яагаад хэвтээ, босоо чиглэлээр санхүүжилтийн тэгш байдлыг хэмжих боломжгүй байгааг товч тайлбарлая.

167 Glenn, W. J., Picus, L. O., Odden, A., & Aportela, A. (2009). The equity of school facilities funding: Examples from Kentucky. Education Policy Analysis Archives, 17(14). Retrieved [date] from <http://epaa.asu.edu/epaa/v17n14/>.

168 Зарчмуудын талаар А.Заяадэлгэр, С.Эрдэмчимэг. (2020). Боловсролын төсвийн зарлагын шинжилгээ: Хандлага (2012-2019) болон өнөөгийн байдал (2019). НҮБХХ. Улаанбаатар, Монгол улс.- судалгаанаас уншина уу.



Босоо чиглэлээр тэгш байдлыг хангах нь ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад ялгаатай санхүүжилт хийх зарчим юм. Тухайлбал Булган, Увс аймгийн сургуулийн барилгын насжилт өөр, барилга дотор олон зүйлийн чанар, өнөөгийн байдал өөр юм. Иймд адилхан 960 хүүхдийн хүчин чадалтай сургуульд их засвар хийх өртөг ялгаатай. Суралцахуйн таатай орчныг жигдхэн бүрдүүлэхийн тулд тэрхүү ялгаатай хэрэгцээг хангах хөрөнгө оруулалт хэрэгтэй.

Хэвтээ чиглэлээр тэгш байдлыг хангах нь ижил шинжтэй суралцагчдад ижил хэмжээний төсөв зарцуулахыг шаардана. Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх өртөг төсөл бүрийн хувьд ялгаатай учраас зарцуулалт мөнгөн дүнгээр аймаг, дүүрэг бүрд тэнцүү байх хэрэгтэй гэж үзэх боломжгүй. Иймд хэвтээ чиглэлээр тэгш байдлыг хангах зарчмыг баримжаа харах эхлэлийн цэг болгож хэрэглэнэ.¹⁶⁹

АНУ-ын Кэнтаки мужийн ерөнхий боловсролын хөрөнгө оруулалтын зарлагад хийсэн шинжилгээнд¹⁷⁰

- Хэвтээ чиглэлийн тэгш байдлыг үнэлэхдээ хөрөнгө оруулалтын 1990-1991 оны хичээлийн жилээс 2004-2005 оны хичээлийн жилийн зарлага дээр тэгш байдлын 5 индексийг тооцож харьцуулсан байв.

Босоо чиглэлийн тэгш байдлын үнэлгээг тус мужийн нийт “сургуулийн барилгын чанарын үнэлгээ”-нд үндэслэн хийсэн байна. Сургуулийн барилгын чанарын үнэлгээтэй уялдуулан нийт сургуулийг бага хэрэгцээтэй (нэг суралцагчид ногдох хэрэгцээ \$3000), дунд зэргийн хэрэгцээтэй (\$3000-7000), их хэрэгцээтэй (\$7000 болон түүнээс дээш) гэсэн гурван түвшинд хувааж, “Сургуулийн тоног төхөөрөмж, барилгын зөвлөл”-ийн санал болгож буй санхүүжилт нь энэ ангилалд хэр нийцтэй

Үүнийг ашиглан тэгш байдлын зарим индексийг өөрийн улсын аймаг, нийслэлийн ерөнхий боловсрол болон цэцэрлэгийн 2016-2019 оны хөрөнгө оруулалт дээр тооцох оролдлого хийлээ. Төсвийн мэдээллээс аймаг, дүүргээр зарцуулалтыг зөв ялгах боломжгүй байв. Сангийн яамны систем (Fiscal) дээр хөрөнгө оруулалтыг төсөл хэлбэрээр бүртгэжээ. Жишээ нь тоног төхөөрөмж гэж бөөн дүн тавьснаас тухайн сургууль эсвэл дотуур байр, цэцэрлэгт ногдох хэмжээ, тоо ширхэг нь харагдахгүй байна. Зарим төслийн ард олон нэр оруулсан, эсвэл салбарын хөрөнгө оруулалт гэсэн бүхэл дүн, мөн зарим төсөл нь соёл, боловсролын салбарын тоног төхөөрөмж гэсэн нэртэй юм.

169 Glenn, W. J., Picus, L. O., Odden, A., & Aportela, A. (2009)

170 Glenn, W. J., Picus, L. O., Odden, A., & Aportela, A. (2009)



Зураг 2.1 Хөрөнгө оруулалтын төсвийн хэсэг /2019/

Төслийн код	Нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Төсөв	Санхүүжилт
	НИИТ			1,165,861.9	616,453,754	558,983,867,583
	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД			1,165,861.9	616,453,754	558,983,867,583
	Улсын төсөв			1,165,861.9	616,453,754	558,983,867,583
	Хөрөнгө оруулалт			1,121,233.3	581,470,054	525,881,793,166
XII.1.1.202	Оюутны дотуур байрын барилга /Архангай, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал сум/	2019	2020	6,000.0	3,000,000	2,940,000,000
XII.1.1.284	Хүүхдийн тоглоомын талбай, модон цамхаг бүхий цогцолбор /Архангай, Булган, Жаргалант, Ихтамир, Өндөр-Улаан, Тариат, Хангай, Цахир, Чулуут сум/	2019	2019	200.0	200,000	173,117,440
XII.1.3.3	Сумдын сургуулийн компьютер, техник хэрэгсэл /Архангай, Цэнхэр, Төвшрүүлэх, Эрдэнэбулган сум/	2019	2019	300.0	300,000	0

Эх сурвалж: СЯ

Дараах тооцоог зөвхөн баримжаа харах зорилгоор бэлтгэсэн тул иш татахгүй, шийдвэр гаргахад хэрэглэхгүй байхыг хүсье.

Хүснэгт 2.7 ЕБ-ын 2016-2019 онуудын хөрөнгө оруулалт /төг/

Аймаг_нийслэл	Сургууль /2016/	Сургууль /2017/	Сургууль /2018/	Сургууль /2019/
Архангай	3,508,115,174	2,472,478,756	148,706,900	9,658,146,297
Баян-Өлгий	4,117,262,000	2,029,826,714	3,241,435,616	5,979,590,599
Баянхонгор	399,121,000	800,899,989	3,136,086,862	15,056,118,445
Булган	4,320,761,417	2,946,361,896	3,301,311,040	9,289,479,783
Говь-Алтай	5,384,780,260	2,207,659,492	4,276,249,078	7,970,662,041
Говьсүмбэр	-	-	-	2,249,941,128
Дархан-Уул	2,736,000,000	-	224,060,000	1,120,886,331
Дорноговь	437,448,990	-	700,000,000	2,714,032,510
Дорнод	1,632,375,000	482,800,000	1,586,540,152	4,040,721,963
Дундговь	684,162,880	1,256,370,525	2,026,398,469	3,636,269,105
Завхан	2,686,882,980	3,701,499,900	4,923,291,596	6,602,024,748
Орхон	1,717,600,000	1,101,470,345	3,049,275,995	5,562,400,618
Өвөрхангай	451,716,400	690,762,310	5,410,518,700	16,057,858,526
Өмнөговь	-	-	2,100,318,179	8,411,229,904
Сүхбаатар	2,853,963,400	3,544,199,969	489,838,883	8,996,839,807
Сэлэнгэ	3,060,684,624	975,923,923	600,000,000	10,261,816,613
Төв	1,610,363,000	1,119,554,929	2,341,299,981	11,502,849,341
Увс	4,121,091,917	1,166,823,854	5,179,777,262	8,688,515,780
Улаанбаатар	11,441,402,681	9,751,268,965	57,624,445,509	81,694,226,518
Ховд	1,623,318,800	-	885,400,000	6,328,179,346
Хөвсгөл	3,770,071,185	1,687,633,765	8,426,997,807	22,419,742,666
Хэнтий	3,427,324,221	1,076,999,957	1,782,992,329	5,194,856,820
Дүн /төгрөгөөр/	59,984,445,929	37,012,535,289	111,454,944,358	253,436,388,889



Хүснэгт 2.8 СӨБ-ын 2016-2019 оны хөрөнгө оруулалт /төг/

Аймаг_нийслэл	Цэцэрлэг /2016/	Цэцэрлэг /2017/	Цэцэрлэг /2018/	Цэцэрлэг /2019/
Архангай	355,381,000		1,088,799,029	2,081,779,641
Баян-Өлгий			1,806,352,260	1,336,503,958
Баянхонгор		131,639,327	3,095,709,814	1,214,347,123
Булган	300,200,000	120,000,000		1,384,856,003
Говь-Алтай	2,173,575,200		2,143,960,867	4,494,999,999
Говьсүмбэр	140,100,000	475,629,732		819,200,000
Дархан-Уул	1,190,195,120		2,129,192,772	6,004,799,459
Дорноговь	21,252,610		450,000,000	3,877,981,762
Дорнод	1,286,610,300		1,300,000,000	3,821,333,750
Дундговь	346,038,000		996,600,000	2,992,327,079
Завхан	2,158,763,890	63,800,000	1,456,699,999	3,632,149,015
Орхон	526,296,400	423,703,045	3,191,689,392	8,301,663,468
Өвөрхангай	300,000,000	607,295,929	3,006,987,716	2,533,000,857
Өмнөговь	177,400,000		39,963,000	2,353,900,131
Сүхбаатар	981,840,000	568,917,170	79,226,000	6,996,420,235
Сэлэнгэ	795,884,820		3,769,747,805	5,598,702,117
Төв			1,302,365,700	2,662,420,624
Увс	224,827,750		1,215,859,429	7,018,398,160
Улаанбаатар	6,092,477,818	3,890,402,686	14,578,717,478	93,581,854,822
Ховд	449,999,900	615,929,015	1,000,000,000	4,300,285,250
Хөвсгөл	858,530,700	125,168,027	2,699,999,970	7,106,229,490
Хэнтий	215,546,630		1,842,000,000	5,534,712,448
Дүн /төгрөгөөр/	18,594,920,138	7,022,484,931	47,193,871,231	177,647,865,391

Хүснэгт 2.9 Хөрөнгө оруулалтын нэгтгэл

Аймаг_нийслэл	Сургуулийн хөрөнгө оруулалт, төгрөгөөр /2016-2019/	Төрийн өмчийн сургуулийн санхүүжсэн дундаж суралцагчдын тоо /2016-2019/	Цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төгрөгөөр /2016-2019/	Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын санхүүжсэн дундаж хүүхдийн тоо /2016-2019/
Архангай	15,787,447,127	17170	3,525,959,670	6120
Баян-Өлгий	15,368,114,929	20522	3,142,856,218	5793
Баянхонгор	19,392,226,296	16035	4,441,696,264	5890
Булган	19,857,914,136	9873	1,805,056,003	3511
Говь-Алтай	19,839,350,871	11267	8,812,536,066	3796
Говьсүмбэр	2,249,941,128	3372	1,434,929,732	1371
Дархан-Уул	4,080,946,331	17783	9,324,187,351	7086
Дорноговь	3,851,481,500	12508	4,349,234,372	4828
Дорнод	7,742,437,115	14500	6,407,944,050	6036
Дундговь	7,603,200,979	8056	4,334,965,079	3054
Завхан	17,913,699,224	14647	7,311,412,904	5131
Орхон	11,430,746,958	17817	12,443,352,305	7980



Өвөрхангай	22,610,855,936	21368	6,447,284,502	7344
Өмнөговь	10,511,548,083	11810	2,571,263,131	5352
Сүхбаатар	15,884,842,059	11178	8,626,403,405	4614
Сэлэнгэ	14,898,425,160	18622	10,164,334,742	7043
Төв	16,574,067,251	14843	3,964,786,324	6148
Увс	19,156,208,813	17366	8,459,085,339	5372
Улаанбаатар	160,511,343,673	219887	118,143,452,804	85300
Ховд	8,836,898,146	18476	6,366,214,165	5901
Хөвсгөл	36,304,445,423	25863	10,789,928,187	8355
Хэнтий	11,482,173,327	14073	7,592,259,078	5461
Дүн	461,888,314,465	537,032	250,459,141,691	201,487

Бид босоо чиглэлийн тэгш байдлыг онцолж, нэг суралцагчид ногдох зарлагын хэмжээ ялгаатай байж болно гэж үзэж байгаа ч


- 1) Засгийн газрын мөчлөгийн хувьд ойролцоо байх нь чухал. Бусад яаралтай асуудалтай харьцуулахад тухайн хөрөнгө оруулалт чухал биш байсан ч нэмэх гэсэн өрсөлдөөн, хандлагыг (Grow the Pie)¹⁷¹ багасгахын тулд ойролцоо хэмжээний санхүүжүүлэлт хийгдэнэ гэдэг баталгаа бодлогын бичиг баримтад байх хэрэгтэй.
- 2) Босоо чиглэлээр тэгш байдлыг хангаж байгаа учраас хэвтээ чиглэлийг зөвхөн баримжаа харах зорилгоор тооцно гэдгийг нотлох үзүүлэлт тодорхой, бас "хүчтэй" байх хэрэгтэй. Тухайлбал хөрөнгө оруулалт их хийсэн аймаг, дүүргийн хамран сургалт нэмэгдсэн байх, эсвэл бага хийгдсэн хэсгээсээ өндөр байх зэрэг үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой байх нь төсвийн хөрөнгийн шударга байдлыг хангаж буй хэрэг юм. Гэтэл ийм холбоос алга байна.

2020-2021 оны хичээлийн жилийн өмнөх 4 жилд (2016-2019) хийсэн хөрөнгө оруулалтын нэг суралцагчид ногдох хэмжээ 2020-2021 оны хичээлийн жилийн төрийн өмчийн сургуулийн суурь боловсролын хамран сургалтын өсөлт, бууралтын хооронд хамаарал байхгүй.

171 <https://www.bbc.com/news/magazine-17063200>



Зураг 2.2 ЕБ-ын хамран сургалт болон хөрөнгө оруулалт



Хөрөнгө оруулалтын тэгш байдлын үзүүлэлт стандарт хэмжээнээс ихээхэн доогуур байна.




Хүснэгт 2.10 2016-2019 оны хөрөнгө оруулалтын тэгш байдлын үзүүлэлт

Үзүүлэлт	ЕБ-ын 2016-2019 оны хөрөнгө оруулалтын дундаж үзүүлэлт	Төгс сайн байх түвшин	СӨБ-ын 2016-2019 оны хөрөнгө оруулалтын дундаж үзүүлэлт
Дундаж	955,174		1,157,884
Медиан	904,767		1,185,172
Стандарт хазайлт	429,153		464,848
Вариацийн коэффициент	44.9%	0%	40.1%
Маклун индекс	75.1%	100%	--

Цэцэрлэгийн насны нийт хүн амаар тооцсон хамран сургалт болон энэ хичээлийн жил хүртэлх 4 жилд (2016-2019) хийсэн хөрөнгө оруулалтын хооронд корреляцийн хамаарал байхгүй байна.

Зураг 2.3 Цэцэрлэгийн хамран сургалт болон хөрөнгө оруулалт





2.2 Зарим арга хэмжээний санхүүжилт

Сургалтын биет орчинтой холбоотой зарим арга хэмжээг бусад улс хэрхэн санхүүжүүлж байгааг энд товч авч үзлээ.

Засвар, үйлчилгээний санхүүжилт

Засвар, үйлчилгээг хоёр ангилж болно. Сургуулийн барилга, тоног төхөөрөмжид байнгын засвар үйлчилгээ, хамгаалалт, арчилгаа хэрэгтэй. Жижиг ажил (minor works) ангилалд хөрөнгийн зардалд багтахгүй дэд бүтцийн зардлууд, тухайлбал цэвэрлэгээ үйлчилгээ, хадгалалт хамгаалалт, арчилгаа, засвар, бага өртөгтэй МХХТ-ийн хэрэгсэл авах, засварлах, сэлбэг авах, бага үнэтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авах зардал багтана.

Дэд бүтцийн арчилгаа, хамгаалалтын санхүүжилтэд улс орнууд “тухайн үед нь шийдэх” (Ad hoc grant), “мэргэжлийн шийдвэр гаргах” аргыг түгээмэл хэрэглэдэг байна. Жижиг засвар, үйлчилгээ, хадгалалт, хамгаалалтын зардлыг урсгал төсөвт тусгадаг ч ингэж нарийн ялгахад төвөгтэй байдаг талаар бичжээ. Төлөвлөгөөт завсар үйлчилгээ хийх (Routine maintenance) Их Британи улсын хөтөлбөрийг сайн туршлагаар нэрлэсэн байв.¹⁷² Австрали улс хөрөнгийн арчилгаа үйлчилгээний зардал тухайлбал цэвэрлэгээ, ашиглалт, барилгын хадгалалт, арчилгаа, завсар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг тооцохдоо элсэлт, сургуулийн хэмжээ, хүн амзүй, газарзүйн байрлал, хөрөнгийн байдал зэргээс хамааруулан тогтоодог.¹⁷³ Төлөвлөлт, хуваарилалтыг Хөрөнгийн менежментийн эсвэл Барилгын менежмент, Засварын ажил хариуцсан нэгж хэмээх төрийн байгууллага хариуцдаг байна. Төрийн өмчийн арчилгаа, хамгаалалт төрийн бус өмчийн сургуулийнхаас муу байдаг гэжээ.¹⁷⁴

Харин барилгын их засвар, тоног төхөөрөмж солих, эд хогшил худалдан авах, шинэчлэх нь хөрөнгийн санхүүжилтэд хамаарна. Их засвар, тоног төхөөрөмж солих, худалдан авах, шинэчлэх ажлын (major works) төлөвлөлт, санхүүжилт нь бусад улсад ч шүүмжлэлд өртдөг юм байна. Хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагад тэгш байдлын зарчимд нийцэх, ил тод байх, хэрэглэж буй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн байх, тухайн орон нутаг нь ашиг тусыг нь хүртдэг байх, давхардахгүй байх, зах зээлийн үнийн зарчимд нийцэх зэрэг зарчим багтана.¹⁷⁵

Шинжлэх ухааны хичээл заах орчин бүрдүүлэх санхүүжилт

Хөгжиж буй орнуудад шинжлэх ухааны боловсрол элит хүүхдүүдэд илүү хүртээмжтэй хэвээр байна.¹⁷⁶ Бага ангид шинжлэх ухааны хичээл заах зорилт сургалтын хөтөлбөрт багтсан хэдий ч сургуулийн нөөц, боломжоос шалтгаалан хангалттай сайн хэрэгжихгүй байна. Өндөр өртөгтэй лаборатори ашиглах нь өртөг-

172 Гарын авлага байдаг юм байна.

173 Gonski, D. et al. (2011)

174 Gonski, D. et al. (2011)

176 Lewin (2013): Access to post primary science education remained the preserve of small elites in poor countries.



үр ашгийг сайтар дэнслэхэд хүргэдэг. Австрали улс анх 60-аад оны эхээр сургуулиудад шинжлэх ухааны лаборатори, тоног төхөөрөмж худалдан авахад нь зориулж томъёо ашигласан. Гэхдээ цаашид зөвхөн урсгал санхүүжилтэд хэрэглэх болжээ.¹⁷⁷

Манай улс анх удаа энэ чиглэлд (STEM) ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийгээд байна. Дараах хүснэгтэд 2020 онд нийлүүлсэн лабораторийн тоног төхөөрөмжийн нэгтгэлийг харуулав.

Хүснэгт 2.11 Лабораторийн хөрөнгө оруулалт

21 аймгийн нэгтгэл	Сургуулийн тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ /төг/
Математик	430	1,450,435.04	623,687,068
Физик	85	39,190,053.18	3,331,154,520
Хими	64	16,446,267.80	1,052,561,139
Дизайн технологи	53	39,366,265.13	2,086,412,051
Аудио-видео	202		423,350,545
			7,517,165,324
9 дүүргийн нэгтгэл	Сургуулийн тоо	нэгжийн үнэ	нийт үнэ
Математик	125	1,450,435.04	181,304,380
Физик	49	39,190,053.18	1,920,312,605
Хими	36	16,446,267.80	592,065,640
Дизайн технологи	29	39,366,265.13	1,141,621,688
Аудио-видео	114		220,389,408
			4,055,693,724
		НИЙТ	11,572,859,049

Эх сурвалж: АХБ-ны зээлээр хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" төсөл

Сургалтын материалын санхүүжилт

ПИСА (2015) үнэлгээний тайланд "сургалтын орчин, материалын хүрэлцээгүй байдлын индекс" тооцон боловсролын үр дүнд нөлөөлдөг эсэхийг нь харуулсан байв. Индексэд 1) биет орчны дэд бүтэц бүрдээгүй байх, үүнд сургуулийн барилгын нөхцөл байдал, халаалт, хөргөлтийн систем, сургалтын орон зай, 2) сургалтын материалын хомсдол, үүнд сурах бичиг, лабораторийн тоног төхөөрөмж, хичээл сургалтын материал, компьютер багтана. Сургалтын орчин, материалын хүрэлцээгүй байдлын индексийг сургуулийн захирлуудын асуулгад багтааж, "тийм" гэсэн хариулт нь хомсдол сургалтын үйл ажиллагаанд нөлөөлдөг гэсэн утгатай аж. Эндээс дараах дүгнэлт хийжээ.¹⁷⁸ Үүнд:

177 This Act, which provided grants for science laboratories and equipment in government and non-government secondary schools, marked the Australian Government's substantive entry into school funding.

178 On average across OECD countries, student learning in rural schools is also hindered to a greater extent than in urban schools by a lack or inadequacy of the material resources. In as many as 35 out of 57 education systems, the capacity of public schools to provide instruction is more likely to be hindered by a shortage of educational material than private schools. Only in Malta and Singapore do public schools enjoy more and better educational materials than private schools, according to principals' reports (PISA 2015 Report Vol II)



- хөдөө, орон нутгийн сургуульд, сургалтын дэд бүтэц, материалын дутагдал нь сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хэмжээнд байдаг.
- асуулгад оролцсон 57 улсын 35-д нь төрийн өмчийн сургуульд сургалтын орчин, материалын дутагдал хувийн сургуультай харьцуулахад их юм.

Хичээл, сургалтын материал (Teaching and Learning materials) гэдэг нь сурах бичиг болон ерөнхий зориулалттай ном, зохиол (reference books) зэрэг *хэвлэмэл материал*, багш, суралцагчийн ашиглаж буй компьютер, хэвлэгч, цахим хэрэгсэл, е-ном, программ хангамж зэрэг *технологид суурилсан материал*,¹⁷⁹ туршилт хийх зориулалттай багаж хэрэгсэл, туршилтын бодис зэрэг сургалтад шууд хэрэглэх эсвэл *нэг удаагийн материал*, аялал, хэлэлцүүлэг, зочин урих зэрэг *мэргэжлийн үйлчилгээ* багтана.

Сургалтад ашиглах материал (Instructional materials) гэдэг нь багш, суралцагчдын танхимд хичээллэх үед тухайн хичээлдээ ашиглах материал юм. Жишээ нь:

- Дасгал, дадлага хийхдээ хэрэглэж дуусах материал (хүнсний материал)
- Туршилт хийх (ургамал тарих, цэцэрлэгжүүлэлт хийх, химийн туршилт хийх бодис)
- Физикийн хууль тайлбарлахад хэрэглэх материал (соронз зэрэг дахин хэрэглэж магадгүй зүйлс бас багтана),
- Симуляци хийх бага оврын машин хэрэгсэл, ямар нэг зүйлийг засах, сэлбэхэд ашиглагдах зүйлс,
- Дүрслэх урлаг, технологийн хэрэгсэл, хөгжмийн зэмсгийн сэлбэг,
- Эмнэлгийн болон конторын үйл ажиллагааг танилцуулахад хэрэглэх материал гэх мэт үргэлжилнэ.

ПИСА 2015-ын тайлангаас харахад, шалгалтад хамрагдсан суралцагчдын 82 нь сурах бичгийг багш сонгох үүрэгтэй, харин 32 хувь нь сургуулийн захиргаа сонгох эрхтэй гэж хариулжээ.

Сургалтын материалын санхүүжилт сүүлийн үед ихээхэн анхаарал татах болсон бөгөөд “багш нараас л бүх зүйл шалтгаална” гэдэг сургамж авч болохоор байна. МХХТ, шинжлэх ухааны лаборатори, материалын санхүүжилт хэрэгтэй эсэх нь багш нарын арга барил, хөгжлөөс шалтгаалах бөгөөд багш нар гараар туршилт хийх, төсөлд суурилсан аргыг сонирхдоггүй бол өндөр өртөгтэй шинжлэх ухааны

179 Technology-based materials include, but are not limited to, software programs, video disks, compact disks, optical disks, video and audiotapes, lesson plans, and databases.



хэрэгсэл хий дэмий хөрөнгө болдог гэсэн байв.¹⁸⁰ Туршилт, гараар хийх аргаар шинжлэх ухааны санааг бодит амьдрал дээр туршиж үзэх нөхцөл бүрдэж, багш нар бэлтгэгдсэн байх нь чухал.¹⁸¹

Сургалтын материалын санхүүжилт нь санхүүжилтийн томьёоны нэг хэсэг байдаг. Томьёоны сүүлийн үеийн хандлага нь “Суралцахуй, хөгжлийн шинжлэх ухааны” (SoLD) хүүхдийг бүх талаар нь хөгжүүлэх онолын (Whole-child development)¹⁸² дагуу хөгжих, суралцагчийн хэрэгцээг хангахад чиглэх юм байна. АНУ-ын Калифорни мужийн санхүүжилтийн томьёог харна уу.¹⁸³ Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн хичээлийн сургалтын материалын санхүүжилтэд хийсэн судалгаанууд “багш нар хэрэгцээгээ гаргаж, санхүүжилт авах эрхийг багш нарт өгөх нь илүү үр дүнтэй, оновчтой” гэж үзэж байна.¹⁸⁴

Компьютер болон Интернэтийн санхүүжилт

ЭЗХАХБ-ын орнуудад нийгэм-эдийн засгийн хувьд сул нөхцөлд байгаа сургуулиудад нэг компьютерыг хэрэглэж буй суралцагчийн тоо өндөр байдаг.¹⁸⁵ Энэ нь нийгэм эдийн засгийн хувьд хөгжил доогуур гэр бүлд амьдарч буй суралцагчдын гэрт нь интернэт хязгаартай, компьютерын хүрэлцээ тааруу гэсэн таамаглалд үндэслэсэн “нөхөх” хэлбэртэй хөрөнгө оруулалтын үр дүн юм.¹⁸⁶ Гэхдээ ихэнх улсад интернэтийн холболт орон нутагт тааруу, төрийн сургуульд хувийн сургуулиас доогуур хэвээр байна.¹⁸⁷

180 OECD (2017, хуудас 96)

181 ПИСА (2015): Ensure that science laboratory work is meaningful Experiments and hands-on activities can be inspiring and can help students develop a conceptual understanding of scientific ideas and transferable skills, such as. However, the opportunity costs of these instructional methods can be high.

182 Linda Darling-Hammond, Lisa Flook, Channa Cook-Harvey, Brigid Barron & David Osher (2020) Implications for educational practice of the science of learning and development, Applied Developmental Science, 24:2, 97-140, DOI: 10.1080/10888691.2018.1537791

183 <https://www.cde.ca.gov/eo/in/lcfff1sys-pri1res.asp>

184 Жишээ нь Gomendio, M. (2017), Empowering and Enabling Teachers to Improve Equity and Outcomes for All, International Summit on the Teaching Profession, OECD Publishing, Paris. Мөн Emily Martha Cayton (2018) Exploring Funding for Instructional Materials in Secondary Science Classrooms

185 Student to computer ratio

186 OECD (2015)

187 PISA (2015)



Хүснэгт 2.12 Компьютерийн хангамж

Үзүүлэлт	Суралцагч-компьютерийн тооны харьцаа	Интернэтэд холбогдсон байдал
ЭЗХАХН-ийн орнуудын дундаж	4.7: 1	96%
Их хэмжээ (Australia, Austria, Canada, the Czech Republic, Iceland, Macao (China), New Zealand, the United Kingdom and the United States)	1: 1	>95%
Бага хэмжээ (Tunisia)	53: 1	<70%

Эх сурвалж: OECD (2015), Students, Computers and Learning: Making the Connection, PISA, OECD Publishing.

АНУ-ын Теннесси мужийн төрийн өмчийн сургуулиудад хийсэн нэгэн судалгаа дараах шалгуурыг санал болгосон байна.¹⁸⁸ Үүнд:

- Суралцагч-компьютерын тооны харьцаа 2:1 эсвэл 1:1 бол технологийн өндөр боломжтой.
- Суралцагч-компьютерын тооны харьцаа 3:1, 4:1, эсвэл 5:1 бол технологийн дунд зэргийн боломжтой.
- Суралцагч-компьютерын тооны харьцаа 6:1 болон түүнээс өндөр бол технологийн боломж бага гэж үнэлнэ.

Манай улсын төрийн өмчийн сургуульд 2020-2021 оны хичээлийн жилийн мэдээгээр 24 суралцагчийн дунд 1 компьютер байна. Суралцагч-компьютерын тооны харьцаа

$$= \frac{2020 - 2021 \text{ оны хичээлийн жилийн элсэлт}}{\text{Компьютерийн тоо}} = \frac{632,499}{26,557} = 24:1$$

188 <https://dc.etsu.edu/cgi/viewcontent.cgi?article=4723&context=etd>



3. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх

санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ гэжээ. Төсвийн хөрөнгө оруулалтыг “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ” хэлбэрээр бид төлөвлөдөг.

Хөрөнгө оруулалтыг шударга байлгахад анхаарах хэрэгтэй байгаа энэ үед бүхнийг ил тод, нэг хавтгай дээр байрлуулснаар олон нийтийн хяналтыг сайжруулна. Боловсролын салбар ихэнхдээ сургуулиа платформ болгож “сургууль дээрээ хүн амаа авчирч” төлөвлөдөг. Сүүлийн үед мэдээллийн олдоц сайжирч, технологи хөгжсөнтэй холбоотойгоор “газар нутаг дээрээ боловсролын үйлчилгээг авчирч” төлөвлөж байна. Үүнд газарзүйн мэдээллийн систем ашигладаг. Сургуулийн зураглал (School mapping) нь орон нутгийн түвшинд хэрэглэх микро төлөвлөлт бөгөөд анхны зориулалт нь

- Шинэ сургууль хэрэгтэй эсэх, хэрэгтэй бол хаана барих,
- Одоо байгаа сургуулиуд хүн амд үйлчилж чадаж байгаа эсэх,
- “Хэрвээ” гэдэг асуултад хариулах шинжилгээ хийхэд туслах байв.¹⁸⁹

Харин газарзүйн мэдээллийн систем (GIS) буюу мэдээллийг цуглуулах, хадгалах, шинжлэх, харуулах зориулалт бүхий системийг боловсролын мэдээллийн системтэйгээ холбон макро түвшний төлөвлөлт, шийдвэр гаргахад хэрэглэдэг. Боловсролын төлөвлөлтөд өргөн хэрэглэж үзсэн улсын туршлагаас харахад орон нутгийн түвшинд техникийн чадавх бүрдүүлэхгүйгээр газарзүйн мэдээллийн системийг үндэсний түвшинд ашиглах нь үр дүн муутай (санхүүгийн болон техникийн хувьд өндөр өртөгтэй) байсан байна.¹⁹⁰ Ийм дүгнэлт хийхэд нөлөөлсөн хүчин зүйл нь тухайн үеийн программ хангамжийн хөгжил байсан байж магадгүй. Орчин үед энэ асуудлыг амархан шийдэх боломжтой.

Сургалтын дизайн, багшлахуйн загвараас үүсэх багш, суралцагчдын хэрэгцээ нь манай улсын боловсролын салбарын хувьд реформын шинжтэй асуудал болж хуримтлагдсан учир үүнийг тусад нь авч үзэх шаардлагатай гэж үзэж байна. Харин энэ хэсэгт одоо байгаа барилгын хувьд төлөвлөлтийн өнөөгийн практикийг хэрхэн сайжруулж болох талаар санал боловсруулъя.

189 Agrawal & Gupta (2016)

190 Hite, S. (2011)



Хүснэгт 3.1 Хөрөнгө оруулалт төлөвлөх зарим арга хэмжээ

БАЙГАА БАРИЛГЫН ХУВЬД	ШИНЭ ХЭРЭГЦЭЭ
- Хүрэлцээтэй эсэх- өргөтгөх - Шийдэх асуудал байгаа эсэх- шугам сүлжээ, тавилга, тоног төхөөрөмж	- Хүн амын хэрэгцээнд нийцэж байгаа эсэх- шинэ барилга - Суралцагчид болон багшийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэх- шинэ концепц, шинэ дизайн
<u>Орхигдож буй хэрэгцээ (Байгаа барилгын хувьд ч, шинээр барих барилгын хувьд ч)</u> - Суралцагчийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэх - Багшид тусалж чадахаар байгаа эсэх	

3.1 Ерөнхий боловсрол

Ерөнхий боловсролын үйлчилгээг төлөвлөхдөө эхлээд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгээс эхлэн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамруулан бүхий л зорилго, зорилт болон чиглэлийг харна.

Дунд хугацаанд боловсролын салбар нь Алсын хараа 2050-д зааснаар “2.Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна.” Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур, хүрэх төвшнөөс дунд хугацааны зорилтыг харъя.

Хүснэгт 3.2 “Үндсэн чиглэл”-ийн үр дүнгийн шалгуур

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 ОН)	Зорилт
11	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	94.9	95.9	1 функтээр өсгөх
12	7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	хувь	61.6, 51.5	70	18.5-17.5 функтээр өсгөх
14	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	31.1 хот-34.6, хөдөө-28.5	25 хот-30, хөдөө-25	9 функтээр бууруулах
15	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)	тоо	Цэцэрлэг-33, ЕБС: хотод-35, хөдөө - 28	25-30	9 функтээр бууруулах

Эх сурвалж: Эхний 5 баганыг Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаас авав.

Эдгээрийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын төлөвлөсөн үйл ажиллагаа, нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг “Монгол Улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх 5 жилийн



үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс харна.

Хүснэгт 3.3 Засгийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	2025 он хүртэл
2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ:	
2.3.9.2.200 шинэ сургууль ашиглалтад оруулах	200
2.3.9.3.тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх;	6 ¹⁹¹
2.3.9.4.жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	4596 ¹⁹²
2.3.10.Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгоно.	Хоол үйлдвэрлэлийн бэлтгэл хангасан байна.
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.	Төрийн өмчийн 672 сургууль, 540 дотуур байр
2.3.11.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.	672 сургууль, 913 цэцэрлэг

Эх сурвалж: Эхний баганыг Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаас авав.

Дээрхээс боловсролын салбар нь дунд хугацаанд 1) хүчин чадлаа нэмж, сургуулийн ачааллыг бууруулах, 2) орчны дэд бүтцийг сайжруулахад анхаарах юм байна гэж дүгнэж болохоор байна.

3.1.1 Эрэлт, нийлүүлэлтийг таамаглах

Боловсролын үйлчилгээний өнөөгийн түвшин (бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ) нь дунд хугацааны эрэлттэй нийцэх эсэхийг харна. Ингэхдээ үндэсний хэмжээнд болон аймаг, дүүрэгт, улмаар сум, хорооны нутаг дэвсгэрээр сургуулийн хүчин чадал нь элсэлтэд хүрэлцэхээр байгааг тооцно.

¹⁹¹ Одоогоор дагнасан 6 сургууль бий.


¹⁹² БУМС дээр 2019 онд 4596 гадаа жорлон байгаа гэсэн мэдээ байна.



- 1) Нийт хүн ам → 2) Сургуулийн насны хүн амын өсөлт, төлөв
→ 3) Нийлүүлэлт хийх хүчин чадал → 4) Нэмэлт хэрэгцээ

Эхлээд боловсролын үйлчилгээний ирээдүйн ачааллыг харья. ҮСХ-ноос 2017 онд гаргасан “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо”-ноос монгол улсын сургуулийн насны (6-17) хүн ам 2030 он хүртэл тасралтгүй өссөөр байх хэдий ч түүнээс цааш тогтонги байхаар харагдаж байна.¹⁹³

Зураг 3.1 Сургуулийн насны тооцсон хүн ам



Эх сурвалж: Хүн амын тоог 1212 мян-ээс

Эндээс 2024-2025 оны хичээлийн жилд элсэлт 280.5 мянгаар нэмэгдэж, ийм хэмжээний танхимын хүчин чадал хэрэгтэй гэж шууд тооцох боломжгүй. Баримжаатай таамаглал хийхийн тулд хамран сургалтыг тооцож, **ачаалал хаана ирэхийг заавал харна.**¹⁹⁴

2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн 672¹⁹⁵ сургуулийн хүчин чадал 452,533 суудал байсан бол 2019-2021 онд шилжих барилгын /115 сургуулийн/ 50,598 суудлыг нэмээд 2021-2022 оны хичээлийн жилд 476,131 суудалтай болох юм байна. Энэ нь одоогоор тодорхой болсон нийлүүлэлтийг харуулна.

¹⁹³ ҮСХ-ны тооцсон хүн амыг ашиглав.

¹⁹⁴ Үүнд ҮСХ-ны тооцсон хүн амын өсөлтийн дундаж хувийг ашиглав.

¹⁹⁵ Нийслэлд нэг цогцолбор сургууль 3 сургууль болж, нийт 674 төрийн өмчийн сургууль гэж тоологдож байна.



Хүснэгт 3.4 2021-2022 оны хичээлийн жилийн хүчин чадал

Аймаг_нийслэл	2020 онд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургуулийн тоо	2019-2020 онд шилжих сургууль	2021 онд үйл ажиллагаа явуулах төрийн өмчийн сургуулийн тоо	Барилгын хүчин чадал /2020 оны байдлаар	2021 онд нэмэгдэх суудал	2021- 2022 оны ХЖ-ийн барилгын хүчин чадал
Архангай	30	8	38	15,930	2,090	18,020
Баян-Өлгий	38	6	44	16,959	1,880	18,839
Баянхонгор	29	10	39	12,567	4,260	16,827
Булган	22	1	23	14,075	240	14,315
Говь-Алтай	28	3	31	12,987	960	13,947
Дорноговь	20	1	21	12,036	320	12,356
Дорнод	23	2	25	13,421	960	14,381
Дундговь	19		19	9,544		9,544
Завхан	30	7	37	14,285	2,800	17,085
Өвөрхангай	32	3	35	17,653	800	18,453
Өмнөговь	22	3	25	8,924	1,600	10,524
Сүхбаатар	16	3	19	8,325	1,760	10,085
Сэлэнгэ	34	3	37	16,382	1,080	17,462
Төв	30	5	35	14,327	2,200	16,527
Увс	27	4	31	13,173	1,280	14,453
Ховд	25	3	28	17,507	1,200	18,707
Хөвсгөл	34	10	44	20,204	3,900	24,104
Хэнтий	25	7	32	15,037	3,580	18,617
Дархан-Уул	17	1	18	13,996	480	14,476
Улаанбаатар	149	30	179	141,872	16,820	158,692
Орхон	19	3	22	14,099	1,428	15,527
Говьсүмбэр	5	2	7	2,230	960	3,190
Дүн	674	115	789	425,533	50,598	476,131

2020 онд 6-14 настай 596.7 мянган хүн амаас 2020-2021 оны хичээлийн жилд 540.1 мянга нь төрийн өмчийн сургуульд элсэж, хамран сургалт улсын хэмжээнд **90.5 хувь**, 15-17 настай 127.5 мянган хүн амын 92.4 мянга буюу **72.5 хувь** нь төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд элссэн байв.¹⁹⁶ Хувийн сургуулийн хамран сургалтад оруулж буй хувь нэмэр **6.6 хувь**. Барилгын хүчин чадал ашиглалтын коэффициент $632.5/425.5 = 1.49$

196 Үлдсэн 15% нь МСҮТ-д элссэн байж болно.



Хүснэгт 3.5 2020-2021 оны хичээлийн жилийн үзүүлэлт

Аймаг_нийслэл	2020 оны эцэст 6-14 настай хүн ам	2020 оны эцэст 15-17 настай байх хүн ам	2020-2021 оны төрийн өмчийн сургуулийн элсэлт	Төрийн өмчийн сургуулийн суурь боловсролын хамран сургалт /2020-2021/	Ашиглалтын коэффициент /2020-2021/
Архангай	17,171	4,090	18,699	91.7%	1.17
Баян-Өлгий	20,627	5,873	22,672	88.3%	1.34
Баянхонгор	16,490	3,828	17,701	93.8%	1.41
Булган	10,623	2,406	11,124	89.0%	0.79
Говь-Алтай	10,348	2,785	11,901	95.3%	0.92
Дорноговь	13,218	2,966	14,499	95.3%	1.2
Дорнод	15,313	3,293	16,991	95.3%	1.27
Дундговь	7,868	2,074	8,457	92.2%	0.89
Завхан	13,256	3,162	15,535	97.2%	1.09
Өвөрхангай	20,976	5,242	23,271	93.8%	1.32
Өмнөговь	12,769	2,767	14,134	96.1%	1.58
Сүхбаатар	11,314	2,588	12,866	97.3%	1.55
Сэлэнгэ	19,204	4,590	20,904	92.1%	1.28
Төв	16,665	3,654	17,286	90.6%	1.21
Увс	16,430	4,194	18,261	93.3%	1.39
Ховд	17,079	4,348	20,206	96.9%	1.15
Хөвсгөл	25,260	5,968	29,009	96.1%	1.44
Хэнтий	14,019	3,467	15,661	95.6%	1.04
Дархан-Уул	18,657	3,877	20,553	93.9%	1.47
Улаанбаатар	277,321	51,784	277,762	86.6%	1.96
Орхон	18,544	3,806	20,988	95.7%	1.49
Говьсүмбэр	3,556	745	4,019	96.5%	1.8
Дүн	596,708	127,507	632,499	90.5%	1.49

Сургуульд хамрагдах магадлалтай хүн амыг тооцохдоо суурь боловсролын хамран сургалтыг **98 хувь**, ахлах сургуулийн элсэлтийг **85 хувь** байхаар тооцов.

2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 1-12 дугаар ангид 817.7 мянган (661.4+156.3) суралцагч элсэх боломжтой. Үүнээс төрийн бус өмчийн сургуулийн элсэлтийг 2020-2021 оны хичээлийн жилийн түвшинд тооцож хасвал, төрийн өмчийн сургуулийн элсэлт 2024-2025 оны хичээлийн жилд 769.7 мянга байх магадлалтай. 2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургуульд 632,499 суралцагч элссэн тул нэмэлт элсэлт 137,179.

Одоо баригдаж буй сургуулийн барилгын хүчин чадлыг, 2020-2021 оны элсэлт дээрээ нэмж тооцоход 2024-2025 оны хичээлийн жил хүртэл дахин **86.6 мянган суралцагч багтаах хүчин чадал хэрэгтэй** байна. Төрийн өмчийн сургуулиудын өнөөгийн ээлжийг үргэлжлүүлнэ гэж үзвэл 86.6 мянган суралцагч нэмж багтаах барилгын хүчин чадал /онолын хүчин чадал/ хэрэгтэй болно.



Хүснэгт 3.6 2024-2025 оны хичээлийн жилийн үзүүлэлтийн төсөөлөл

Аймаг_нийслэл	Элсэлтийн таамаглал /98%/ / I-IX анги/	Элсэлтийн таамаглал /85%/ /X-XII анги/	2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтийн таамаглал	2024-2025 оны хичээлийн жилийн төрийн өмчийн сургуулийн элсэлтийн таамаглал
Архангай	18,432	4,626	23,058	23,026
Баян-Өлгий	22,671	5,561	28,232	25,916
Баянхонгор	17,873	4,366	22,239	21,807
Булган	11,154	2,978	14,132	14,132
Говь-Алтай	10,612	2,859	13,471	13,471
Дорноговь	14,163	3,514	17,677	17,547
Дорнод	17,087	4,028	21,115	20,684
Дундговь	8,610	2,303	10,913	10,913
Завхан	13,429	3,862	17,291	17,291
Өвөрхангай	22,380	5,793	28,173	28,173
Өмнөговь	14,482	3,375	17,857	17,857
Сүхбаатар	12,843	2,865	15,708	15,708
Сэлэнгэ	20,249	5,251	25,500	25,222
Төв	18,127	4,486	22,613	22,579
Увс	17,265	4,618	21,883	21,616
Ховд	18,545	4,554	23,099	23,099
Хөвсгөл	26,552	6,876	33,428	33,359
Хэнтий	15,131	3,886	19,017	18,928
Дархан-Уул	20,354	4,973	25,327	23,159
Улаанбаатар	316,940	69,686	386,626	346,410
Орхон	20,544	4,951	25,495	23,928
Говьсүмбэр	3,948	905	4,853	4,853
Дүн	661,391	156,316	817,707	769,678

2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургуулийн барилгын хүчин чадал ашиглалтын коэффициент = Элсэлт/(Хүчин чадал) = 769.7/476.1 = 1.62 болж магадгүй.




Зураг 3.2 Хүчин чадал ашиглалтын харьцуулалт

Хүчин чадал ашиглалт /2020-2021/



Хүчин чадал ашиглалт /2024-2025/



Дундаж хүчин чадал ашиглалт Улаанбаатарт хамгийн өндөр, хүндрэх магадлалтай 2 дахь хэсэг нь Өмнөговь, Дархан-уул, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг байна. Харин Булган, Говь-Алтай, Хэнтий, Дундговь, Завхан аймагт хүчин чадал нэмэх биш, сургуулийн чанарыг сайжруулах төсөл хэрэгтэй.

2021-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулсан хүчин чадал өргөтгөх төслүүдийг дээрхийн дагуу “яаралтайгаар нь” эрэмбэлж болно. Гэхдээ эхлээд боловсролын салбарын мэдээллийн систем дээрх хүчин чадлын өгөгдлийг сайтар шалгаж баталгаажуулах хэрэгтэй.

Дараах зурагт төрийн өмчийн нэг сургуулийн дундаж ачаалал 2024-2025 оны хичээлийн жилд ямар байхыг харуулав. Гэхдээ аймгуудыг сумаар нь, дүүргүүдийн хороогоор нь нарийн шинжилбэл хүчин чадлыг нэмэх биш, жигд болгох замаар нэмэгдэл эрэлтийг шийдэх боломж байгаа эсэх нь илүү тодорхой харагдана.



Зураг 3.3 Төрийн өмчийн нэг сургуульд 2025 онд ногдох сургуулийн насны хүн ам



Эрэлтийг гаргасны дараа сургуулийн орчны талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийнэ. Ийм аргаар нийлүүлэлт хийх боломж, нөхцөлөө гаргадаг. Бусад улс ч мөн адил. Тухайлбал Чех улс эхний өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэхдээ онцгой анхаардаг байна. Улсын төсвөөс санхүүжилт авах сургууль бүр боловсролын мэдээллийн систем дээр хийгдэх “сургуулийн бүртгэл”-д хамрагдах ёстой. Үүнийг Боловсролын яам нь хийдэг. Ингэж бүртгүүлэхдээ бүх төрлийн мэдээллийг заавал оруулсан байх, ямар нэг өөрчлөлт гарсан бол дараа жилийн санхүүжилтээс өмнө шинэчилсэн байх шаардлагатай ажээ.¹⁹⁷

Зарим улс хүчин чадлыг сургалт явуулах зориулалттай танхимын орон зайгаар (Instructional Space Model) тооцсон байв. Анги танхимыг зориулалтаар нь ялгаснаар сургалт явуулах наад захын орчин бүрдэж байгаа эсэхийг үнэлэх боломжтой байна. АНУ-ын нэгэн хотын боловсролын мастер төлөвлөгөөний жишээг доор харууллаа.¹⁹⁸ Бельги, Австрали, Их Британи улсын практик үүнтэй төстэй юм.

Хүснэгт 3.7 Танхимын багтаамжийг тооцох жишээ

Хичээлийн танхимын төрөл	Нэг өрөөнд хичээллэх суралцагч (хамгийн их)
Цэцэрлэг	18
Энгийн хичээлийн танхим (1-2 дугаар анги)	25
Энгийн хичээлийн танхим (3-12 дугаар анги)	30
Шинжлэх ухааны хичээл (6-12 дугаар анги)	3
Хөгжим (6-12 дугаар анги)	40
Биеийн тамир (6-12 дугаар анги)	25

197 MSMT (2016)

198Rapid City South Dakota- <https://www.rcasfuture.org/wp-content/uploads/2018/08/RCAS-Facilities-Master-Plan-05-Capacity-and-Utilization.pdf>



Дүрслэх урлаг (6-12 дугаар анги)	25
Компьютерын лаб	
Тусгай хэрэгцээт сургалт (1-5 дугаар анги)	10
Тусгай хэрэгцээт сургалт (6-12 дугаар анги)	12

Эх сурвалж: <https://www.rcasfuture.org/wp-content/uploads/2018/08/RCAS-Facilities-Master-Plan-05-Capacity-and-Utilization.pdf>

Хүснэгт 3.8 Сургалтын танхимаар хүчин чадлыг тооцох жишээ

Өрөөний төрөл/сургалтын орон зай	Сургуульд байгаа танхимын тоо	Нэг танхимд хичээллэх суралцагчийн тоо	Хүчин чадал
Энгийн хичээлийн танхим /уламжлалт анги/ (3-12 дугаар анги)	47	30	1410
Шинжлэх ухааны хичээлийн лаб (6-12)	9	28	252
Компьютер лаб	2	0	0
Дүрслэх урлаг (Арт)	3	25	75
Хөгжим (6-12)	4	40	160
Мэргэжлийн боловсрол (6-12)	5	25	125
Биеийн хөгжлийн боловсрол ¹⁹⁹ (6-12)	5	25	125
Тусад нь сургалт явуулах анги	2	12	24
Задгай орчин/орон зай			
Зөөврийн танхим			
Нийт хүчин чадал			2171
Ахлах сургуулийн хичээлийн хуваарь уян хатан байх ёстой тул хэзээ ямар анги хэрэгтэйг нарийн гаргах боломжгүй.			70%
Ахлах сургуулийн хүчин чадал			1520

Эх сурвалж: <https://www.rcasfuture.org/wp-content/uploads/2018/08/RCAS-Facilities-Master-Plan-05-Capacity-and-Utilization.pdf>

Гаргасан хүчин чадлын үзүүлэлтийг танхимаар болон шалны хэмжээгээр тооцсон ашиглалтын шалгуураар үнэлдэг.

199 Биеийн тамир гэдэг хэллэг орчин үеийн биеийн хөгжлийн хичээлд тохиолромжгүй санагдаж байна. Хүний биеийг бүх талаас нь хөгжүүлэх гэдэг утгаараа ихээхэн ач холбогдолтой агуулга багтдаг болжээ.



Хүснэгт 3.9 ХЧА-ын үнэлгээний шалгуур

Сургалтын анги, танхимаар тооцсон хүчин чадал ашиглалт хэвийн гэж үзэх түвшин		Шалны м ² -аар тооцсон хүчин чадал ашиглалтын үзүүлэлт	
Түвшин	Хүчин чадал ашиглалт	Хүчин чадал ашиглалт	Үнэлгээ
Бага сургууль	90%	125	Хэтэрсэн
Дунд сургууль	80%	100-125	Их хэрэглээ
Ахлах сургууль	70%	75-100	Хэвийн
		< 75	Хүчин чадалдаа хүрэхгүй

Эх сурвалж: <https://www.rcasfuture.org/wp-content/uploads/2018/08/RCAS-Facilities-Master-Plan-05-Capacity-and-Utilization.pdf>

Боловсролын салбарын мэдээллийн системд төрийн өмчийн сургуулиудын сургалт явуулах зориулалттай танхимын талаар дэлгэрэнгүй өгөгдөл одоогоор байхгүй эсвэл байгаа нь баталгаатай биш байна. Байгаа мэдээлэлд үндэслэн тооцвол, үндэсний хэмжээний хүчин чадал 2020-2021 оны хичээлийн жилийн эхэнд 548.8 мянган суралцагч элсүүлэх боломжтой байна. Энэ хичээлийн жилд төрийн өмчийн 672 сургуульд 632.5 мянган суралцагч элссэн тул салбарын хүчин чадал ашиглалтын коэффициент 1.15 гарна.

Хүснэгт 3.10 Салбарын хүчин чадал /2020-2021/

Өрөөний төрөл/сургалтын орон зай	Сургуульд байгаа танхимын тоо	Нэг танхимд хичээллэх суралцагчийн тоо	Хүчин чадал
Энгийн хичээлийн танхим /уламжлалт анги/	17278	30	518,340
Шинжлэх ухааны хичээлийн лаб	0	30	0
Компьютер лаб	385	0	0
Дүрслэх урлаг (Арт)		30	0
Хөгжим /Урлагийн заал/	316	30	9,480
Мэргэжлийн боловсрол /Дадлагын газар/	22	15	330
Биеийн тамирын заал	671	30	20,130
Тусад нь сургалт явуулах анги /Лингафон/	35	15	525
Задгай талбай			
Зөөврийн танхим			
Нийт хүчин чадал			548,805
2020-2021 оны хичээлийн жилийн элсэлт			632,449
Хүчин чадал ашиглалт			1.15

Барилгын онолын хүчин чадлаар биш сургалтын зориулалттай танхимаар тооцох нь илүү оновчтой байж магадгүй. Энэ аргаар хүчин чадлыг гаргахад сургалтын биет орчны талаарх захиргааны статистикийн маягтыг шинэчилж, сургалтын зориулалттай танхимын мэдээллийг цуглуулах хэрэгтэй болно.



3.1.2 Сургалтын биет орчны өнөөгийн байдлыг тодорхойлох

Сургуулийн барилгын өнөөгийн байдалд ойр ойрхон үнэлгээ хийх нь шийдвэр гаргаж буй хүмүүсийг зөв мэдээллээр хангаж, зөв бодлого хэрэгжүүлэхэд тусалдаг. Давтамж, зориулалтаар нь дараах байдлаар ангилжээ.

- Хааяа хийдэг. Тодорхой төлөвлөсөн шинэчлэлийн хүрээнд эсвэл хөрөнгө оруулалтын хэрэгцээг гаргах зорилгоор хийж болно. Тухайлбал Португал улс “сургуулийн барилгыг орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлж, үүнд ямар барилгыг хамруулахыг шийдэхдээ насжилт, одоогийн байдал, бусад хүчин зүйлийг нь авч үзсэн байна. Асуудалтай гэж үзсэн барилгын жагсаалтыг гаргаж, судалгааг цаашид үргэлжлүүлэн, зарцуулах хөрөнгөө ач холбогдлоор нь эрэмбэлэх боломжтой болжээ.²⁰⁰
- Тодорхой давтамжтай хийдэг. Ийм үнэлгээ ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд ихээхэн тустай. Тухайлбал Бельги улс засгийн газрын үйл ажиллагааны мөчлөг бүрийн төгсгөлд хийдэг. 2008 онд хийсэн судалгаагаар шаардлагатай тоног төхөөрөмж, анги танхим байгуулахад нийт сургуулийн 32 хувь нь хэт жижиг гэж гарчээ.²⁰¹
- Барилга ашиглаж эхэлсний дараа хийдэг. Энэ нь багш, сурагчдын хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тогтоож, гарч буй асуудлыг шийдэхэд чиглэсэн үнэлгээ юм.

Хэрэгцээг үнэлж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахын давуу тал нь нотолгоонд суурилсан загвар ашиглах (Evidence-Based Model)²⁰² боломж олгодог. Ингэснээр шийдэх шаардлагатай тулгамдсан асуудлыг сургалтын орчны наад захын нөхцөл бүрдсэн байх ёстой гэдэг талаас нь харж болно.²⁰³ Ерөнхий боловсролын сургалтын биет орчны өнөөгийн байдлыг үнэлэхдээ одоо байгаа сургуулийн нөхцөл байдлыг дараах рубрикийн дагуу шинжилье. Үүнд:

- Барилгын хүчин чадал, өнөөгийн нөхцөл,
- Сургалтын тоног төхөөрөмжийн хүртээмж,
- Тэгш хамруулах орчин,
- Шугам сүлжээг багтаав.

200 Blyth et.al (2012)

201 Leemans & von Ahlefeld (2013)

202 Equity and Adequacy in Ohio School Funding Justin L. Johnson, University of Toledo Randall S. Vesely, University of Toledo 2017

203 “Educational Challenge Factor”-Сүүлийн үед энэ ойлголтыг хэрэглэж асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлдэг болсон.



Хүснэгт 3.11 Сургалтын биет орчинг үнэлэх үзүүлэлт

Төрөл	Хэрэгтэй мэдээлэл	Утга/зорилго
Барилгын хүчин чадлыг үнэлэх	• Байрлал болон хүн амын нягтаршилт, прогноз • Хамран сургалтын жин • Бүлэг дүүргэлт эсвэл багшийн ачаалал • Барилгын хүчин чадал	БТХ²⁰⁴-ийн • 9.1.1.барилга байгууламж шинээр барих; • БТХ-ын 9.1.2.барилга байгууламжийг өргөтгөх.
Барилгын нөхцөлийг харах	• Одоогийн барилгад хамгийн сүүлд их завсар хийсэн хугацаа • Одоогийн барилгын ашиглалтын хугацаа • Гадна талбайд ногоон байгууламж байгаа эсэх • Одоогийн барилгын нөхцөл байдлын талаар мэргэжлийн хяналтын байгууллагын ямар нэг дүгнэлт гарсан эсэх	БТХ-ийн • 9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох; • 9.1.5. гадна талбайн тохижилт • 9.1.1.барилга байгууламж шинээр барих; • Аюулгүй байдал нь хэвийн эсэх;
Сургалтын танхим, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүртээмжийг гаргах	• Анги, танхимын талаарх мэдээлэл • Цахим хэрэглэгдэхүүний эрх, • Компьютерийн хүрэлцээ, • Интернэт холболт зэрэг дэд бүтцийн хэрэгцээг үнэлэх.	• Сургалтын цахим хэрэглэгдэхүүн, • Симуляци хийх лаб, ТТ, • Хөгжмийн студи, • STEM лаборатори, • Зургийн урлан хэрэгтэй эсэх.
Тэгш хамруулахад бэлэн эсэх	• Хамран сургах тойргийн хөгжлийн ялгаатай суралцагчдын бүртгэл, • Хөгжлийн ялгаатай, нэмэлт тусламж хэрэгтэй суралцагчдыг хамруулсан эсэх. • Тэргэнцэр явах гарц байгаа эсэх.	• Хөгжлийн ялгаатай суралцагч хүлээн авах боломж бүрдсэн эсэх.
Шугам сүлжээнд холбогдсон эсэх ²⁰⁵	• Дулаан хангамж • Цэвэр усны хангамж	• Гадаа нүхэн жорлонг бөглөх эсэх,

204 Барилгын тухай хууль

205 Барилгын тухай хуулийн () дараах тодорхойлолтод нийцэж байвал шугам сүлжээтэй гэж үзнэ. Үүнд:

- 4.1.35. “инженерийн шугам сүлжээ” гэж ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламжийг;
- 4.1.37. “төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ” гэж тодорхой талбай, эсхүл барилга байгууламжид ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны үйлчилгээ нийлүүлэх зориулалт бүхий байгууламжийг;



	• Ариутгах татуургын өнөөгийн байдлыг	• Ариутгах татуургыг шинэчлэх эсэх, • Зөөврийн усыг худаг болгох эсэх, • Ундны ус сургууль дээр байгаа эсэх, БТХ-ийн • 4.1.37, 4.1.38-д заасан сүлжээ байгаа эсэх.
--	---	---

Дээрх рубрикээр хийсэн сургалтын биет орчны үнэлгээнээс

- 1) хөрөнгө оруулалтын төсвийн үр дүнг хэмжих үзүүлэлт (сургалтын биет орчин),
- 2) өнөөдрийн байдлаар шийдвэрлэх хэрэгтэй асуудлыг (сургууль дээрх хэрэгцээг) гаргаж болно.

1) Сургалтын биет орчны үзүүлэлт (Хөрөнгө оруулалтын үр дүнг хэмжих)

Ерөнхий боловсролын хөрөнгө оруулалтын зарлагын үр дүнг дараах үзүүлэлтээр хэмжвэл сургалтын биет орчны өнөөгийн байдлыг үнэлж, хөрөнгө оруулалтыг педагогийн наад захын хэрэгцээ рүү чиглүүлэх боломжтой гэж үзлээ. Үзүүлэлтийг сонгохдоо олон улсын боловсролын хандлагыг харгалзав. Эдгээрийг тооцох аргачлалыг “Төсвийн үр дүнг хэмжих үзүүлэлт”-ээс харна уу.

Хүснэгт 3.12 ХО-ын төсвийн үр дүнг хэмжих үзүүлэлт

Хэмжих үзүүлэлт	Хэмжих нэгж/утга	Давтамж	Хэрэгтэй мэдээлэл
Орчин 1. Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо	Харьцаа	Жил бүр	• Сургалтын зориулалтаар ашиглаж буй компьютерийн тоо- ЗС Маягт БДБ18 • Элсэлт- ЗС Маягт БДБ1В
Орчин 2. Интернэтэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь	Хувь	Жил бүр	• Сургалтын орчин- ЗС Маягт БДБ18

- 4.1.38. “төвлөрсөн инженерийн шугам сүлжээ” гэж төв суурин газар, түүний тодорхой хэсэгт орших барилга байгууламжийг ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбооны төвлөрсөн эх үүсвэртэй холбох үндсэн байгууламжийг хэлнэ.




Орчин 3. Тэгш хамруулахад бэлэн байдал	Хувь	Жил бүр	Мэдээлэл сургуулиас цуглуулах, статистик маягтад багтаах.
Орчин 4. Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	Хувь	Жил бүр	- Бүлгийн тоо- ЗС Маягт БДБ1А - Ангиар хичээллэх боломжтой танхимын тоо-ЗС Маягт БДБ18
Орчин 5. Хүчин чадал ашиглалт	Кэффициент	Жил бүр	- Хичээлийн байрны хүчин чадал- ЗС Маягт БДБ18 - Элсэлт- ЗС Маягт БДБ1В

Орчны үзүүлэлтийг 2020-2021 оны хичээлийн жилээр гаргаж харья. Хичээлийн жилийн статистик найдвар муутай байх тул аймаг, дүүргийн Боловсролын газар, хэлтсийн 2022 оны төсвийн төсөлд ирүүлсэн мэдээгээр орчны үзүүлэлтийг гаргалаа.

Орчин 1. Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо


Хүүхэд бүрийн ширээн дээр компьютер байрлуулж, хичээллэх тухай ойлголт манай ерөнхий боловсролын сургуулиудад практик болж биелэхэд одоогоор хүнд байна.



Эх сурвалж: unsplash.com



Зураг 3.4 Орчин 1.Сургалтын нэг компьютерыг ашиглаж буй суралцагчдын тоо



Орчин 2. Интернэтэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь

Сургалтын зориулалттай компьютерийн 55 хувь нь улсын хэмжээнд интернэтэд холбогдсон байна. Энэ нь компьютерийн кабинетад байгаа компьютерүүд ч интернэтэд бүрэн холбогдоогүй байж болохыг харуулж байгаа юм.


Орчин 3. Тэгш хамруулахад бэлэн сургуулийн хувь

Хүнд биш хэлбэрийн хөгжлийн ялгаатай суралцагчдыг энгийн сургуульд хамруулах нь олон талын ач холбогдолтой гэж орчин үеийн боловсрол судлалд үздэг. Хамгийн эхний шаардлага нь гарц юм. Улсын хэмжээнд нийт төрийн өмчийн сургуулийн 67 орчим хувь нь одоогоор гарцтай байна.



Зураг 3.5 Орчны шалгуур үзүүлэлт 2 болон 3-ын өнөөгийн байдал /2021/

Орчин 2. Интернетэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь



Орчин 3. Тэгш хамруулахад бэлэн сургуулийн хувь




Орчин 4. Нэг ээлжээр хичээллэх боломж

Сургалтын наад захын орчин бүрдсэнийг харуулах өөр нэгэн үзүүлэлт нь суралцах тав тухтай орчин нөхцөл бүрдүүлж, хүүхэд бүрд хөгжих боломж олгож байгаа эсэх юм. Манай улсын төрийн өмчийн сургуулиуд 2 ээлжээр хичээллэж байгаа нь багшийн ч, суралцагчийн ч хөгжих боломжийг хааж байна. Улсын хэмжээнд төрийн өмчийн нийт сургуулийн 40 орчим хувь нь нэг ээлжээр хичээллэх боломжтой байна.



Зураг 3.6 Орчин 4. Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь




Орчин 5. Хүчин чадал ашиглалт

2020-2021 оны хичээлийн жилийн үзүүлэлтээр Улаанбаатарын ихэнх дүүрэг (Багахангайгаас бусад) болон Говьсүмбэр аймагт төрийн өмчийн сургуулийн барилгын хүчин чадал ихээхэн хэтэрсэн, харин Булган, Говь-алтай, Дундговь аймгууд хүчин чадалдаа хүрэхгүй ажиллаж байгаа харагдаж байна.




Зураг 3.7 Орчин 5. Хүчин чадал ашиглалт



Боловсролын салбарын мэдээллийн системд сургуулиудын оруулсан хүчин чадлын талаарх мэдээлэл алдаатай байж магадгүй байв. Иймд ачаалал ихтэй харагдаж байгаа аймгийг тодруулах зорилгоор дундаж бүлэг дүүргэлтийг харахад Сүхбаатар аймагт ачаалал ийм их хэтэрсэн байх үндэслэл харагдахгүй байна.

Зураг 3.8 Дундаж бүлэг дүүргэлт





2) Сургуулийн биет орчныг үнэлэх (Шийдвэрлэх асуудлыг тогтоох)

Нийт сургуулийн биет орчныг үнэлэхэд 1) зарим шаардлагатай мэдээлэл одоогоор дутуу, 2) зарим үзүүлэлтээр ЗГ-ын хөтөлбөр хэрэгжиж байгаа тул систем руу мэдээлэл орох хүртэл хүлээх хэрэгтэй байна.

Хүснэгт 3.13 Сургуулийн барилгын өнөөгийн байдал

Үзүүлэлтүүд	Утга/Хэмжих нэгж	Өнөөгийн байдал
Өргөтгөх шаардлагатай сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	Тоолно
Насжилт нь гүйцсэн сургуулийн барилгын тоо	Судлах асуудлын тоо	Тоолно
Их засвар хийх сургуулийн барилгын тоо	Судлах асуудлын тоо	Тоолно
Ногоон байгууламж хэрэгтэй сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	Тоолно
Цэвэр усны хангамж /Зөөврийн устай/	Судлах асуудлын тоо	ЗГ-ын хөтөлбөр хэрэгжиж байна.
Ариутгах татуургын төвлөрсөн холболт байхгүй сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	ЗГ-ын хөтөлбөр хэрэгжиж байна.

3.1.3 Жишээ: Дорноговь аймгийн ерөнхий боловсрол

Дорноговь аймгийг жишээ болгон сургалтын болон сургуулийн биет орчны үзүүлэлтийг тооцлоо. Үүний тулд эхлээд Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээрх сургуулийн насны хүн амын төлөвийг гаргана. 2020-2021 оны хичээлийн жилд сургуульд элсэх боломжтой гэж тооцсон 6-17 насны хүн ам 16.9 мянга байсан бол 2024-2025 оны хичээлийн жилд 18.6 мянга хүрч байна.

Хүснэгт 3.14 Дорноговь аймгийн сургуулийн насны хүн ам болон элсэлтийн таамаглал

Сумын нэр	2020-2021 хичээлийн жилд 6-14 настай хүн ам	2020-2021 оны хичээлийн жилд 15-17 настай хүн ам	2024-2025 хичээлийн жилд 6-14 настай хүн ам	2020-2021 оны хичээлийн жилд 15-17 настай хүн ам
Сайншанд	5138	1095	5662	1572
Айраг	619	170	715	197
Алтанширээ	201	65	229	73
Даланжаргал	524	132	588	162
Дэлгэрэх	336	70	329	117
Замын-Үүд	3763	799	4157	1141
Иххэт	365	90	367	124
Мандах	236	70	277	76
Сайхандулаан	244	59	255	81
Улаанбадрах	251	63	254	78
Хатанбулаг	509	112	498	180
Хөвсгөл	252	70	280	75
Эрдэнэ	412	91	441	138
Өргөн	368	80	400	120
Нийт	13218	2966	14452	4134



2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн 20 сургуульд 14,499 суралцагч элсэж, суурь боловсролын хамран сургалт 87.2% байв. Сургуулийн барилгын хүчин чадал ашиглалт доогуур байгаа сумдад хамран сургалт мөн доогуур байна. Энэ нь тухайн сумдын сургуулийн сургалтын чанар, боловсролын үр дүн тааруу гэж оршин суугчид нь үзэж өөр сумын эсвэл аймгийн төвийн сургуульд элсүүлдэг гэсэн үг байж болно. Тухайлбал дараах хүснэгтийн сүүлийн хоёр баганыг хамт харна уу.

Хүснэгт 3.15 Ерөнхий боловсролын үзүүлэлт, 2021 оны байдлаар

Сумын нэр	2020-2021 оны элсэлт	Төрийн өмчийн сургуулийн тоо	Сургуулиудын хүчин чадал /2020-2021/	Сургуулийн барилгын хүчин чадал ашиглалт /2020-2021/	Суурь боловсролын хамран сургалт /2020-2021/
Сайншанд	6692	5	4776	1.40	97.7%
Айраг	721	1	740	0.97	85.9%
Алтанширээ	154	1	320	0.48	67.2%
Даланжаргал	462	1	440	1.05	78.6%
Дэлгэрэх	300	1	320	0.94	91.2%
Замын-Үүд	4029	3	2888	1.40	83.0%
Иххэт	369	1	392	0.94	86.6%
Мандах	208	1	250	0.83	75.1%
Сайхандулаан	145	1	250	0.58	56.9%
Улаанбадрах	229	1	240	0.95	90.2%
Хатанбулаг	384	1	400	0.96	77.1%
Хөвсгөл	236	1	400	0.59	84.3%
Эрдэнэ	315	1	320	0.98	71.4%
Өргөн	255	1	300	0.85	63.8%
Нийт	14499	20	12036	1.20	87.2%

Барилгын хүчин чадлаар тооцвол хүчин чадал ашиглалт аймгийн хэмжээнд 1.20 байна. Харин сургалтын зориулалттай танхимаар тооцвол 2020-2021 оны хичээлийн жилд хүчин чадал ашиглалтын дундаж 0.88 болж буурч байна.




Хүснэгт 3.16 Ялгаатай аргаар тооцсон хүчин чадал ашиглалтын үзүүлэлт

Нэр	Хүчин чадал ашиглалт /барилгын анхны хүчин чадлаар/	Хүчин чадал ашиглалт /сургалтын танхимаар/	Хүчин чадал ашиглалт /хичээлийн ангиар/
Дг. Сайншанд сумын 1 дүгээр сургууль	1.72	1.36	1.13
Дг. Сайншанд сумын лаборатори 2-р сургууль	2.10	1.91	1.69
Дг. Сайншанд сумын 3 дугаар сургууль	1.15	0.83	0.94
Дг. Сайншанд сумын тавдугаар сургууль	1.52	0.79	0.70
Дг. Айраг сумын ерөнхий боловсролын сургууль	0.97	0.71	0.75
Дг. Алтанширээ сумын сургууль	0.48	0.39	0.82
Дг. Даланжаргалан сумын дунд сургууль	1.05	0.81	1.06
Дг.Дэлгэрэх сумын сургууль	0.94	0.91	1.10
Дг.Замын-үүд сумын лаборатори нэгдүгээр сургууль	1.50	1.56	1.50
Дг. Замын-үүд сумын хоёрдугаар сургууль	1.34	1.29	1.40
Дг. Сайншанд сумын Зүүнбаянгийн ЕБ-ын сургууль	0.42	0.37	0.47
Дг. Иххэт сумын сургууль	0.94	0.68	0.88
Дг. Мандах сумын сургууль	0.83	0.63	0.90
Дг. Сайхандулаан сумын сургууль	0.58	0.44	0.90
Дг. Улаанбадрах сумын сургууль	0.95	0.85	1.13
Дг. Хатанбулаг сумын сургууль	0.96	0.58	0.81
Дг. Хөвсгөл сумын сургууль	0.59	0.46	0.67
Дг. Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль	0.98	1.17	1.63
Дг. Өргөн сумын сургууль	0.85	0.50	0.56
Дг. Замын-үүд сумын гуравдугаар сургууль	1.34	1.26	1.34
Дундаж	1.2	0.88	1.02

2024-2025 оны хичээлийн жил гэхэд хамран сургалтыг 98%-д хүргэж чадвал Замын-үүд, Сайншанд, Даланжаргал, Эрдэнэ, Өргөн сумд хүндэрч магадгүй.



Зураг 3.9 Дорноговь аймгийн сургуулийн насны хүн ам болон элсэлтийн таамаглал



2019-2021 шилжих барилгын жагсаалт дээр 320 суудалтай 1 сургууль байна. Гэхдээ хаана барьж байгааг нь мэдээгүй тул оруулж чадсангүй. 2024-2025 оны хичээлийн жилд хүчин чадал ашиглалт

$$17,675 / (12,036 + 320) = 1.43$$

гарч байна. Гэхдээ сургалтын танхимаар тооцвол $17,675 / 15,135 = 1.18$

Тус аймагт дунд хугацааны боловсролын төлөвлөлт хийхдээ


- 1) хамран сургалтыг эрс нэмэгдүүлэх,
- 2) хүчин чадал ашиглалтыг эхлээд жигд болгох (хамран сургалт доогуур хэр нь, хүчин чадал ашиглалт бага байгаа сургуулиуд дээр анхаарч эхлэх),
- 3) сумдаас аймгийн төвд эсвэл Замын-үүдэд ирж суралцаж буй шалтгааныг тогтоох (аймгийн төвийн сургуулийн чанар илүү гэдэг таамаглал байх магадлалтай, гэхдээ бодит байдал тийм биш байж болно. Жишээ нь Зураг 3.10-аас 2022 оны төсвийн төсөлд ирүүлсэн үр дүнгийн үзүүлэлтийг харна уу)



- 4) зарим сумын сургуулийг (жишээ нь Хөвсгөл, Сайхандулаан, Алтанширээ, Өргөн) магнет буюу төрөлжсөн гүнзгийрүүлсэн, эсвэл олон улсын хөтөлбөртэй болгох, эсвэл дахин зохион байгуулах хэрэгтэй.²⁰⁶ Мөн зарим ахлах сургуулийг сайжруулах, төрөлжсөн ахлах сургууль нэмж байгуулах замаар Замын үүд, Сайншандын ачааллыг бууруулах боломжтой байна.

Зураг 3.10 Математикийн хичээлийн суурь чадвар эзэмшсэн байдлын тархалт /9-р анги/

Дүнд 1. Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн суралцагчдын хувь Дүнд 1. Унших суурь чадвар эзэмшсэн 9-р ангийн суалцагчдын хувь



206 Сургууль сайжруулах төсөл хэрэгжүүлэх (School improvement project) эсвэл ямар нэг хүлээн зөвшөөрөгдсөн сайн сургуультай кластер болгон ажиллуулах зэрэг хэд хэдэн бодлогын арга хэмжээ авч болохыг 1-р бүлгээс уншина уу.



Зураг 3.11 ЕШ-ын хэмжээст онооны дундаж /2019-2020/



Боловсролын төлөвлөлтийг оновчтой болгож, хөрөнгө оруулалт хийснээр дунд хугацаанд хүрэх үр дүнг (outcome) бодитой болгоно. Хөрөнгө оруулалтын төсвийн үр дүнг 2022-2024 онуудад хэрхэн ахиулж, 2025 онд ямар түвшинд хүргэхээ 2022 оны төсвийн саналд тусгах боломжтой.

Хүснэгт 3.17 ДГ-аймгийн ХО-ын үр дүнг хэмжих үзүүлэлт

Байгууллагын нэр	Орчин 1. Нэг компьютерийг хэрэглэж буй суралцагчийн тоо	Орчин 3. Тэгш хамруулахад бэлэн байдал	Орчин 4. Нэг ээлжээр хичээллэх боломж	Орчин 5. Хүчин чадал ашиглалт
Дг. Сайншанд сумын 1 дүгээр сургууль	58	Тийм	Боломжгүй	1.72
Дг. Сайншанд сумын лаборатори хоёрдугаар	27	Үгүй	Боломжгүй	2.10
Дг. Сайншанд сумын 3 дугаар сургууль	30	Тийм	Нэг ээлж	1.15
Дг. Сайншанд сумын тавдугаар сургууль	31	Тийм	Нэг ээлж	1.52
Дг. Айраг сумын сургууль	14	Тийм	Нэг ээлж	0.97
Дг. Алтанширээ сумын сургууль	9	Үгүй	Нэг ээлж	0.48
Дг. Даланжаргалан сумын дунд сургууль	51	Тийм	Боломжгүй	1.05
Дг.Дэлгэрэх сумын сургууль	10	Тийм	Нэг ээлж	0.94
Дг.Замын-үүд сумын лаборатори нэгдүгээр су	27	Тийм	Боломжгүй	1.50
Дг. Замын-үүд сумын хоёрдугаар сургууль	17	Тийм	Боломжгүй	1.34
Дг. Сайншанд сумын Зүүнбаянгийн сургууль	11	Тийм	Нэг ээлж	0.42
Дг. Иххэт сумын сургууль	23	Тийм	Нэг ээлж	0.94
Дг. Мандах сумын сургууль	8	Үгүй	Нэг ээлж	0.83
Дг. Сайхандулаан сумын сургууль	48	Тийм	Нэг ээлж	0.58
Дг. Улаанбадрах сумын сургууль	10	Тийм	Боломжгүй	0.95
Дг. Хатанбулаг сумын сургууль	20	Үгүй	Нэг ээлж	0.96
Дг. Хөвсгөл сумын сургууль	9	Тийм	Нэг ээлж	0.59
Дг. Эрдэнэ сумын сургууль	14	Тийм	Боломжгүй	0.98
Дг. Өргөн сумын сургууль	17	Тийм	Нэг ээлж	0.85
Дг. Замын-үүд сумын гуравдугаар сургууль	38	Тийм	Боломжгүй	1.34

Өнөөдрийн байдлаар өргөтгөх шаардлагатай сургууль байгаа эсэхийг харлаа. Одоогийн ээлжээр тооцоход хүчин чадал ашиглалтын дээд хэмжээ нь хэтэрсэн 1 сургууль, нэг ээлжээр хичээллэх боломжтой 12 сургууль, 2-р ээлж нь хүндэрсэн 1 сургууль байна. 2-р ээлж хүндэрсэн эсэхийг тооцохдоо 1) нийт бүлгийн 40-өөс дээш хувь нь 2-р ээлжээр хичээллэж байгаа, 2) бүлэг дүүргэлт нь 30-аас дээш байгаа эсэхийг тооцож, эдгээр нөхцөл бүгд биелж байвал "БТХ-ийн 9.1.2 буюу өргөтгөх шаардлага биелсэн" гэж үзлээ.



Хүснэгт 3.19 Өргөтгөх шаардлагатай сургуулийн мэдээлэл

#	Байгууллагын нэр	Хучин чадал ашиглалтын дээд хэмжээ	1 ээлжээр хичээллэх боломж	2-р ээлж хүндэрсэн эсэх	Өргөтгөх шаардлагатай эсэх
1	Сайншанд сумын 1 дүгээр сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
2	Сайншанд сумын лаборатори 2-р сургууль	Хэтэрсэн	Боломжгүй	Хүндэрсэн	9.1.2
3	Сайншанд сумын 3-р сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
4	Сайншанд сумын тавдугаар сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
5	Айраг сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
6	Алтанширээ сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
7	Даланжаргалан сумын дунд сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
8	Дэлгэрэх сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
9	Замын-үүд сумын лаборатори 1-р сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
10	Замын-үүд сумын 2-р сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
11	Сайншанд сумын Зүүнбаянгийн ЕБ-ын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
12	Иххэт сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
13	Мандах сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
14	Сайхандулаан сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
15	Улаанбадрах сумын сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
16	Хатанбулаг сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
17	Хөвсгөл сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
18	Эрдэнэ сумын сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
19	Өргөн сумын сургууль	Хэвийн	Нэг ээлж	Хэвийн	Хэвийн
20	Замын-үүд сумын 3-сургууль	Хэвийн	Боломжгүй	Хэвийн	Хэвийн
Аймгийн хэмжээнд		<u>1</u>	<u>12</u>	<u>1</u>	<u>1</u>



Хүснэгт 3.20 Судлах, шийдвэрлэх асуудал

Хэмжих үзүүлэлт	Утга/хэмжих нэгж	Өнөөгийн байдал /2021/
БТХ-ийн 9.1.2.барилга байгууламжийг өргөтгөх шаардлагатай сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	1
Насжилт нь гүйцсэн сургуулийн барилгын тоо	Судлах асуудлын тоо	3
Их засвар хийх сургуулийн барилгын тоо	Судлах асуудлын тоо	6
Ногоон байгууламж хэрэгтэй сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	17
Цэвэр усны хангамж /Зөөврийн ус/	Судлах асуудлын тоо	9
Ариутгах татуургын төвлөрсөн холболт байхгүй сургуулийн тоо	Судлах асуудлын тоо	9

Хүснэгт 3.21 Сургуулийн биет орчныг үнэлэх үзүүлэлт

Байгууллагын нэр	Дулаан хангамж	Цэвэр усны хангамж	Ариутгах татуурга	Барилгын насжилт	Их засвар хийх эсэх	Гадна тохижилт хийх эсэх
Дг. Сайншанд сумын 1 дүгээр сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Сайншанд сумын лаборатори хоёрдугаар	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Сайншанд сумын 3 дугаар сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Дууссан	-	-
Дг. Сайншанд сумын тавдугаар сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Айраг сумын сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Алтанширээ сумын сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Даланжаргалан сумын дунд сургууль	4.1.37	Худаг	Байхгүй	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг.Дэлгэрэх сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг.Замын-үүд сумын лаборатори нэгдүгээр су	4.1.38	4.1.38	4.1.38	Дууссан	-	-
Дг. Замын-үүд сумын хоёрдугаар сургууль	4.1.38	Зөөврийн	4.1.37	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Сайншанд сумын Зүүнбаянгийн сургууль	4.1.38	4.1.38	4.1.38	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Иххэт сумын сургууль	4.1.38	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Мандах сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Сайхандулаан сумын сургууль	4.1.38	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Улаанбадрах сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Хатанбулаг сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Хөвсгөл сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Дууссан	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Эрдэнэ сумын сургууль	4.1.37	4.1.37	4.1.37	Хэвийн	Их засвар	Ногоон байгууламж
Дг. Өргөн сумын сургууль	4.1.37	Зөөврийн	Байхгүй	Хэвийн	Хэвийн	Ногоон байгууламж
Дг. Замын-үүд сумын гуравдугаар сургууль	4.1.38	4.1.38	4.1.38			



3.1.4 Дотуур байрны үйлчилгээ

Дотуур байрны үйлчилгээний бүх арга хэмжээ, түүнд хэрэгтэй төсвийг (урсгал болон хөрөнгийн) сургуулийн төсвөөс бие даасан байдлаар хийж, төсвийн зарлагын үр дүнг хэмждэг байх нь чухал. Хөрөнгө оруулалт хийх хэрэгцээг гаргахын тулд дараах рубрикээр байдал ямар байгааг үнэлье.

Хүснэгт 3.22 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт

Хэмжих үзүүлэлт	Хэмжих нэгж/утга	Давтамж	Хэрэгтэй мэдээлэл
ДБ 1. Дотуур байрны хүртээмж	Харьцаа	Жил бүр	- Ашиглалт: - Дотуур байрны хүчин чадал /ороор/-ЗС Маягт БДБ6А - Дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо-ЗС Маягт БДБ6А - Хангамж: - Дотуур байранд суух хүсэлт гаргасан хүний тоо-ЗС Маягт БДБ6А - Дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо-ЗС Маягт БДБ6А
ДБ 2. Дотуур байрны өрөөний боломж	Хувь	Жил бүр	- Суугч хүлээн авах өрөөний тоо- ЗС Маягт БДБ6А - Дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо-ЗС Маягт БДБ6А
ДБ 3. Интернет холболттой дотуур байрны тоо	Хувь	Жил бүр	- Дотуур байрны тоо-ЗС Маягт БДБ6А - Интернэтэд холбогдсон дотуур байрны тоо ЗС Маягт БДБ6А

Дээрх үзүүлэлтийг нийт 540 дотуур байраар гаргасныг Хавсралт 2-оос харна уу. Нэгтгэлийг доор харуулав.



Хүснэгт 3.23 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт

Аймаг_нийслэл	Дотуур байр 1: Хүртээмж	Дотуур байр 2: Өрөөний боломж	Дотуур байр 3. Интернетэд холбогдсон дотуур байрны ХУВЬ
Архангай	-	Судлах	21.9%
Баян-Өлгий	Судлах	Судлах	19.1%
Баянхонгор	-	-	35.7%
Булган	-	Судлах	42.9%
Говь-Алтай	-	-	13.8%
Дорноговь	-	-	56.3%
Дорнод	-	Судлах	9.1%
Дундговь	-	-	55.6%
Завхан	-	Судлах	30.8%
Өвөрхангай	-	-	31.4%
Өмнөговь	-	-	85.0%
Сүхбаатар	Судлах	Судлах	18.8%
Сэлэнгэ	-	-	81.0%
Төв	-	Судлах	40.0%
Увс	-	Судлах	35.9%
Ховд	-	Судлах	33.3%
Хөвсгөл	-	Судлах	17.4%
Хэнтий	-	Судлах	22.2%
Дархан-Уул	-	Судлах	66.7%
Улаанбаатар	-	Судлах	75.0%
Орхон	-	-	100.0%
Говьсүмбэр	-	Судлах	33.3%
Дүн	2	14	34.9%

Баян-өлгий аймагт 2020-2021 оны хичээлийн жилийн мэдээгээр нийт 47 дотуур байр байгаа ч хүсэлт гаргасан нийт 4843 суралцагчийн 4207 буюу 87 орчим хувийг байранд авчээ. Аймгийн хэмжээнд хүчин чадал ашиглалт бага зэрэг хэтэрсэн байгааг шалгав. Дотуур байр нэг бүрээр судалж үзвэл ийм хэрэгцээ үүсээгүй байна. Сүхбаатар аймгийн хувьд боловсролын салбарын мэдээллийн системд зарим сумын дотуур байрны хүчин чадлыг хоосон орхисон байв. Тус аймагт хүртээмжийн асуудал байхгүй харагдаж байна. Хавсралт 2-оос харна уу.

2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар хүчин чадал ашиглалт улсын хэмжээнд 73%, хүсэлт гаргасан нийт суралцагчдын 92%-ийг хамруулсан байна. Хүчин чадал нэмэх зорилгоор дотуур байр нэмж барих хэрэгцээ харагдахгүй байна Харин дотуур байранд тулгамдаж буй асуудал нь 1) өрөөний боломж, тав тух, 2) суралцах боломж (интернэт) гэж үзэж болохоор байна.



Хүснэгт 3.24 Дотуур байрны өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлт /2020-2021/

Аймаг_нийслэл	Дотуур байранд суух хүсэлт гаргасан хүүхдийн тоо	Дотуур байрны барилгын нийт хүчин чадал	Амьдарч буй хүний тоо	Ашиглалт	Хангамж
Архангай	2443	2540	2343	0.922	0.96
Баян-Өлгий	4843	3838	4203	1.095	0.87
Баянхонгор	1746	2535	1690	0.667	0.97
Булган	1949	1877	1820	0.970	0.93
Говь-Алтай	1258	2602	1258	0.483	1.00
Дорноговь	771	1115	749	0.672	0.97
Дорнод	1142	1721	1084	0.630	0.95
Дундговь	818	1525	791	0.519	0.97
Завхан	1500	2047	1396	0.682	0.93
Өвөрхангай	2024	3096	1863	0.602	0.92
Өмнөговь	880	2233	831	0.372	0.94
Сүхбаатар	955	843	947	1.123	0.99
Сэлэнгэ	1303	1518	1249	0.823	0.96
Төв	2461	3823	2301	0.602	0.93
Увс	3311	3375	3026	0.897	0.91
Ховд	2105	2305	1916	0.831	0.91
Хөвсгөл	4008	4222	3599	0.852	0.90
Хэнтий	1919	2330	1470	0.631	0.77
Дархан-Уул	448	571	407	0.713	0.91
Улаанбаатар	1104	2132	1016	0.477	0.92
Орхон	108	220	105	0.477	0.97
Говьсүмбэр	162	195	141	0.723	0.87
Дүн	37,258	46,663	34,205	0.733	0.92

Бусад улс сургуулийн дотуур байрыг гэртээ байгаа мэт тухлаг (dorm-house) дизайнтай барьж, нэг өрөөнд 2 суралцагч байхаар төлөвлөж, байх ёстой тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн жагсаалт, эрүүл ахуй, дуу чимээ, гэрэл, агаарын шаардлагыг баталдаг.²⁰⁷

207 <https://citiesandschools.berkeley.edu/school-facilities>



Эх сурвалж: https://www.archdaily.com/458329/k-botici-student-s-home-schindler-seko/52ac812fe8e44e0f370000c1_k-boti-i-student-s-home-schindler-seko_k_botici_18_prw-jpg

Дээрх шаардлагыг хангах гол үзүүлэлт нь өрөөний боломж юм. Нэг өрөөнд 4 хүн байхаар тооцоход ч манай улсын дотуур байрууд шаардлага хангахгүй байна. Өрөөний боломжийг нэг өрөөнд 4 болон түүнээс цөөн хүүхэд суухаар тооцоход нийт 12 аймгийн дотуур байруудад ийм боломж бага харагдаж байна. Үүнийг дотуур байр нэг бүрээр гаргасныг Хавсралт 2-оос харна уу.

Дотуур байрны хөрөнгө оруулалтыг хэмжих дараагийн үзүүлэлт нь интернэтийн холболт юм. Нийт төрийн өмчийн 540 сургуулийн дотуур байрны 185 нь 2020-2021 оны хичээлийн жилийн мэдээгээр интернетэй гэж бүртгүүлжээ.

Дотуур байрны барилгын өнөөгийн байдлыг дараах үзүүлэлтээр хэмжиж болно. Үүнд:

- Насжилт нь гүйцсэн дотуур байрны барилгын тоо
- Их засвар хийх дотуур байрны барилгын тоо
- Цэвэр усны хангамж /Зөөврийн ус/
- Ариутгах татуургын төвлөрсөн холболт байхгүй дотуур байрны тоо

Жишээг Дорноговь аймгаас харна уу.



3.2 Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсролыг дараах алхмаар төлөвлөх санал боловсрууллаа.
Үүнд:

- 1) Эрэлт, нийлүүлэлтийг гаргах – 2) Өнөөгийн байдлыг тогтоох =
- 3) Хөрөнгө оруулалтыг төлөвлөх

3.2.1 Эрэлт, нийлүүлэлтийг таамаглах

Эрэлтийг гаргахдаа эхлээд дунд хугацаанд ямар бодлогын зорилт дэвшүүлж, ямар үр дүнд хүрэхээр төлөвлөснийг харна. Дараа нь үйлчилгээ хүртэх хүн амыг тооцож, эндээс хүчин чадал нэмэх хэрэгтэй эсэхийг гаргая.

Хүрэх үр дүн: Дунд хугацаанд Алсын хараа 2050-д зааснаар “2.Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна.”

Хүрэх үр дүнгийн шалгуур: Алсын хараа 2050 болон “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн шалгуураас сургуулийн өмнөх боловсролын хэрэгцээг харъя.

Хүснэгт 3.25 Үндэсний түвшинд хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Зорилт
9	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	81.5	89.4	9.7 функтээр өсгөх
10	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь	90.1	100.0	9 функтээр өсгөх
13	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	тоо	34.1	25	9 функтээр бууруулах
15	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр)	тоо	33	25-30	3-8 функтээр бууруулах


Эх сурвалж: Эхний 5 баганыг Монгол улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаас авав.

Зарим аймгийн хамран сургалт аль хэдийн 90%-д хүрсэн тул салбарын хүрэх түвшнээс өндөр байна. Намрын элсэлтээр гаргаж буй хамран сургалтыг жилийн турш хадгалж “бодит хамрагдалтын хувь” (Participation rate) болгох нь чухал. 2025 онд хүргэхээр төлөвлөсөн хамран сургалтыг 2018-2019 оны хичээлийн жилийн хамран сургалттай харьцуулав. Эндээс харахад Улаанбаатар хот болон Баян-өлгий,



Булган, Дундговь, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Архангай аймаг хамран сургалтаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.²⁰⁸

Зураг 3.12 Хамран сургалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ



“Монгол Улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” нь төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсөвт сууж хэрэгждэг. Энд багтсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулна.

208 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтээр тооцох боломжгүй.




Хүснэгт 3.26 СӨБ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	2025 он хүртэл
2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ:	
2.3.9.1.273 цэцэрлэг ашиглалтад оруулах;	273
2.3.9.3.тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх;	2 ²⁰⁹
2.3.9.4.жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	x
2.3.11.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.	x ²¹⁰

ҮСХ-ноос 2017 онд гаргасан “Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо”-ноос цэцэрлэгийн насны хүн ам 2030 он хүртэл тогтонги байхаар харагдаж байна.

Зураг 3.13 Цэцэрлэгийн насны тооцсон хүн амын төлөв



Эх сурвалж: Тооцооллыг 1212мн-ээс 2020 оны 12 сарын 05-ны өдөр татав.

209 Тусгай цэцэрлэг одоогоор 2 бий.

210 Цэцэрлэгийн хувьд хөгжмийн зэмсэг, дуу тусгаарлагч, дасгал хөдөлгөөн хийх материалын хөрөнгө оруулалт хэрэгтэй.



Хүснэгт 3.27 Цэцэрлэгийн насны тооцоолсон хүн ам

Нас	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2030
2	81,968.	82,591.	82,580.	82,409.	82,088.	81,639.	80,193.	79,769.
3	81,123.	81,844.	82,471.	82,466.	82,299.	81,984.	80,650.	79,554.
4	81,477.	81,030.	81,754.	82,385.	82,382.	82,220.	81,055.	79,591.
5	76,504.	81,410.	80,966.	81,692.	82,325.	82,324.	81,375.	79,849.
Нийт	321,072.	326,875.	327,771.	328,952.	329,094.	328,167.	323,273.	318,763.
		1.02	1.00	1.00	1.00	1.00	0.99	0.99

Эх сурвалж: 1212тп-ээс 2020 оны 12 сарын 05-ны өдөр татав.

СӨБ-д хамрагдах хүн амыг ҮСХ-ны 2020 оны хүн амын тооноос гаргая. Үүний тулд эхлээд 0-5 настай хүн амыг ялгаж, цэцэрлэгийн насны хүн амыг дараах хоёр түвшинд тооцлоо. Үүнд:

- **2-5 настай хүн амаар**- 2020-2021, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд элсэх 2-5 настай хүн амын тоог гаргаж, 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилд элсэх хүн амыг жилийн дундаж өсөлтийн хувиар өсгөв.211
- **3-5 настай хүн амаар**- 2023-2024, 2034-2025 оны хичээлийн жилд элсэх 3-5 настай хүн амын тоог гаргаж, 2022-2023, 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилд элсэх хүн амыг жилийн дундаж өсөлтийн хувиар өсгөв.

2020 оны хүн амын тоонд үндэслэн тооцвол 2024-2025 оны хичээлийн жилд 2-5 настай 317.5 мянга, 3-5 настай 235.4 мянган хүүхэд СӨБ-д элсэх боломжтой байна. Сум, дүүргээр гаргасан тооцооллыг Хавсралт 3-аас харна уу.

Хүснэгт 3.28 Цэцэрлэгийн насны хүн амын таамаглал

Аймаг/Нийслэл	2020-2021 оны хичээлийн жилд 2-5 настай хүн ам	2024-2025 хичээлийн жилд 2-5 настай байх хүн ам /таамаглал/	2024-2025 хичээлийн жилд 3-5 настай байх хүн ам /таамаглал/
Архангай	8,529	8,574	6383
Баян-Өлгий	11,004	12,029	8998
Баянхонгор	8,226	8,982	6806
Булган	5,127	5,157	3866
Говь-Алтай	4,824	5,358	4147
Говьсүмбэр	1,830	1,864	1394
Дархан-Уул	9,436	9,585	7268
Дорноговь	6,525	6,442	4860
Дорнод	8,080	8,258	6220
Дундговь	4,306	4,574	3509
Завхан	6,219	6,399	4909



Орхон	9,599	9,795	7363
Өвөрхангай	10,484	10,822	8212
Өмнөговь	6,869	7,419	5761
Сүхбаатар	6,067	6,480	4877
Сэлэнгэ	9,220	9,453	7230
Төв	8,427	8,313	6248
Увс	8,104	8,408	6273
Улаанбаатар	147,423	150,624	109254
Ховд	8,649	9,368	7072
Хөвсгөл	11,978	12,276	9219
Хэнтий	7,125	7,295	5513
Нийт	308,051	317,475	235,382

2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилүүдэд төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтад 200.0 гаруй мянган хүүхэд хамрагдаж байв. Таамаглал хийхэд дараах хоёр хязгаарлалт гарлаа. Үүнд 1) 2020-2021 оны хичээлийн жилийн үзүүлэлт нь цаашдын таамаглалд хэрэглэхэд тохиромж муутай мэдээлэл боловч аль болох сүүлийн үзүүлэлтээр өнөөгийн байдлыг шинжлэх хэрэгтэй гэж үзэж сонгов. 2) Боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан цэцэрлэгийн хүчин чадлын өгөгдөл алдаа ихтэй байна.

2020-2021 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтад 194.6 мянган хүүхэд элсэж, хамран сургалт 63.2%, төрийн бус цэцэрлэгийн хамран сургалтад оруулах хувь нэмэр 11.5%, буюу салбарын хувьд хамран сургалт 74.7% болж буурчээ. 2020-2021 хичээлийн жилийн хүчин чадал ашиглалтын үзүүлэлт²¹² = $\text{Элсэлт} / (\text{Хүчин чадал}) = 194,614 / 141,282 = 1.38$



212 Өмнөх жилүүдэд төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхэд-өдрийн гүйцэтгэл орчим хувь байсан бөгөөд хүчин чадал ашиглалтын талаар хэт өөдрөг биш тооцоолол хийхийн тулд 2020-2021 онд хүүхэд-өдрийн гүйцэтгэлийг 80% гэж үзвэл хүчин чадал ашиглалтын дундаж 1-ээс бага болж байна. Цаашид жилийн турш хамрагдсан хүүхдийг гаргахдаа анх элссэн хүүхдийн тоогоор биш, хүүхэд-өдрийн гүйцэтгэл (participation rate) ашиглаж хэвших нь илүү оновчтой байх болно.



Хүснэгт 3.29 Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын үзүүлэлт

Аймаг_нийслэл	Төрийн өмчийн цэцэрлэг	Төрийн бус өмчийн цэцэрлэг	Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын элсэлт /2020-2021/	Төрийн өмчийн цэцэрлэгийн хүчин чадал ашиглалт /2020-2021/	Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын хамран сургалт /2020-2021/
Архангай	35	1	5577	1.19	65.4
Баян-Өлгий	44	6	6332	1.26	57.5
Баянхонгор	36	7	5373	1.27	65.3
Булган	22	0	3233	1.20	63.1
Говь-Алтай	30		3464	1.14	71.8
Говьсүмбэр	6	4	1340	1.64	73.2
Дархан-Уул	29	9	7236	1.17	76.7
Дорноговь	33	3	4471	1.09	68.5
Дорнод	31	5	6249	1.24	77.3
Дундговь	22	0	2923	1.16	67.9
Завхан	38	3	4766	1.28	76.6
Орхон	30	8	7782	1.20	81.1
Өвөрхангай	42	5	6530	1.45	62.3
Өмнөговь	29		5074	1.13	73.9
Сүхбаатар	24		4449	1.48	73.3
Сэлэнгэ	38	3	6674	1.25	72.4
Төв	42	5	5570	1.29	66.1
Увс	30	4	5272	1.67	65.1
Улаанбаатар	278	423	84076	1.56	57.0
Ховд	33	10	5558	1.51	64.3
Хөвсгөл	42	8	7572	1.31	63.2
Хэнтий	34	2	5094	1.15	71.5
Дүн	948	506	194,615	1.38	63.2

